

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

СЭДЭВ: “НИЙСЛЭЛИЙН 2024-2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ”

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

Та сонсголын тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС
2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/ ЗОХИОН
БАЙГУУЛСАН “НИЙСЛЭЛИЙН 2024-2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ
ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ” СЭДЭВТ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН
СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 27 минутад Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал даргалав.

Ерөнхий хяналтын сонсгол явуулсан сэдэв:

“Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал”

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ерөнхий хяналтын сонсголд оролцогч Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн сонсгол Төсвийн байнгын хорооны ирцээр эхлэх ёстой. Ирц 53,3% хүрсэн тул сонсголын үйл ажиллагаа эхэллээ. Сонсголд оролцохоор хүрэлцэн ирсэн Байнгын хороодын гишүүдийг Та бүхэнд танилцуулъя.

УИХ-ын гишүүн Норовын Алтанхуяг, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Чинбатын Номин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Тилиханы Аубакир, Жамбын Батсуурь, Пүрэвжавын Ганзориг, Баатаржавын Мөнхсоёл, Ганзоригийн Тэмүүлэн, Ренчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормaa, Хассуурийн Ганхуяг, Нанзадын Наранбаатар, Даваагийн Цогтбаатар гишүүд ирсэн байна. Мөн ажлын хэсгийн гишүүдээс Наранцэцэгийн Алтаншагай, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Дуламын Бум-Очир нарын гишүүд ирсэн байна.

Сонсголын ирцийг танилцуулж дууслаа. Өнөөдрийн сонсголд УИХ-ын гишүүдээс гадна ажиглагчаар нэг иргэн, холбогдох төрийн байгууллагын төлөөллөөр 61, Төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэн 17 оролцогч оролцож байгаа. Нийт бүртгүүлсэн оролцогчдыг 6 дугаар сарын 15 болон 16-ны өдөр 2 хувааж оролцуулахаар зохион байгуулсан.

Ингээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос зохион байгуулж байгаа “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдэвт Ерөнхий хяналтын 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн сонсгол нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу МҮОНРТ болон парламентын шууд дамжуулах суваг ажиллаж байгааг мэдэгдье.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн

124 дүгээр зүйлийн 124.4-т “хэл яриа сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.” гэж заасны дагуу хэл яриа сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах сонсголд оролцох, ажиглах боломжийг хангах зорилгоор өнөөдрийн сонсголыг МҮОНРТ-ээр дохионы хэлмэрчтэй шууд дамжуулж байна.

УИХ-аас зохион байгуулж байгаа хяналтын сонсгол нь зөвхөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмаар явагддаг болохыг сонсгол эхлэхийн өмнө онцгойлон анхааруулж байна. Иймээс өнөөдрийн сонсголд оролцож байгаа Та бүхэн зөвхөн хуульд заасан дэг журмыг сахин оролцохыг хүсье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-т “хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч гишүүн бусад оролцогчоос асуулт асуухгүй” гэж заасан бөгөөд мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан сонсголд оролцогчийн эрх үүргийг Та бүхэнд уншиж танилцуулъя. 124.1 Сонсголд оролцогч дараах эрхийг эдэлнэ, 124.1.1-д “Энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу асуултад хариулах тайлбар санал хэлэх 124.1.2 Сонсголын тэмдэглэл гарсан шийдвэртэй танилцах Өөрийн хэлсэн санал тайлбарыг хянах 124.1.3 Сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй хүндэтгэлтэй хандахыг шаардах, 124.2 Сонсголд оролцогч дараах үүрэг хүлээнэ. 124.2.1 Сонсгол зохион байгуулагчийн дурдсанаар сонсголд хүрэлцэн ирэх, 124.2.2 сонсголын дэг сахих, 124.2.3 Сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлыг биелүүлэх, 124.2.4 сонсголд үнэн зөв мэдээлэх, бодитой дүгнэлт өгөх, 124.2.5 холбогдох, бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх гэж тус тус заажээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.24-т Улсын Их Хурлын хяналтын сонсгол болон хяналт шалгах түр хорооны сонсголд оролцож байгаа этгээд үнэн зөв бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэг хүлээнэ гэж заасан 21.26-д энэ хуулийн 21.24-т заасан холбогдох албан тушаалтан худал мэдээлэл өгсөн, танилцуулсан гэж үзвэл гишүүн хуралдаан даргалагчид санал гаргаснаар Улсын Их Хурлын Тамгын газар, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн Үндэсний комисс, Үндэсний статистикийн хороо, Төрийн албан зөвлөл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн мэдээллийн үнэн зөв бодит эсэхийг ажлын 5 өдрийн дотор хянаж дүгнэлт гаргана 21.28-д Улсын Их Хурлын хяналтын сонсголд худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг нуун дарагдуулсан улс төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлыг нам, эвслийн бүлэг, эсвэл 20-оос доошгүй гишүүн гарын үсэг зурсан бол энэ хуулийн 30.1.11-д зааснаар холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ 21.30-д Улсын Их Хурлын хяналтын сонсголд худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан нийтийн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 32.8-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ. Энэ хуулийн 21.31-д хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй тайлбар өгөхөөс татгалзсан. Хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д энэ хуулийн холбогдох зүйл хэсэг заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй нь Улсын Их Хурлын хяналт шалгалтыг тасалдуулсан бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.25-д заасан парламентыг үл хүндэтгэх үйлдэл гэж үзэн төрийн албаны тухай хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ 57.6-т

шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна 57.7-т шинжээч, сонсголд оролцогч, ажиглагч бусад хүн сонсголын дэг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ 57.9-д холбогдох албан тушаалтан энэ хуульд заасан сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол холбогдох тайлбар мэдээлэл өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлагыг оногдуулна.

Одоо та бүхэнд сонсгол даргалагчийн эрх үүргийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлд заасны дагуу сонсгол даргалагч нь сонсголын явцад асуулт хариулт өгөх дарааллыг тогтоох бөгөөд тайлбар, санал мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох, сонсголын дэг зөрчсөн, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргасан оролцогчид сануулга зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах.

Сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх, сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах хүртэл арга хэмжээ авах эрхтэй байна. Сонсгол хийх үндэслэл зорилгын талаар Та бүхэнд товчхон танилцуулъя. Хүмүүс энэ мэдээллийг сонсохыг хүссэн. Тэгэхээр хүмүүс сонсохыг хүсэх нь бол хангалттай шалтгаан мөн юм. Монгол Улсын үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд төр, түүний байгууллагаас хууль, ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх хүлээн авах эрх бол Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх эрхийн нэг билээ. Энэ эрхийг хэрэгжүүлэх үүднээс нөгөөтээгүүр Монгол Улсын Их Хурал нь хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах эрхийнхээ хүрээнд энэхүү сонсголыг зохион байгуулж байна. Тэгээд Монгол Улсын төрийн байгуулалт бол нэгдмэл зарчимтай байдаг. Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах нь бидний энэ иргэний ардчилсан нийгэм байгуулж байгаа төрийн байгуулалтын бол гол үндэс суурь юм. Тэгээд энэ үүднээсээ улсын төсөв нийслэлийн төсөв эдгээр их том дүнтэй төслүүдийн уялдаа холбоо ямар байх нь цаанаа улсын төсвийн ачаалалд, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, хүрсэн үр дүн тоо нь маш их том дүнтэй байгаа учраас анхаарал хандуулах зүйлс байгаа.

Иймд иргэдийн гаргасан хүсэлт, олон мянган хүний цахим платформоор гаргасан өргөдөлд тулгуурлаад мэдэх эрхийг нь хангах, нөгөө талдаа Улсын Их Хурлын хууль тогтоомжийн хэрэгжилт, улсын эдийн засаг, төсвийн тогтвортой байдалд анхаарал хандуулах нь бол зүй ёсны хэрэг. Ийм болохоор УИХ-ын гишүүд санаачлаад 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр 25 гишүүн гарын үсэг зурж улмаар Төсвийн байнгын хороогоор авч хэлэлцээд Ажлын хэсэг байгуулсан. Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах ажлын хэсэгт УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, Д.Бум-Очир, Н.Алтаншагай, П.Сайнзориг, Б.Заяабал, Дав.Цогтбаатар, Ч.Лодойсамбуу, Ж.Баярмаа, Р.Батболд, Ж.Золжаргал гэсэн 11 гишүүн ажиллаж мэргэжлийн шинжээчид томилон богино хугацаанд бэлтгэлийг хангаж ажиллалаа.

Сонсголоор мэдээлэл сонсох, цуглуулах, төрийн болон ТББ иргэдийн мэдэх эрхийг хангаж саналыг сонсож, шийдвэр гаргах түвшиндээ нэгдсэн нэг ойлголттой болох төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах асуудлаар Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх түүнчлэн хууль эрх зүйн орчинд анхаарал хандуулах засаж сайжруулах ямар асуудлууд байгаа талаар санал, дүгнэлт хэлэлцэх,

шаардлагатай тохиолдолд шат шатны шийдвэр гаргалтаар засаж залруулах нь бол хууль тогтоогч УИХ-ын байгууллагын хувьд шийдвэр гаргах нь гол асуудал юм гэдгийг хэлье.

Одоо Та бүхэнд сонсголын хөтөлбөр, дэг дарааллыг танилцуулна. Эхний өдрийн сонсгол 6 дугаар сарын 15-ны өдрийн 09.00 цагт эхлэх байсан. Удтал хүлээлгэсэн Та бүхнээсээ хүлцэл өчье. Хоцорч ирц бүрдсэн учраас би цагийг нь ярихгүйгээр явчихъя. Ингээд өнөөдөр сонсголыг даргалагч сонсголыг нээж үг хэлээд сонсголд оролцогчийн эрх, үүрэг, хөтөлбөрийг танилцуулна. Үүний дараагаар эхний танилцуулгыг “Монгол Улсын төсвийн бодлого ба нийслэлийн төсвийн уялдаа санхүүжилтийн эх үүсвэр хууль тогтоомжид нийцсэн эсэх болон анхаарах асуудал (2024-2026)” сэдвээр Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулна.

Дараагаар нь “Нийслэлийн 2024-2026 оны төсөв”-ийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Б.Пүрэвдагва танилцуулна. Дараа нь “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, эх үүсвэр, шийдвэр гаргалт ба хэрэгжилтийн явц хууль тогтоомжид нийцсэн байдлын талаарх дүгнэлт”-ийг шинжээч Ц.Хосжаргал, Т.Мөнхбат нар танилцуулна. “Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хэрэгжүүлж буй төслүүдийн цар хүрээ, зарцуулалт, ирээдүйн хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн” сэдвээр Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа танилцуулна. “Нийслэлийн өмчит, өмчийн оролцоотой болон хамаарал бүхий хуулийн этгээдүүд, тэдгээрийн хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хийсэн дүгнэлт”-ийг шинжээч Ч.Мөнхбаатар, Б.Энхчимэг нар танилцуулна. Мөн “Нийслэлээс хэрэгжүүлж буй мега төслүүдийн шийдвэр гаргалт, хэрэгжилтийн явц, эрсдэлийн талаарх дүгнэлт”-ийг шинжээч С.Оюун-Эрдэнэ, Д.Энхбаяр нар танилцуулна. Үүний дараа “Нийслэлийн төсвийн захиран зарцуулалт хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт дэх хууль эрх зүйн асуудлууд” сэдвээр шинжээч Б.Энхчимэг дүгнэлт танилцуулна.

Дээрх танилцуулгуудын дараа сонсголд оролцогчдоос санал тайлбар үг хэлэх хэсэг эхэлнэ. Нийтдээ 2 цаг 10 минутаар төлөвлөсөн байна. Дараа нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу урьдчилсан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийн агуулгыг хуралдаан даргалагч уншиж танилцуулна. Үүний дараа үдийн хоолны завсарлага байгаа. Цайны завсарлага тусгайлан байхгүй. Тэгэхээр төрийн албаныхан хоорондоо ярилцаж байгаад боломжоороо ээлжилж гараарай. Оролцогчид бол чөлөөтэй. Үдээс өмнө 11 цагаас 12 цагийн хооронд, үдээс хойш бол 15-16 цагийн хооронд бэлдсэн байгаа. Үдээс хойш хоолны завсарлагааны дараа 14 цагаас “Нийслэлээс хэрэгжүүлж буй мега төслүүдийн төсвийн гүйцэтгэл, тодотгол, аудитын тайланд хийсэн дүгнэлт”-ийг шинжээч В.Данаасүрэн танилцуулна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буй хэргийн талаар мэдээлэл нийслэлийн хэмжээнд 2024 оноос хойш хийсэн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар судалгаа авсан арга хэмжээний талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газраас танилцуулна.

Ингээд УИХ-ын гишүүд асуулт асууж, хариулт авах, үг хэлэх хэсэг эхэлнэ. УИХ-ын гишүүд 14 цаг 20 минутаас 16 цаг 30 минутын хооронд асуулт асууж хариулт авна. Үүний дараа 16.30-17.30 хүртэл гишүүд үг хэлнэ. Ингээд 17 цаг 30 минут сонсголыг хааж сонсгол даргалагч үг хэлэх хөтөлбөртэй байна.

За одоо танилцуулгуудаа эхэлье. Эхний илтгэл Сангийн сайд З.Мэндсайхан

Таныг урьж байна. Илтгэгч 10 минутын дотор мэдээлэл хийх байгаа. Илтгэлийн сэдэв “Монгол Улсын төсвийн бодлого ба нийслэлийн төсвийн уялдаа, санхүүжилтийн эх үүсвэр, хууль тогтоомжид нийцсэн эсэх болон анхаарах асуудал”.

Сангийн сайд 3.Мэндсайхан: Ерөнхий хяналтын сонсгол даргалагч болон Байнгын хорооны гишүүд, сонсголд оролцож байгаа Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий хяналтын сонсголын ажлын хэсгийн даргаас өгсөн чиглэлийн дагуу Улаанбаатар хот болон улсын төсвийн хоорондын харилцаа цаашид анхаарах асуудлын танилцуулга бэлтгэлээ. Ерөнхийдөө Та бүхэнд нийслэлийн төсөв болон улсын төсөв хоорондын харилцан хамаарал нь энэ схем дээр үзүүлсэн байгаа улсын төсөв бол нийслэлийн төсөвтөө санхүүгийн дэмжлэг төвлөрүүлэх орлого, ААНОАТ орон нутгийн хөгжлийн санд татаас өгөх, дамжуулан зээл, хөрөнгө оруулалт гэсэн энэ 5 чиглэлээр үндсэн улсын төсөв нь нийслэлийн төсөвтэй харьцаж байна.

Гэхдээ улсын төсөв орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиг үүргийг тодорхой заагаагүй байдаг. Энэ нь юун дээр харагддаг вэ гэвэл өнөөдөр улсын төсвөөр нийслэл, сургууль, цэцэрлэг, зам талбай барих чиг үүрэг нь ч улсын төсөв дээрээ хадгалагдаж байгаа. Орон нутаг руу шилжүүлэхдээ нийслэл дээр мөн энэ ажлуудыг нийслэл, дүүрэг хийхээр хуульчлаад өгчихсөн байгаа. Тэгэхээр чиг үүрэг ялгаагүй учраас өнөөдрийн бид нарын харилцаа төсөв хооронд үндсэн энэ 5 чиглэлээр явж байна.

Нийслэл Улаанбаатар хотод улсын төсөвт төвлөрүүлэх орлого 2021 оноос Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбоотойгоор өөрчлөлт орсон. Өмнө нь төвлөрүүлэх орлогын суурь орлогын харьцаа Улсын төсөв 43,2% байсан бол өнөөдөр 7,5 болсон байна. ААНОАТ-ыг улсын төсөв рүү төвлөрүүлээд 40%-ийг нь нийслэл рүү буцааж олгож байгаа. Та бүхэн энэ дэлгэцээс харах юм бол суурь орлого болон ААН-ийн орлогын өсөлт болон нийслэл дээрх тэлэлтийг харуулсан байна. Зарлагын хувьд мөн зэрэгцүүлэн харуулсан байгаа. Тэгэхээр өнөөдрийн байдлаар бол 2026 онд нийт орлого төвлөрүүлэлт бол 2,4 их наяд буюу одоо суурь орлого маань өссөн байгаа. Үүн дээр нэмэх нь 1,1 их наяд гээд ингээд нийтдээ 3,4 их наядын орлого төвлөрч байна. Нийслэл дээр үнэт цаас болон одоо зарлагын хэмжээ 2,6 их наяд байна. Орон нутгийн хөгжлийн сангаас нийслэлд олгох шилжүүлэг хүн амын тооноос хамааруулан шилжүүлж байгаа.

Ингээд нийслэл рүү бол 42,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгож байна. Нийслэлийн төсвийн тоон үзүүлэлтийг та бүхэнд танилцуулах юм бол нийслэлийн төсвийн орлого ерөнхийдөө үндсэн бүрэлдүүлж байгаа нь ХХОАТ, ААНОАТ, хөрөнгийн татвар бусад татвар буюу татварын бус орлогоос бүрдэж байгаа. Нийслэлийн төсвийн орлого 2025 оны гүйцэтгэлээр 3,8 их наяд төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 24%-аар өссөн байгаа. Улсын төсөвтэй харьцуулан нийслэлийн орлогын бүтцийг авч үзвэл ХХОАТ болон ААНОАТ нь нийслэлийн орлогын 70 орчим хувийг бүрдүүлж байгаа нь нэгдсэн төсвийн 40 орчим хувиас өндөр үзүүлэлт бөгөөд нийслэлийн орлого нь хөдөлмөр эрхлэлт, ААН-ийн үйл ажиллагаанд суурилсан татварын баазад илүү төвлөрснийг энэ график дээрээс та бүхэнд харуулж байна.

Нийслэлийн орлогыг бүтцээр нь авч үзэх юм бол ХХОАТ 52%, ААНОАТ 21%, бусад татвар 8%, хөрөнгийн бус татвар 13%-ийг бүрдүүлж байна. Нэгдсэн төсвийн орлогыг авч үзвэл ХХОАТ 12%, ААНОАТ 17%, бусад татвар, татварын бус орлого, үлдэх татварын орон зайг бүрдүүлж байна.

Нийслэлийн төсвийн зарлагыг авч үзэх юм бол нийслэлийн төсвийн 2025 оны

гүйцэтгэлээр 4,5 их наяд төгрөгт хүрч өмнөх оныхоос 32%-аар өссөн. Эргэж төлөгдөх цэвэр зээл, хөрөнгийн зардал, урсгал зарлага гэсэн бүрэлдэхүүнтэй зарлагын бүтэц байгаа. 2022-2026 он хүрэхэд зарлага тасралтгүй тэлэлт үүссэн байгаа. Энэ бол Нийслэлийн эрх зүйн байдлын хууль батлагдсантай холбоотойгоор орлого төвлөрөлт дээр гарсан зардлын тэлэлт үүсэж байгаа. 2022 онд 1,4 их наядын зарлагатай байсан бол 2026 оны НИТХ-ын баталсан дүнгээр 7,8 их наядын зарлага батлагдсан байна.

Нийслэлийн төсвийн алдагдал 2026 оны төлөвлөгөөгөөр 2,4 их наяд төгрөгт хүрч нэгдсэн төсвийн алдагдлын 232.8%-тай тэнцэж байгаа. Улсын нэгдсэн төсвийн алдагдал 1 их наяд байгаа бол зөвхөн нийслэлийн алдагдал 2,4 их наядад хүрч байна. Энд юу нөлөөлж байна гэвэл нийслэл Улаанбаатар хот төсвийн алдагдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг алдагдуулж байгаа. Нийслэлийн төсвийн алдагдал 2024 оноос огцом өсөж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал эзлэх хувь 2024 онд 29.5% байсан бол 2025 онд 68.1% болсон. 2026 оны төлөвлөгөөгөөр 2,4 их наяд хүрч байна. Тэгэхээр энэ зардлын өсөлт нь нэгдсэн төсвийн алдагдалд нөлөөлж байгаа учраас цаашдаа энэ төсвийн зардлыг нийслэл дээр хянах тогтолцоог оруулж ирж Төсвийн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын хуульд тодорхой болгож өгөхгүй бол асуудал үүсэх нь. Оны төгсгөл рүү бид нар механик зохицуулалт хийхээс өөр замгүй болно. Нэг ёсондоо төсвийн алдагдлаа барихын тулд нийслэлийн зардлыг санхүүжилтийг хязгаарлах байдал руу орно. Тэгэхээр нэг ёсондоо өнөөдөр улсын нэгдсэн төсвийн гадуур нийслэлийн төсөв өөрөө алдагдлыг бий болгоод энэ нь дээр бид нар ямар нэгэн хяналт тавих боломжгүй болж байна гэсэн үг.

Энэ асуудлууд юунаас болж үүссэн юм бэ гэвэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан байгаа. Төсвийн хууль дээр байсан зарлагын бүх бүтцүүд буюу чиг үүргийн эрх мэдлүүдийг бүгдийг нь ийш нь татаж авсан. Улсын төсөв дээр зөвхөн орлого талыг нь үлдээчихсэн, зарлага талыг Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд тусгаад өгчихсөн учраас бид нар орлогыг зөвхөн хянаж болно. Зардал дээр ямар нэгэн хяналт тавих ийм боломжгүй. Одоогийн хуулийн зохицуулалт бий болсон.

Нэг ёсондоо нийслэл нь бие даасан төсөвтэй байна гээд эрх зүйн байдлын хууль дээрээ 11.1 дээр тусгай чиг үүргийн санхүүжилтийг нь зааж өгсөн байгаа. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиг үүргүүдийг нь заагаад өгчихсөн. Хотын аж ахуйн чиг үүрэг дээр гээд энэ та бүхэн слайд дээр харж байгаа байх. Нийтдээ эндээс харвал Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиараа төвлөрүүлж болох орлого болон нийслэлийн эрх мэдэл дээрээс нь бүх талын зардлынхаа эрх чиг үүргүүдийг бүгдийг нь Нийслэлийн эрх зүйн байдлын хуулиар хуульчилсан. Ингээд улсын нэгдсэн төсөв дээр орлогын талаарх заалт үлдээд бусад нь энэ төсвийн нэгдсэн хуулиас гаргачихсан. Энэ бол эрх зүйн хувьд эргэж харах асуудал болж байна. Үнэт цаасны орчин ба үнэт цаасны талаар ярих юм бол нийслэл өнөөдрийн байдлаар 2,5 их наядын гадаад болон дотоодын үнэт цаас гаргасан байна. 2021 оны 7 сард батлагдсан Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар нийслэл үнэт цаас гаргаж болно, Өрийн удирдлагын тухай хуулиар нийслэл гадаад үнэт цаасыг Засгийн газрын өрийн баталгаагаар гаргаж болно гэсэн энэ заалтыг үндэслээд гаргасан. Гаргасан үнэт цаасыг одоо харуулвал 2024 оны Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор Бөөрөлжүүтийн ДЦС барих төсөл дээр 300 тэрбум, зам засвар арчилгаа дээр 150 тэрбум, бохир усны Туул нэг коллектор дээр 50 тэрбум гээд дотоодын болон гадаадын үнэт цаас гаргасан байна.

Энэ үнэт цаас дээр Засгийн газрын тогтоолоор гарсан учраас энийг Засгийн газрын баталгаатай гэж үзэхэд эрх зүйн хувьд эргэлзээтэй. Засгийн газрын 2024 оны 264 дүгээр тогтоолоор Батарей хуримтлуурын төсөл дээр 298 тэрбум төгрөгийн бондыг 5 жилийн хугацаатай 8,3%-ийн хүүтэй гаргасан байгаа. УИХ-ын 2024 оны 17, Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоол дээр Сэлбэ дэд төвд түшиглэсэн орон сууцжуулалтын төсөл дээр 500 сая ам.долларын бонд буюу 1,7 тэрбум төгрөгийн бондыг 2,75 жилийн хугацаатай 7,75%-ийн хүүтэй гаргасан. Энэ бондын эргэн төлөлт ирэх жил төлөгдөхөөр хугацаа нь дуусаж байгаа.

Нийслэлийн үнэт цаасны үлдэгдлийг төсвийн орлогынх нь 70%-аас хэтрүүлэхгүй байна гэсэн хуулийн заалтаа хангаж байгаа. Гэхдээ нийслэлээс гаргасан бонд болон дотоодын үнэт цаас нь Засгийн газрын өр дээр улсын төсөвт бичигдээд явж байгаа. Төлөлтөд эрсдэл үүсэх юм бол Засгийн газар хариуцаж төлнө. Нийслэл төлөхгүй гэсэн ийм зохицуулалттай явж байгаа. Энэ бол улсын төсөвт маш том ачаалал болж орж ирэхээр байгаа. Суурь болон ИТХ-ын баталсан дүнг нь та бүхэнд ингээд харуулъя.

2022 онд УИХ-аар улсын төсвийн хязгаарыг нийслэл дээр 1,3 их наядын орлоготой, 827.6 тэрбум төгрөгийн зарлагатайгаар баталж байсан. Өнөөдрийн байдлаар 2023-2026 он хүртэл нийт баталсан хязгаар болон НИТХ-ын баталсан хязгаарын хоорондын зөрүүг харуулж байна. 2026 оны байдлаар улсын төсвийн хязгаар дээр орлогыг 3,4 их наяд, зарлагыг 2,7 их наяд төгрөгөөр баталсан бол НИТХ орлогыг 7,6 их наяд төгрөг, зарлагыг 7,8 их наяд төгрөгөөр баталсан байгаа.

Төсвийн тухай хуулиар аймаг, орон нутгийн төсөв алдагдалгүй батлагдах ёстой. Тэгэхээр өнөөдрийн байдлаар нийслэлийн төсөв 2,4 их наядын алдагдал үүсэхээр байна. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйл дээр ААНОАТ-ын орлогын 40%-ийн харьцаа аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлдэг болсон.

Үүнтэй холбоотойгоор нийслэлийн орлого тэлсэн. Үүнийг дагаад зардлаа өсгөсөн. Энэ дээр голлож нөлөөлж байгаа асуудлууд бол түрүүний дурдсан бондын асуудлууд байгаа. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйл дээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны 14 дүгээр тогтоол болон Засгийн газрын 201, 264, 265 дугаар тогтоолоор нийтдээ 2,5 их наяд төгрөгийн үнэт цаасыг нийслэл гаргасан байна.

Олон улсад ямар байдаг юм бэ гэвэл чиг үүргийн заагийг нь маш тодорхой зааж өгсөн байдаг. Татварын хувь орлогын хуваарилалтад суурилсан тогтолцоо гэх юм бол НӨАТ, ААНОАТ, ХХОАТ томоохон татваруудыг төв Засгийн газар цуглуулж томьёолсон механизмаар хуваарилдаг. Өөрийн орлогын эх үүсвэрт суурилсан тогтолцоонд бол хотын эдийн засгийн идэвхжилтэй шууд холбоотой татварыг нийслэл өөрөө төвлөрүүлдэг. Үүнд бол үл хөдлөхийн хөрөнгийн татвар, автомашины татвар, зочид буудлын татвар, одоо рестораны татвар, зар сурталчилгааны зардал гэх мэт энэ татваруудыг нийслэлд төвлөрүүлдэг. Төсвийг шилжүүлэхэд суурилсан тогтолцоо гэхээр бид нар төвлөрүүлсэн орлогоосоо орон нутгийн орлогын санхүүгийн татвар, чадавхыг дэмжих, төрийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангах, хөгжлийн ялгааг бууруулах, зорилготойгоор тэнцвэржүүлэх шилжүүлгүүдийг хийдэг.

Төв засгийн газрын чиг үүргийн хуваарилалтын зарчимд батлан хамгаалах салбарын бодлого, гадаад бодлого, шүүх, прокурор гээд дэлгэцэнд үзүүлсэн мөнгөний бодлогоо явуулах, санхүүгийн бодлого, төмөр замын бодлого, үндэсний

авто замын сүлжээ, эрчим хүчний бодлого, боловсролын бодлого, байгаль орчин, үндэсний статистик мэдээлэл орно. Ингээд энэ үндсэн бодлогуудаа Засгийн газрын төв чиг үүрэгтэй авч явдаг. Нийслэлийн чиг үүрэг дээр бол хот төлөвлөлт, газар ашиглалт, нийтийн тээвэр, хотын авто зам гээд хог хаягдлын менежмент, нийтийн гэрэлтүүлэг, ногоон байгууламж гээд нийслэлтэй холбоотой нийслэлийн шийдвэрлэх чиг үүргүүдийг тусгай зааж өгсөн байдаг. Нийслэлийн бонд бол урт хугацааны хөрөнгө оруулалт, дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гадаад зах зээл дээр хөрөнгө татах боломжтой. Гэхдээ Засгийн газрын зөвшөөрөлтэй, Өрийн удирдлагын тухай хуульд захирагдах гэсэн ийм үндсэн чиг үүргүүдийг авч явдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Микрофоныг нээж өгье. Гүйцээж танилцуулъя.

Сангийн сайд 3.Мэндсайхан: Чиг үүргүүдийг бол Олон Улсад тодорхой зааж өгсөн байдаг. Манайд бол чиг үүргийн хуваарилалт маш тодорхойгүй байгаа. Тийм учраас улсын төсвөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалт болон урсгал зардлыг хөрөнгө оруулалтын зардал болон нийслэлийн хөрөнгө оруулалтын зардлууд чиг үүрэг нь адилхан давхцаж байгаа. Нэг ёсондоо улсын төсвөөр хөрөнгө оруулалтыг хийх боломж байгаа. Мөн нийслэл, дүүргийн хөрөнгө төсвөөр нийслэл хотод хөрөнгө оруулалт хийх байна. Тэгэхээр энэ чиг үүргийн заагийг бид орлогын шилжилттэй холбоотойгоор зайлшгүй шийдэж өгөх ёстой байгаа. Бидний дүгнэлт бол 1 дүгээрт, төсвийн алдагдлын асуудал байна. Нийслэл Улаанбаатар хотын төсвийн алдагдал сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж байгаа.

2026 оны НИТХ-аар баталсан алдагдал бол УИХ-аар баталсан нэгдсэн төсвийн алдагдлаас 1,4 их наяд төгрөгөөр их байгаа. Өөрөөр хэлбэл нийслэлийн төсвийн алдагдал өөрөө нэгдсэн төсвийн зарлагын алдагдлын хэмжээг давчихсан байж байгаа. Үүнээс шалтгаалаад төсвийн гүйцэтгэлээр төсвийн хүрээний мэдэгдэл болон Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагыг барих боломжгүй болгож өгч байгаа. Нийслэлийн зардлын тэлэлт урьд оны үлдэгдлийн хувьд Төсвийн тухай хуулиараа орон нутгийн төсвийг алдагдалгүй батлах, мөн 57.3-т орон нутгийн төсөв урьд оны санхүүжилтээс үлдэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэхээр ийм салаа утгатай 2 заалт явж байгаа юм. Тэгэхээр уг 2 заалтын зөрчлийг арилгаж өгөхгүй бол цаашдаа урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зардлаар нэгдсэн төсвийн зардал тэлэх, төсвийн алдагдал нэмэгдэж байгаа асуудлыг шийдвэрлэх боломжгүй болоод байгаа юм. Мөн энэ 2 хууль дээр байгаа салаа заалтыг бид нар нэгтгэх шаардлага үүсэж байна. За чиг үүргийн хувьд Улаанбаатар хотын чиг үүргийг Нийслэл Улаанбаатарын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулж байгаа. Энэ дээр нийслэлийн чиг үүрэг, төсвийн, хотын, нийслэлийн өөрийнх нь төсөвтэй уялдуулаад чиг үүргийг нь бүрэн шилжүүлж өгье гэдэг ийм саналыг гаргаж байна. Орлогын хуваарилалт дээр ААНОАТ-ын 40%-ийг ААН байрлаж байгаа аймаг, нийслэлд нь хуваарилдаг болсноор төсвийн зарлагын тэлэлтийг үүсгэж байгаа үндсэн суурь болж байна гэж үзэж байна. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 3.Мэндсайхан сайдад баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлд зааснаар оролцогчийн санал, мэдээлэл, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байх гэж заасан байгаа. Тийм учраас та бүхэн танилцуулгаа хийхдээ цагаа баримтлахыг хүсье. Дараагийн танилцуулга Нийслэлийн 2024-2026 оны төсөв сэдвээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч Б.Пүрэвдагва танилцуулна. Индэрт урьж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Б.Пүрэвдагва: Эрхэм Улсын Их Хурлын гишүүд, энэхүү сонсголд оролцож байгаа оролцогчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд нийслэлийн төсвийн сүүлийн 3 жилийн бүрдүүлэлт, зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн томоохон төсөл, арга хэмжээнүүд, хотоос гаргасан үнэт цаас түүний зарцуулалт эргэн төлөлтийн талаар танилцуулга хийе.

Төсвийн орлогын ерөнхий мэдээлэл 2024-2026 он Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан төсвийн орлогын ангиллын дагуу нийслэлийн төсвийг төлөвлөн бүрдүүлж байна. Өнөөдрийн байдлаар нийслэлийн төсөвт 25 нэр төрлийн орлого төвлөрч байгаагаас 17 нэр төрлийн татварын орлого, 8 нэр төрөл нь татварын бус орлогоос бүрдэж байна. Төсвийн тухай хуульд 2021 оны 7 дугаар сард орсон нэмэлт, өөрчлөлтөөр 2022 оны төсвийн жилээс эхлэн ААНОАТ-ын 40%-ийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр хуульчилсантай холбоотойгоор нийслэл, дүүргийн төсвийн орлогын бүтцэд томоохон өөрчлөлт орсон. Та бүхэн дэлгэцээр нийслэлийн төсвийн орлогын сүүлийн 3 жилийн харьцуулсан судалгааг харуулж байна. Судалгаанаас харахад төсвийн орлого жил бүр тогтвортой өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн жилүүдэд нийслэлийн хэмжээнд татварын бааз суурийг өргөжүүлэх, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийг татварын шинэчилсэн бүртгэлд бүрэн хамруулж татвар төлөгчдөд туслан зөвлөх үйлчилгээ үзүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, аль болох татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр татварын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг бууруулах чиглэлээр тодорхой ажлыг хэрэгжүүлэн ажилласанд төсвийн орлогын бүрдүүлэлтэд эерэг нөлөөллийг үзүүлж байна. Төсвийн орлогын 2026 оны 5 сарын гүйцэтгэлийг харуулъя.

2026 онд нийслэлийн төсөвт 5 их наяд 422,1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр батлагдсанаас татварын орлогоор 4 их наяд 250 тэрбум төгрөг, татварын бус орлогоор 1 их наяд 172,1 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ. Үүнд татварын нийт орлогын 58%-ийг ХХОАТ-аар бүрдүүлж байгаа бол 29%-ийг ААНОАТ-аар, үлдэж байгаа 13%-ийг бусад нэр төрлийн татварын орлогоос бүрдүүлэхээр байна. 2026 оны 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нийслэлийн төсөвт 1 их наяд 589,1 тэрбум төгрөг төвлөрч төсвийн орлогын бүрдүүлэлт 81.7%-ийн гүйцэтгэлтэй байна.

Дэлгэцээр та бүхэн нийслэлийн төсвийн орлогын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг төсвийн орлогын ангиллаар болон хот дүүргээр нь ангилан харуулж байна. Төсвийн зарлагын ерөнхий мэдээлэл нийслэлийн төсвийн зарлагын сүүлийн 3 жилийн харьцуулсан судалгааг харуулж байна. Судалгаанаас харахад төсвийн зарлага орлогын өсөлтөөр жил бүр тогтвортой өссөн байна. Зардлын бүтцийг 2026 оны хувьд авч үзвэл нийт зардал урсгалд 25.6%, дотоод гадаад үнэт цаастай холбоотой зардал 5.2%, хөрөнгө оруулалтын зардал 64.7%. Нийслэлийн улсын төсөвт төвлөрүүлэх 3.4%, дамжуулан зээл 1.2%-ийг тус тус эзэлж байна.

Энэ оны 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр зарлагын гүйцэтгэл 78.6%-тай байна. Төсвийн 2026 оны урсгал зардлын зарлагын төлөвлөгөө нийслэлийн төсвийн урсгал зардлыг арга хэмжээгээр авч үзэх юм. Хот тохижуулахын зардал 24.6% буюу 495,2 тэрбум, нийтийн тээврийн алдагдлын татаас ахмад настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цагдаагийн албан

хаагчдад олгох нийтийн тээврийн унааны нөхөн олговрын зардал 18.8% буюу 377,6 тэрбум, Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардал 16.4% буюу 329,2 тэрбум, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8% буюу 161,8 тэрбум төгрөг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал 4% буюу 79,7 тэрбум, СОП-17 зохион байгуулах зардал 3.5% буюу 70,1 тэрбум төгрөг, Агаар орчны бохирдлыг бууруулах зардал 2.6% буюу 52,3 тэрбум төгрөг бусад зардал 17.5% буюу 351,3 тэрбум төгрөг байна. Төсвийн 2026 оны 5 дугаар сарын хөрөнгө оруулалтын зарлагын гүйцэтгэл, Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 5 их наяд 85 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардал батлагдсанаас тайлант хугацаанд 629,8 тэрбум төгрөг буюу 12.4%-ийн биелэлттэй байна. Дүүргээр нь авч үзвэл нийт гүйцэтгэлийн 90.9%-ийг нийслэлийн хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл эзэлж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2 их наяд 116 тэрбум төгрөг нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжих санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ 749,2 тэрбум төгрөг үнэт цаасны хөрөнгө оруулалтаар 1 их наяд 500,9 тэрбум төгрөг, Нийслэлийн замын сангийн эх үүсвэрээр 227,5 тэрбум төгрөг батлагдсанаас захиалагч байгууллагуудын хянан баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэлд үндэслэн эхний 5 сарын байдлаар 572,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд хийгдсэн нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг авч үзвэл нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2024 онд 1 их наяд 811,4 тэрбум төгрөг байсан бол 2026 онд 4 их наяд 657,2 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөгдсөн. Үнэт цаасны эх үүсвэрээр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын томоохон төсөл, арга хэмжээ, мега төслүүд нэмэгдсэнтэй холбоотой байна. Эх үүсвэрийн бүтцийн хувьд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр 67-71%-ийг эзэлж байгаа бол үнэт цаасны эх үүсвэрээр 29-32%-ийг бүрдүүлж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 3 их наяд 156,2 тэрбум төгрөг, Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 1 их наяд 500,1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй авто зам, нийтийн тээвэр, боловсрол, дэд бүтцийн төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр баталсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийт 3 их наяд 156,2 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий дараах төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Авто зам, замын байгууламжийн шинэчлэл засвар арчлалтад 371,3 тэрбум төгрөг, трамвайн 2 дугаар шугамын бүтээн байгуулалтад 325 тэрбум төгрөг, Улаанбаатар метро төслийн бүтээн байгуулалтад 136,3 тэрбум төгрөг, зөвлөх үйлчилгээний ажилд 17,6 тэрбум төгрөг, газар чөлөөлөлтийн ажилд 281,5 тэрбум төгрөг, цэцэрлэг сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд 231,2 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгөд 59,4 тэрбум төгрөг, нийтийн тээврийг хөгжүүлэх санд 34 тэрбум төгрөг, он дамжин хэрэгжиж байгаа төслүүдийг дуусгахад 761,3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн.

Туулын хурдны замд төсөвлөгдсөн 800 тэрбум төгрөгөөс нэг ч төгрөгийн санхүүжилт олгоогүй байгаа бөгөөд хууль хяналтын байгууллагын шалгалтын ажил дууссаны дараа уг төсвийн асуудлыг эргэн харах боломжтой болно. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр нийт 1 их наяд 500,1 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий дараах төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын барилга угсралтын ажилд 1 их наяд 273,6 тэрбум төгрөг, ДЦС-5 төсөлд 200 тэрбум төгрөг, ариутгах татуургын Туул нэг коллекторын барилгын ажилд 22,3 тэрбум төгрөг, эрчим хүчний хуримтлуурын станцын ажилд 5 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн болно. Нийслэлийн үнэт цаас 2024 онд Засгийн

газрын 201, 264, 265 дугаар тогтоолуудаар нийт 2 их наяд 508,4 тэрбум төгрөгийн үнэт цаас, 2026 оны 49 дүгээр тогтоолоор 200 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас, нийт 2 их наяд 708,4 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргасан.

Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан 500 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нийт 3 транчтайгаар арилжаалсан. Үүнд транч нэг 300 тэрбум төгрөгийг 3 жилийн хугацаатай 14%-ийн хүүтэйгээр худалдсан. Эргэн төлөлтийг 2027 оны 6 дугаар сарын 25-нд хийж дуусахаар байна. Транч хоёр 100 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай 13%-ийн хүүтэйгээр арилжаалсан бөгөөд эргэн төлөлт хийх хугацаа 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдөр байна. Транч гурав 100 тэрбум төгрөгийг нэг жилийн хугацаатай 12%-ийн хүүтэйгээр арилжаалсан бөгөөд 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр бүрэн төлж барагдуулсан. Богино хугацаат өрийг хугацаанд нь барагдуулсан нь өрийн сахилга бат харьцангуй сайн байгааг харуулж байна.

Засгийн газрын 2024 оны 264 дүгээр тогтоолоор батлагдсан 298,3 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 5 жилийн хугацаатай 2 транчтайгаар гаргасан. Үүнд транч нэг 212,8 тэрбум төгрөгийг 5 жилийн хугацаатай 7.4%-ийн хүүтэйгээр, транч хоёр 85,5 тэрбум төгрөгийг 5 жилийн хугацаатай 5.6%-ийн хүүтэйгээр тус тус арилжаалсан. Эргэн төлөлт хийх хугацаа 2029 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өрийн бүтцийг урт хугацаанд шилжүүлэх дарамтыг багасгах бодлого барьсан болно.

Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор баталсан үнэт цаасыг 2,8 жилийн хугацаатай 7,75%-ийн хүүтэйгээр арилжаалсан. Эргэн төлөлт хийх хугацаа 2027 оны 8 дугаар сарын 21-ний өдөр байна. Засгийн газрын 2026 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан дотоод үнэт цаасыг 3 жилийн хугацаатай 14%-ийн хүүтэй гаргасан. Эргэн төлөлт хийх хугацаа 2029 оны 4 сарын 3-ны өдөр байна. Та бүхэнд Нийслэлийн 2024-2026 оны төсвийн талаар товч танилцууллаа. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Пүрэвдагва даргад баярлалаа. Яг цагтаа их мэдээллийг богино хугацаанд өгчихлөө гэж бодож байна.

Та бүхэндээ нэмээд нэг тайлбар хэлчихье. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах үүргийн хүрээнд Хянан шалгах түр хороо гэж байгуулдаг. Хяналтын сонсголын хувьд ерөнхий хяналтын болон Төсвийн хяналтын сонсгол гэж байдаг. Ерөнхий хяналтын сонсголоор мөрдөн шалгах тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэггүй.

Өнөөдрийн ерөнхий хяналтын сонсгол нэгдүгээрт Үндсэн хуульд заасан иргэдийн мэдэх эрхийг хангах дээрээс нь бид нарт бодлогын хэрэгжилтийн ямар алдаа байна гэдгийг олж илрүүлэх, түүнийг залруулах нь хууль тогтоогч байгууллагын үндсэн үүрэг. Тэгэхээр сая танилцуулсан мэдээллээс та бүхэн 2,3-хон тоог харсан байх. Нутгийн өөрөө удирдах ёс Улаанбаатар хотын хөгжлийг идэвхжүүлэх зорилгоор Монгол Улс сүүлийн хэдэн жил нэлээн олон хуулиудыг баталсан. Эрх мэдлийг нэмж, олон төрлийн татваруудыг нэмсэн. Үүний үр дүнд төсвийн тэлэлт ямар их хэмжээгээр гарсан байна гэдэг нь та бүхэнд харагдаж байна. Огцом хурдацтай өөрчилж, дандаа алдаануудыг дагуулж явдаг. Ганцхан жишээ хэлэхэд Сангийн сайдын танилцуулга дээр нийслэлийн төсвийн алдагдал 232 хувь, өөрөөр хэлбэл улсын төсөв 1,4 их наяд батлагдсан бол нийслэл 2,4 их наяд. Тэгэхээр энэ өрийн баталгаа буцаад Засгийн газар дээр, Засгийн газар бол улсын төсвөөс улсын төсвийг Улсын Их Хурал баталдаг.

Улсын Их Хурал гэдэг бол ард түмний элч болсон хүмүүсийн ажлаа хийдэг газар. Тэгэхээр энэ бүгдээрээ ард түмний нуруун дээр ирэх татварын орлогын мөнгө. Тийм учраас өнөөдрийн сонсголоор бид элдэв мөрдөн шалгах ажиллагаанаас илүүтэйгээр Монгол Улсын төсөв, эдийн засагт ямар эрсдэл байна вэ, яаж өөрчлөх вэ гэдэг дээр анхаарч хэлэлцэж байна.

Дараагийн илтгэлийг хэлэлцүүлэх асуудлыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Ч.Лодойсамбууд түр шилжүүлье. “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт эх үүсвэр шийдвэр гаргалт ба хэрэгжилтийн явц хууль тогтоомжид нийцсэн байдлын талаарх дүгнэлт”-ийг шинжээч Ц.Хосжаргал, Т.Мөнхбат нарын танилцуулгыг сонсьё.

Шинжээч Ц.Хосжаргал: Эрхэм гишүүд болон сонсголд оролцож байгаа нийт оролцогчид энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт болон эх үүсвэр, шийдвэр гаргалт, хэрэгжилтийн явц, хууль тогтоомжид нийцсэн байдлын талаарх шинжээчийн товч дүгнэлтийг Та бүхэнд танилцуулъя. Нийслэл 2024 онд төсвийг 4 удаа тодотгосон байна. Ингэж тодотгохдоо ашигтай байсан төсвийг алдагдлыг нэмэгдүүлж баталсан. Энэ нь өөрөө Төсвийн тухай хуульд заасны дагуу урьдчилан тооцуулах боломжгүй байдлаас нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах эсвэл зардал нэмэгдэж төсвийн алдагдал нэмэгдэхээр байвал төсвийн зарлагыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх замаар төсвийн тэнцлийг тэнцвэржүүлж алдагдалгүй байлгах гэсэн төсвийн зарчмыг зөрчиж төсвийг алдагдалтай баталсан байна. Тодотголоор 2025 онд анхны баталсан төсвийн алдагдлыг бууруулсан эерэг үзүүлэлттэй харагдаж байгаа боловч бүх зардлыг бууруулсан зардлыг шинжилж үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тухайн оны төсвөөс санхүүжих дүнг бууруулсан.

Мөн Төсвийн тухай хуульд заасан тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжүүлэх дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх гэсэн заалтыг зөрчсөн байдалтай байна. 2026 онд тодотгол хийхдээ төсвийн алдагдлыг нэмэгдүүлсэн нь төсвийн хуульд алдагдалгүй батлах гэсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Нийслэл төсвийн тодотголыг хийхдээ тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн тоо төсөвт өртгийг нэмэгдүүлсэн тухайн онд санхүүжүүлэх дүн болон 2024 онд дүнг нэмэгдүүлсэн. Ингэж төсвийн тодотгол хийхдээ төсөл, арга хэмжээний тоо мөнгөн дүнг нэмэгдүүлсэн. Энэ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь нийслэлийн төсвийн төсөлд тусгагдаагүй. Мөн нийслэлийн урт, дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцээгүй, нийслэлийн тухайн онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан тухайн жилийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээ нь хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх гэсэн заалттай нийцэхгүй байна гэж шинжээчийн хувьд дүгнэж байна. Нийслэлийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад орлого 23.7%-аар, зарлага 34.9% буюу зарлага нь 10,9 функтээр илүү байгаа нь өөрөө төсвийг өмнөх оноосоо алдагдал өсөх байдалд хүргэсэн байна. Орлогод гол нөлөөлсөн татварын орлого бол ААНОАТ, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар болон Нийслэл хотын албан татварын өсөлт нөлөөлж байгаа. Татварын бус орлогоос хүүгийн орлого, гол нь татварын өсөлтөд нөлөөлсөн гэсэн байна. Зарлагын нийт өсөлтөд хөрөнгийн зардал болон урсгал зардлын 44% өссөн нь нөлөөлсөн гэсэн үзүүлэлттэй байна. Тухайн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхдээ төсөв, үнэт цаас гаргасан байгаа. Энэ үнэт цаас гаргахдаа нийт 2,9 их наяд төгрөгийн үнэт цаас

гаргах зөвшөөрөл авснаас 2024 онд гаргасан үнэт цаасныхаа 43,2%-ийг нь ашиглаагүй байгаа нь эх үүсвэрээр санхүүжүүлэх төсвийн бэлтгэл ажил хангагдаагүй байгааг харуулж байна. 2026 оны 6 сарын 10-ны байдлаар нийт гаргасан үнэт цаасны хүүгийн зардалд одоогийн байдлаар 256,3 тэрбум төгрөгийн зардал гаргасан үзүүлэлттэй байна.

Төсвийн гүйцэтгэлийг өмнөх жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад орлогын гүйцэтгэл дунджаар 88.8%-тай, зарлагын гүйцэтгэл нь 77%-тай байгаа нь тухайн нийслэлийн төсвөөр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна гэж дүгнэхээр байна. Нийслэлийн төсвийн зарлага нийт өсөлтөд голлон нөлөөлж байгаа нь хөрөнгийн зардал байгаа. Хөрөнгийн зардал бол өмнөх оноосоо 34% өссөн үзүүлэлттэй. Урсгал зардлаас гол нөлөөлж байгаа зардал нь бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал, татаас мөн бусдаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал өссөнтэй холбогдуулж өмнөх оноосоо өссөн байна. Нийслэлийн төсвийн нийт урсгал зардлын 20%-ийг нийслэл өөрийн орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдээр дамжуулан зарцуулсан байгаа нь төрөөс хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болох ажил, үйлчилгээг өөрийн, орон нутгийн өмчит аж ахуй нэгжээр дамжуулж байгаа нь төрийн бодлоготой уялдахгүй байна гэж шинжээчийн хувьд дүгнэж байна. Хөрөнгө оруулалтын зардал 2016 онтой харьцуулахад 10 дахин өссөн.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ 5-12 жил он дамжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнүүд байна. Энэ нь Төсвийн тухай хуульд тухайн хөрөнгө оруулалтын арга хэмжээг 3 жилд багтаан санхүүжиж дуусгахаар Төсвийн хуульд заасантай зөрчилдсөн. Олон жил дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ нь тухайн төсөл арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэхэд хүргэж байна гэж дүгнэж байна. 2024 он болон 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний хэрэгжилтийг харвал 2024 онд нийт гэрээ байгуулсан ажлын 29.2% нь хэрэгжсэн, 2025 оны хувьд гэрээ хийсэн төсөл арга хэмжээний 60.8% нь бүрэн хэрэгжсэн байдалтай байгаа нь анх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталж байгаа нь тухайн жилдээ хэрэгжихгүй байх, он дамнах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Зураг төсөвгүй, магадлангаар батлагдсан. Төсөл, хөрөнгө арга хэмжээ батлагдсаныхаа дараа магадлангаар оруулдаг. Газрын зөвшөөрөл болон техник инженерийн зөвшөөрөл нь олгогдоогүй төсөл арга хэмжээнүүдийг баталж байгаа нь өөрөө хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн гэж үзэж байна. Шинжээчийн хувьд нийслэл төсвийнхөө төлөвлөлтөөсөө эхэлж хуульд нийцүүлж ажиллах шаардлагатай байна гэсэн ерөнхий дүгнэлтийг хийж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Уг нь таны танилцуулга их чухал танилцуулга байна. “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, эх үүсвэр, шийдвэр гаргалт ба хэрэгжилтийн явц хууль тогтоомжид нийцсэн байдлын дүгнэлт” гэж байгаа юм. Шинжээчийн танилцуулга бол хангалттай санагдахгүй байна. Тийм учраас дараагийн сонсгол дээр шинжээч нар өөрсдийн өгөгдсөн даалгаврын дагуу мэдээллээ дахиж сайн бэлдэх шаардлагатай шүү. Дараагийн илтгэл “Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хэрэгжүүлж байгаа төслүүдийн цар хүрээ, зарцуулалт, ирээдүйн хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн”-гийн талаар Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа танилцуулна.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нийслэлийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 16 хуулийн этгээд

компани үйл ажиллагаа явуулж байна. 26 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээр нийтдээ 40 гаруй хуулийн этгээдүүдээс 7 компани өнгөрсөн онд 7,6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. 9 компани 14 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан ийм нөхцөл байдалтай байгаа.

Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудаас 18 газар нь 18,3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан, 6 үйлдвэрийн газар алдагдалтай ажилласан буюу 4 үйлдвэрийн газар аудитын хязгаарлалттай дүгнэлтээр дүгнэгдсэн. Нийслэлийн хэмжээнд эдгээр орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нийтдээ 16 томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд явж байна. Миний зүгээс өнөөдөр та бүхэндээ эдгээр төслүүдийн талаар маш товч танилцуулга хийе. Манай нийслэлийн тухайн төсөл хөтөлбөрийг хариуцсан удирдлагууд бүгд ирсэн байгаа. Нэмэлтээр дэлгэрүүлж тайлбар өгөхөд бэлэн байна. Нийтдээ 28 их наяд 892 тэрбум 283 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ийм 16 томоохон төслүүд бий.

Өнөөдрийн байдлаар эдгээр 16 төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 1 их наяд 396 тэрбум 631 сая төгрөгийн зарцуулалттай буюу төслийн нийт төслийн гүйцэтгэл 4,8%-ийн гүйцэтгэлтэй байна. Төсөл тус бүрийг нь Та бүхэнд товч танилцуулъя. Нэгдүгээрт, Улаанбаатар метро төслийн хувьд ТЭЗҮ 100% хийгдсэн, газар чөлөөлөлт бүрэн хийгдээгүй. Өнөөдрийн байдлаар байгаль орчны нарийвчилсан үнэлгээ тайлан батлуулсан. Сонгон шалгаруулалт 1, 2 дугаар үе шатны сонгон шалгаруулалт зарлагдсан. 2 дугаар шатын сонгон шалгаруулалт энэ оны 7 сарын 3-ны өдөр нээхээр төлөвлөгдсөн. Төсөвт өртөг, 2433,38 сая ам.долларын төсөвт өртөгтэй. 2024-2030 онд хэрэгжилтийг хангаж дуусгах төлөвлөгөөтэй төсөл байгаа. Өнөөдрийн байдлаар тус төслийн гүйцэтгэл 5%-тай гэж дүгнэсэн байна. Дараачийнх нь Улаанбаатар трам-1 шугам байгаа. Сүхбаатарын талбайгаас Зунжин чиглэлийн ийм төсөл Трам-2 шугам нь Архивын ерөнхий газраас Сүхбаатарын талбай гэсэн ийм 2 тусдаа төсөл бий. Нэгдүгээр төслийн хүрээнд 275,28 сая ам.долларын төсөвт өртөгтэй, 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй. ТЭЗҮ 100% хийгдсэн. Газар чөлөөлөлт хийгдээгүй, сонгон шалгаруулалт явагдаагүй байдалтай байна. Улаанбаатар Трам шугам-2 дугаар төсөл нь 348,16 сая ам.долларын төсөвт өртөгтэй 2024-2028 онд хэрэгжих төлөвлөгөөтэй, ТЭЗҮ 100% хийгдсэн, газар чөлөөлөлт хийгдээгүй. Сонгон шалгаруулалт зарлагдсан байгаа. 2026 оны 5 сарын 13-нд нээх төлөвлөгөөтэй байсан хэдий ч мөн Монополын эсрэг газарт гомдол гарсан учраас төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа нээгдээгүй байдалтай байгаа.

Дараагийн төсөл бол 1 дүгээр тойрог замын төсөл байна. Хариуцагч байгууллага нэгдсэн төслийн удирдлагын газар нийт 918,57 сая ам.долларын төсөвт өртөгтэй. 2025-2028 онд хэрэгжих төлөвлөгөөтэй байгаа, ТЭЗҮ 100% хийгдсэн, газар чөлөөлөлт явагдаагүй, сонгон шалгаруулалт зарлагдсан. 2 сонирхогч этгээд санал ирүүлсэн. Баталгаа ирүүлээгүй байгаа. 2 дахь төсөл нь Тойрог-2 дугаар замын төсөл байгаа. Энэ төсөл маань ТЭЗҮ-ийн гүйцэтгэл 90%-тай, газар чөлөөлөлт хийгдээгүй, сонгон шалгаруулалт өнгөрсөн оны 12 дугаар сарын 17-нд явагдсан. Мөн дахин 2026 оны 3 дугаар улиралд дахин хэлэлцүүлэхээр төлөвлөчихсөн байдалтай төсөл байна.

Сэлбэ хот орон сууцжуулах төсөл байна. Энэ төслийг Сэлбэ 20 минутын хот корпорац хариуцан хэрэгжүүлнэ. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нийслэлийн бондоос болоод төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. 611,41 сая ам.долларын төсөвт өртөгтэй 2025-2027 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй төсөл байгаа. ТЭЗҮ 100% хийгдсэн, газар чөлөөлөлт 2206 нэгжээс 2095 нэгжийг чөлөөлөлт бүрэн хийгдсэн, ажлын зураг 95%-тай, барилгын ажил 32%-ийн гүйцэтгэлтэй явж байгаа ийм төсөл байна. Нийтдээ Сэлбэ орон сууцжуулах төсөл

маань 4 багц хэсгээс явж байгаа. 1 дүгээр багц барилга угсралтын явц 6.9%-тай, 2 дугаар багц 8.3%-тай, 3 дугаар багц бол 8.7%-ийн явцтай, 4 дүгээр багц 5.9%-ийн гүйцэтгэлтэй явж байгаа ийм төсөл, хөтөлбөр байна.

Дараагийн төсөл, хөтөлбөр Дулааны-V цахилгаан станцын төсөл байгаа. Хариуцагч байгууллага Дулааны-V цахилгаан станц ОНӨААТҮГ байна. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэл 20%, хувийн хэвшил 80% гэсэн төлөвлөгөөтэй. Нийтдээ 558,56 сая ам.долларын төсөвт өртөгтэй, хэрэгжих хугацаа 2025-2028 он гэж төлөвлөгдсөн. ТЭЗҮ 100% хийгдсэн, газар чөлөөлөлт 26 нэгжээс 25 нэгж бүрэн чөлөөлөгдсөн байдалтай байна. Яг төслийн гүйцэтгэл 6%-тай гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа төсөл байна.

Дараагийн төсөл Туулын хурдны замын төсөл байна. Хариуцагч байгууллага Туулын хурдны зам ОНӨААТҮГ. Хөрөнгийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээс гэж төлөвлөсөн. 611,84 сая ам.долларын төсөвт өртөгтэй, 2025-2028 онд хэрэгжиж дуусна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. ТЭЗҮ 100% дууссан. Газар чөлөөлөлт 112 нэгжээс 51 нэгжийг чөлөөлсөн. Ажлын зураг 80.6%-тай өнөөдрийн байдлаар гүйцэтгэл 13.15%-тай гэж дүгнэж байгаа. Туулын хурдны замын төслийн үндсэн барилга угсралтын ажил түр зогсоосон ийм байдалтай байгаа.

Дараагийнх Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн төсөл байна. Хариуцагч байгууллага “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр төр хувийн хэвшлийн түншлэл. Улс нийслэлийн төсөв болоод гадаадын зээл гэсэн төлөвлөгөөтэй. 62,91 сая ам.долларын төсөвт өртөгтэй, 2025-2028 онд хэрэгжүүлж дуусах төлөвлөгөөтэй байгаа. ТЭЗҮ болон газар чөлөөлөлт 100% хийгдсэн, ажлын зураг 60%-тай дэд бүтцийн бэлтгэл ажил 100% хангагдсан. Төслийн ерөнхий гүйцэтгэл 11%-тай гэж дүгнэсэн төсөл, хөтөлбөр байна.

Дэд төвүүдийг түшиглэсэн орон сууцжуулах ийм хөтөлбөр байгаа. Дэд төвүүдийг орон сууцжуулах хөтөлбөр 6 дэд хэсгээс бүрдэж байгаа. Сая Сэлбэ дэд төвийн тухай товч танилцуулсан. Нэмээд Дамбадаржаа дэд төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 71%-тай, Толгойт дэд төвийн гүйцэтгэл барилга угсралтын ажил 39%-тай, Дэнжийн мянга дэд төвийн барилга угсралтын ажил 7.6%-тай, Шар хад дэд төвийн барилга угсралтын ажил 11%-тай явж байна. Баянхошуу орон сууцжуулах дэд төвийн гүйцэтгэл төсөл 45.6%-ийн гүйцэтгэлтэй явж байгаа нийтдээ энэ 6 хэсгээс бүрдэж байна. Мөн ханын материал орон сууцжуулах төсөл 14.5%-ийн гүйцэтгэлтэй. Нийслэлийн хамгийн эрчимтэй явж байгаа төслүүдийн нэг байна.

Дараагийн нэг төсөл “Тусгай замын автобус”. Хариуцагч байгууллага Нэгдсэн төслийн удирдлагын газар. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг АХБ-ны зээлээр гэж төлөвлөсөн. Төсөвт өртөг нь 74,7 сая ам.долларын төсөвтэй, 2025-2030 онд хэрэгжих төлөвлөгөөтэй төсөл байгаа АХБ-ны зээлийн судалгаа 100% хийгдсэн. ТЭЗҮ 90%-тай, газар чөлөөлөлт хийгдээгүй, тендер шалгаруулалт явагдаагүй, ажлын төслийн ерөнхий гүйцэтгэл 4.7%-тай гэж дүгнэсэн төсөл байна.

Дүүжин тээврийн төсөл хариуцагч байгууллага Нэгдсэн төслийн удирдлагын газар. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Франц улсын нэн хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлэнэ гэж төлөвлөсөн. 1 дүгээр шугам бол 41,6 сая евро, 2 дугаар шугам бол 55 сая еврогийн төсөвт өртөгтэй гэж үзэж байгаа. Хэрэгжих хугацаа 2025-2027 онд дуусна. ТЭЗҮ болон газар чөлөөлөлт 100% хийгдсэн, ажлын зураг төсөв 95%-тай, барилгын ажлын гүйцэтгэл 72%-тай явж байгаа. Нийт ажлын төслийн нийт гүйцэтгэл

бол 74.8%-ийн гүйцэтгэлтэй явж байгаа.

Туулын усан цогцолбор төслийг хариуцагч нь Нэгдсэн төслийн удирдлагын газар. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг гадаадын зээлээс гэж төлөвлөсөн. Төсөвт өртөг 300 сая ам.доллар. Хэрэгжих хугацаа 2025-2032 он гэж төлөвлөгдсөн. ТЭЗҮ 1 дүгээр багц 90%-ийн гүйцэтгэлтэй. Газар чөлөөлөлт, сонгон шалгаруулалт явагдаагүй ийм байдалтай байна. Бусад төслүүдийг товч дурдаад явчихъя. “Лаг шатаах үйлдвэрийн төсөл” эдгээр бусад төслүүд маань хэрэгжилт бол 2-4%-ийн гүйцэтгэлтэй явж байгаа... (минут дуусав)

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Хугацаа 10 хүртэлх минут гээд хуулийн заалттай. Баярлалаа. Дараагийн танилцуулга “Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой болон хамаарал бүхий хуулийн этгээд тэдгээрийн хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хийсэн дүгнэлт”-ийг шинжээч Ч.Мөнхбаатар, Б.Энхчимэг нар танилцуулна.

Шинжээч Ч.Мөнхбаатар: Эрхэм гишүүд болон сонсголд оролцож байгаа нийт оролцогч Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд “Нийслэл нь орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй байж болно” гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийслэлд ОНӨААТҮГ болон аж ахуйн компаниудыг үйл ажиллагааг байгуулан ажиллуулж байна. Өнөөдрийн байдлаар нийслэлийн ОНӨААТҮГ нийт 43 аж ахуй нэгж байгаагаас нийслэлийн өмчит хуулийн этгээд 40, үүнээс 30 нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани байна. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 26 байна. Эдгээр ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны үр дүнд болон нийслэлийн өмчит ААН-үүдийн 2024-2025 оны аудитын дүн шинжилгээний нэгдсэн тайланд дүн шинжилгээ хийхэд 2025 оны байдлаар санхүүгийн болон засаглалын хэлбэр эрсдэлтэй хэвээр байна гэж дүгнэсэн. НИТХ-ын нийт 45 төлөөлөгчөөс 43 нь орон нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-д тодорхой суудал эзлэн ажиллаж байгаа нь нийт суудлын 65 буюу 62.5% байна.

Мөн 10 төлөөлөгч байгууллагын гүйцэтгэх удирдлагын албан тушаал эрхэлж ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож байгаа нь засаглалын төвлөрөл хяналтын хараат бус байдал болон сонирхлын зөрчлийн эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй байна. Тухайлбал, хуулиар зөвшөөрөгдсөний дагуу нийслэлийн ОНӨААТҮГ болон хувьцаат компаниуд зах зээлийн хуулийн дагуу өөрийн үйл ажиллагааг тэлж бизнесийн үйл ажиллагааныхаа дагуу явах зохицуулалттай хэдий боловч эдгээр компаниудын тоо, үйл ажиллагаа нь ихсэх тусам хувийн хэвшлийн орон зайг хумих, тэдгээрийн зах зээл дэх өрсөлдөөний орчинд сөргөөр нөлөөлж байна.

Орон нутгийн өмчит компаниудын холбоо хамаарлууд, үйл ажиллагааг тэлэлттэй нь холбон үзвэл Улаанбаатар хотын хөгжлийн корпорац 3 хараат компанитай үйл ажиллагаа явуулж байна. Мөн Улаанбаатар хөрөнгө оруулалт ҮЦК хуулийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ тусгай зөвшөөрлийн дагуу Говь-Алтай аймгийн санхүү хөрөнгө оруулалтын чиглэлээр Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газартай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан үйл ажиллагаагаа тэлэн явуулж байна. ОНӨААТҮГ нь хуулийн этгээдүүд нэмэгдэх нь хувийн хэвшлийн орон зайг хумих эрсдэлтэй. Мөн ТУЗ-д төвлөрөл их байгаа нь шийдвэр гаргах түвшинд буюу хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж ашиг сонирхлын зөрчил үүсэх

эрсдэлийг бий болгож байна.

Нийслэлийн өмчит компаниудын үйл ажиллагааны хүрээ өргөжин засаглалын нэгдсэн бодлого дутагдаж байна. Төрийн оролцоо нэмэгдэж байгаа нь өрсөлдөөний орчинд нөлөөлөх эрсдэл үүсгэж байна. Худалдан авах ажиллагаанд төвлөрөл бий болсон шинж тэмдэг ажиглагдаж, санхүүгийн төвлөрөл өндөр байна. Хууль тогтоомжийн нийцэл, ашиг сонирхлын зөрчлийн хяналтыг бэхжүүлэх шаардлагатай байна. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хэмждэг тогтолцоо хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг шинжээчийн зүгээс өгч байна. Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь нийслэлийн чиг үүргийг хэрэгжүүлэх томоохон төсөл хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч засаглал, өрсөлдөөний орчин, худалдан авах ажиллагааны төвлөрөл ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо хөрөнгө оруулалтын үр өгөөжийн үнэлгээний хүрээнд бодлогын түвшний шинэчлэл хийх шаардлагатай нөхцөл бүрдсэн байна. Танилцуулж дууслаа.

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Баярлалаа. За дараагийнх нь “Нийслэлээс хэрэгжүүлж байгаа мега төслүүдийн шийдвэр гаргалт, хэрэгжилтийн явц, эрсдэлийн талаарх дүгнэлт”-ийг шинжээч С.Оюу-Эрдэнэ, Д.Энхбаяр нар танилцуулна.

Шинжээч Д.Энхбаяр Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлээс хэрэгжүүлж байгаа мега төслүүдийн шийдвэр гаргалт, хэрэгжилтийн талаар нэгтгэсэн дүгнэлтийг танилцуулъя. Нийтдээ нийслэлээс хэрэгжүүлж байгаа 16 мега төсөл нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт болон Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хөтөлбөрүүдэд үндсэн агуулгаараа шууд туссан байна гэдэг дүгнэлт гарсан.

Дараа нь 16 мега төслүүдийг нь салбараар ангилаад харвал:

- Нийтийн тээврийн 4 төсөл, төсөвт өртөг 11,4 их наяд төгрөг;
- Авто замын 3 төсөл, төсөвт өртөг 8.6 их наяд төгрөг;
- Эрчим хүчний 4 төсөл, 3.8 их наяд төгрөг;
- Хот байгуулалтын 3 төсөл, 3.1 их наяд төгрөг;
- Дэд бүтэц, усны менежментын 2 төсөл, 2 их наяд төгрөг байна.

Дээр дурдсан 16 мега төслийн төсөвт өртөг 28.9 их наяд төгрөг байна. Хэрэгжүүлэх хугацаа нь 2024-2031 он гэсэн мэдээлэлтэй байна. Энэ төслүүдийн ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийгээд харвал ТЭЗҮ болон зураг, барилга угсралтын ажил гэсэн гол дарааллаар нь ингэж харлаа. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл нь өндөр байгаа төслүүдийг шар өнгөөр тодруулсан байгаа. Ингээд харах юм бол нийтдээ 28,9 их наяд төсөвт өртөг гарсан. Санхүүжилт нь аль аль төслүүд дээр ямар ямар үнийн дүнтэйгээр гарсан бэ гэдэг нь хамгийн ард талын баганад гаргасан. 1 их наяд 396,6 тэрбум төгрөг байна. Санхүүжилт гарсан 1,4 их наяд төгрөг нь нийт төсөвт өртгийнхөө 5% буюу үүнийг оноор нь харуулах юм бол 2023 онд 26,1 тэрбум төгрөг, 2024 онд 155 тэрбум төгрөг, 2025 онд 977,7 тэрбум төгрөг, 2026 оны байдлаар 237,8 тэрбум төгрөг байна. Эх үүсвэрээр нь харвал нийслэлийн төсвөөс 43%, үнэт цааснаас 34%, гадаадын зээл тусламж 20%, буцалтгүй тусламжаар 1%, улсын төсвөөс 2% гэсэн ийм төсвийн бүтэцтэй харагдаж байгаа.

Нийт 11 төсөлд шаардлагатай санхүүжилтийн дүн 19,1 их наяд төгрөг байна. Нийт төсөвт өртгийнхөө 66%-тай тэнцэж байгаа. Үүнийг мөн ингээд салбараар нь

ангилаад салгаж харууллаа. Та бүхний харж байгаагаар метро төсөл 8,3 их наяд төгрөг, тусгай замын автобус BRT нь 50,8 тэрбум, Улаанбаатар хөнгөн галт тэрэг Трам төсөл нь 954,4 тэрбум төгрөг, агаарын дүүжин замын тээврийн төсөл 2 дугаар шугам нь 234,2 тэрбум төгрөг, Эрчим хүчний төслөөр Лаг шатаах үйлдвэрийн төсөл 518,7 тэрбум төгрөг, хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх төсөл нь 712,4 их тэрбум төгрөг, Авто зам гүүрэн байгууламжийн төслөөр болохоор 1 дүгээр тойрог зам нь 3 их наяд 282,9 тэрбум төгрөг, тойрог зам 2 дугаар төсөл нь 2 их наяд 678,1 тэрбум, олон түвшний уулзвар төсөл нь 251,7 тэрбум, Дэд бүтэц усны менежменттэй холбоотой нь Туул усан цогцолбор төсөл 1 их наяд 72,5 тэрбум, хөрсний ус үерийн хамгаалалт төсөл нь 915,2 тэрбум буюу энэ төслүүдийн шаардлагатай. Нийт санхүүжилтийнх нь ихэнх нь гадаадын зээл, төр, хувийн хэвшлийн түншлэлээр төлөвлөсөн байгаа, эцэслэгдэн шийдэгдээгүй гэсэн мэдээтэй байна.

Цуглуулсан мэдээлэлд үндэслэн дүгнэлт хийхэд нийслэлээс хэрэгжүүлж байгаа 16 мега төсөл нь Алсын хараа, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын хөгжлийн агуулгууд шууд болон агуулгаараа бүрэн уялдсан. Гэхдээ ихэнх төслүүд нь барилга угсралтын ажил нь эхлээгүй, ТЭЗҮ боловсруулах, зураг төсөл гаргах зэрэг бэлтгэл шатандаа явж байгаа юм байна.

Мөн нийт 28,9 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий төслийн санхүүжилтийн гүйцэтгэл нь ердөө 5% буюу 1,4 их наяд төгрөг байна. Нийт төсөвт өртгийн 66%-ийг нь буюу 19,1 их наяд төгрөгийг гадаадын зээл, төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэхээр төлөвлөсөн ч энэ нь одоогоор бүрэн баталгаажаагүй байгаа. Төслүүд нь зогсох сунжрах зэрэг эрсдэл үүсэх магадлалтай. Мөн үүнээс улбаалаад эдийн засгийн үр ашиггүй байдал гэдэг дээр ямар дүгнэлт гарсан бэ гэвэл санхүүгийн шийдвэрлэлт удааширснаас болж бэлтгэл ажил шат шатанд зарцуулсан зураг төсөл, БОННУ, ТЭЗҮ гэх мэтийг бэлтгэсэн зардлууд байна. Эдгээрийн хүчинтэй байх хугацаа нь дуусаж дахин энэ хэмжээний зардал өөр байдлаар гарах бодитой эрсдэл байна гэж харж байна. Үүнийг Төсвийн тухай хуулийн 29.2.2-т заасан барилга байгууламжийн хувьд, Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн 2 жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байна гэдгийг үндэслэж гаргаж байгаа. Мөн удирдлага, зохион байгуулалтын төлөвшлийн тал дээр мега төслүүдийг хэрэгжүүлэх шийдвэр гаргалт эрсдэлийн удирдлагын систем нь бүрэн төлөвшөөгүй, дотоод хяналтын тогтолцоо нь жигдрээгүй байна.

Төслүүдийг олон улсын стандартын дагуу үр дүнтэй удирдах шаардлагатай байна гэсэн тийм дүгнэлттэй байна. Энэ дүгнэлтээс үүдээд зөвлөмж гаргасан. Санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг баталгаажуулах дээр гадаадын зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжих 19,1 их наяд төгрөгийн эх үүсвэрийг богино хугацаанд тодорхой болгож гэрээ хэлэлцээрийг эцэслэн баталгаажуулах шаардлагатай. Төсвийн хөрөнгө оруулалтын хамгийн өндөр ач холбогдолтой хэрэгжилтээр нь ахисан байгаа төслүүдэд төвлөрүүлж, үр дүнг нь хурдан гаргах шаардлагатай байна. Мөн төслийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог нийт хэрэгжүүлж байгаа 16 мега төслүүд дээрээ нэгдсэн байдлаар гаргах, 8 төсөл нь Нэгдсэн төслийн удирдлагын газар бусад төслүүд нь хариуцсан хариуцагч нэгж компаниуд дээрээ байгаа төслийг нэгдсэн удирдлагаар төслийн менежментийг хэрэгжүүлэхдээ нэгдсэн байдлаар явах нь зөв байна гэсэн зөвлөмж өгч байна. Бэлтгэл ажлын үр ашгийг хамгаалах тал дээр нэгэнт хийгдсэн ТЭЗҮ болон зураг төслийг хугацаа алдалгүй төслийг хэрэгжүүлэхийн тулд байгаль орчинд нөлөөлөл байдлын нарийвчилсан үнэлгээ болон газрын асуудлыг шуурхай шийдвэрлэх, төслийн төсөвт өртөг нэмэгдэхээс сэргийлж барилга угсралтын ажлыг төлөвлөсөн

хугацаанд нь эхлүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай. Мөн мега төслүүдийн шийдвэр гаргалт, хөрөнгө оруулалт, хэрэгжилтийн явцыг олон нийтэд нээлттэй ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлж хөндлөнгийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна гэж зөвлөж байна. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа дараагийн илтгэл “Нийслэлийн төсвийн захиран зарцуулалт хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт хууль эрх зүйн асуудлууд” сэдвээр шинжээч Б.Энхчимэг танилцуулна.

Шинжээч Б.Энхчимэг: Сонсголд оролцогч Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн хөрөнгө оруулалт болон төслүүдийн хэрэгжилттэй холбоотой хууль тогтоомжийн эрх зүйн асуудлыг 1) Төсвийн төсөл хөтөлбөрийг батлахтай холбоотой асуудалд төлөвлөлт батлахтай холбоотой асуудал болон хэрэгжилтийн явц дахь нөхцөл байдалтай холбогдуулан дүн шинжилгээ хийсэн байгаа. Үүнийг 2024-2025 оны аудитын дүгнэлт болон холбогдох бусад баримт бичгүүд дээр тулгуурлан хийсэн. Төлөвлөлтийн явц дахь хууль тогтоомжийн асуудлыг судлахдаа бодлогын баримт бичигт тусгагдсан эсэх, ерөнхий төлөвлөгөө дээр тусгагдсан эсэх асуудал дээр дүгнэлт хийсэн байгаа.

Нийтдээ нийслэл дээр хэрэгжүүлэгдэж байгаа 14 төсөл арга хэмжээ нь НЗД-ын хэрэгжүүлэх 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. 2025 оны 9 сарын 23-ны өдрийн байдлаар 16 болж нэмэгдсэн байгаа. Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан эсэх асуудал дээр өмнөх шинжээчдийн танилцуулснаар бол нийтдээ ерөнхий байдлаар тусгагдсанаас 2030 хүртэлх ерөнхий төлөвлөгөө нь өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд нийслэл дээр хэрэгжүүлж байгаа нийт төсөл арга хэмжээ нь ерөнхий байдлаар тусгагдсан.

Харин 2040 оны ерөнхий төлөвлөгөөнд тодорхой төсөл арга хэмжээнүүд нь тусгагдсан байгаа ч гэсэндээ УИХ-д өргөн баригдаад эцсийн байдлаар батлагдаагүй нөхцөл байдалтай байгаа. Тодорхой төсөл арга хэмжээг төсөвт тусгах болон хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлах ёстой. Үүнд Төсвийн тухай хуулийн 29.1, 29.2-т заасны дагуу тухайн төсөл арга хэмжээ нь ТЭЗҮ хийгдсэн эсэх, мөн газрын зөвшөөрөл болон холбогдох зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Мөн магадлалын дүгнэлтээр 2 жилийн хугацаанд батлагдсан төсөвтэй байх, урсгал зардлын тооцоолол гаргасан байх, төсвийн хязгаар батлагдсан байх олон нийтийн хэлэлцүүлсэн байх зэрэг хуулийн шаардлага тавигдсан байгаа. Гэтэл 2024 оны аудитын дүгнэлтээс дээр харахад нийтдээ 2024 онд шинээр 113 багц төсөл, арга хэмжээ батлагдсанаас зардлын тооцоолол хийх ёстой 57 арга хэмжээний нь бол 33-д нь зардлын тооцоолол хийгдээд 24 арга хэмжээнд нь зардлын тооцоолол хийгдээгүй нь хууль тогтоомжийн зөрчил гарсан. Мөн дээрээс нь 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийт нийцээгүй 12 төрлийн төсөл, арга хэмжээ байсан.

Тухайлбал, үүнд зураг төсөвгүй батлагдсан СХД-ийн 11 байрны суурь болон авто зам барих, зам засварын ажлын төсөл, арга хэмжээ, смарт сити зэрэг төслүүд нь тухайн жилдээ зураг төсөвгүй батлагдсан байгаа. Мөн дээрээс нь газрын асуудал шийдэгдээгүй, Төсвийн тухай хуулийг зөрчиж газрын асуудал шийдэгдээгүй төсөл арга хэмжээнүүд батлагдсан. Үүний нэг жишээ нь бол БЗД-ийн 640 суудалтай, 77,3 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн арга хэмжээ байна. Дулааны эх үүсвэр нь тодорхойгүй 2,1 тэрбум төгрөгийн цэцэрлэгийн өргөтгөлийн арга хэмжээ зураг төсөвгүй батлагдсан. 1,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ийм төсөл арга хэмжээнүүд байна. 2024 оны аудитын дүгнэлтээр төлөвлөлтийн шаардлага

хангаагүй батлагдсан төсөл арга хэмжээнүүд байна. Нийтдээ 118 төсөл арга хэмжээ батлагдсанаас 2021-2025 оны 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдаагүй 9 төсөл арга хэмжээ, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй 11 төсөл арга хэмжээ Засаг даргын 2025 оны үйл ажиллагаатай уялдаагүй 23 төсөл арга хэмжээ нь хууль тогтоомжийн зөрчилд орж батлагдсан байдаг.

Тодруулбал зураг төсөвгүй баталсан 60 төсөл арга хэмжээ байсан. Үүнийг нь багцлаад харвал орон сууцын дээвэр, фасад засварлах, эмнэлэг, сургууль цэцэрлэгийн засварын ажил, Эмээлт эко аж үйлдвэрийн парк, плэй тайм чиглэлийн цахилгааны авто замын ажил, Сэлбэ дэд бүтцийн ус, дулааны ажил зэрэг нь зураг төсөвгүй тухайн үедээ батлагдсан. Мөн дээрээс нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хугацаа нь дууссан төсөл арга хэмжээ батлагдсан 17 зөрчил, зураг төсөвгүй, техникийн шаардлага хангаагүй батлагдсан төсөл, арга хэмжээнээс шалтгаалж төсөвт өртөг нь 2,8 дахин нэмэгдүүлсэн байгаа. Мөн газрын зөвшөөрөл, байршил тодорхойгүй батлагдсан төсөл арга хэмжээнүүд байгаа. Үүнд гал унтраах, аврах анги, бейсболын талбай, шинээр баригдах станцуудын болон эрүүгийн хэргийн анхан шатын шүүхийн барилгын зураг төсөл зэрэг нь Төсвийн тухай хуульд заасан газрын зөвшөөрөл байршил тодорхойгүй байдлаар төсөвт өртөг нь батлагдсан байна. 2025 оныхоор. Хоёрдугаарт, төсөв, төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлэхдээ олон нийтийн оролцоог хангасан эсэх асуудал дээр хууль зүйн дүгнэлт гарсан байгаа.

Захиргааны ерөнхий хуулийн 73.1-д заасны дагуу тодорхой төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалт байгаа. Нийслэл дээр хэрэгжиж байгаа нийт 16 томоохон төсөл арга хэмжээ Захиргааны ерөнхий хуульд заасан төлөвлөлтийн сонсголыг хийх зохицуулалт байгаа. Сонсголын бэлтгэл ажлын явцад нийслэлээс төлөвлөлтийн сонсгол хийж олон нийтийн оролцоог хангасан эсэх асуудал дээр тодруулга авахад нийт 6 төсөл дээр сонсгол хийсэн талаар холбогдох материалуудыг ирүүлсэн байгаа.

Гэхдээ ирүүлсэн материалууд дээр тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хэрэгцээ шаардлагыг тооцох, олон нийтийн хүрээнд санал асуулга хийсэн судалгаа байгаа. Мөн Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг тухайн трасст өртөж байгаа зарим хорооны ИНХ-аар хэлэлцүүлсэн баримтыг ирүүлсэн. Тэгэхээр Захиргааны ерөнхий хуульд тухайн төслийг хэрэгжүүлэгч захиргааны байгууллага нь тухайн төсөл арга хэмжээг төсөвт өртөгийн тодорхой шийдвэрийг гаргахаас өмнө нийтийн сонсголыг хийнэ гэдэг зохицуулалт байгаа. Хэрэгжилтийн явцад зөвхөн хэрэгцээ шаардлагын судалгааг явуулсан трасст өртөж байгаа иргэд, ААН-үүдэд мэдээлэл хүргэсэн зэрэг нөхцөл байдал нь Захиргааны ерөнхий хуульд заасан төлөвлөлтийн сонсголыг зохих хууль журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Нэг тодорхой жишээ гэвэл 06 сарын 11-ний өдөр ирүүлсэн албан бичиг дээр Туулын хурдны замтай холбоотой гэрээ нь 2025 оны 8 сарын 12-нд байгуулагдсан байхад трасст өртөж байгаа иргэд дээр хэлэлцүүлэг явуулах арга хэмжээ нь 2025 оны 11 сараас 2026 оны нэг сар хүртэл явуулсан гэдэг тайлбарыг ирүүлсэн байгаа.

Тэгэхээр нэлээн хэдэн төсөл арга хэмжээнүүд нь төлөвлөлтийн сонсгол хийгдэхгүйгээр явуулж байгаа Захиргааны хуулийн ерөнхий хуулийг зөрчсөн нөхцөл байдалтай байна гэж үзэж байгаа.

Мөн төсөв батлахтай холбоотойгоор тодотгол хийж байгаа нөхцөл байдал байгаа. Тухайлбал 2024 онд нийтдээ 4 удаа, 2025 онд 5 удаа нийслэлийн төсөвт

тодотгол хийсэн байгаа. Тухайлбал 2025 онд хийсэн төсвийн тодотгол дээр үзэхэд Төсвийн тухай хуулийн 34.2.2 буюу урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас тодотгол хийж байгаа гэсэн хууль зүйн үндэслэлийг дурдсан боловч тодорхой төслүүд дээр дүгнэлт хийхэд Туулын хурдны зам дээр анх 900 тэрбумаар төсөв батлагдсан бол 2 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр 1.9, 1.2, 2.3 болж дээрээс нь... (минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хугацаа дууссан тул би үргэлжлүүлээд ерөнхий дүгнэлтийг нь уншаад өгье.

Хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдах шаардлага бүрэн хангагдаагүй байна. Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг тусгагдаагүй, Засаг даргын хөтөлбөрт хожим нэмэлтээр оруулсан, батлагдаагүй 2040 оны төлөвлөгөөг үндэслэсэн байна.

2-т нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төслүүдийг баталсан байна. ТЭЗҮ, зураг төсөв, газар, зөвшөөрөл магадлал, урсгал зардлын тооцоо, техникийн тодорхойлолт, олон нийтийн хэлэлцүүлэг дутуу төслүүд батлагдсан. Энэ нь төсөвт өртөг нэмэгдэх, ажил удаашрах, гэрээ сунгах, урьдчилгаа санхүүжилт үр ашиггүй олгох, хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах нөхцөл үүссэн гэж байна.

3-д нь олон нийтийн оролцоо бодитоор хангагдаагүй.

Дараагаар нь орон нутгийн өмчит компаниудын өсөлт ба чиг үүргийн давхардал их байна. 2024-2026 онд 24 байгууллага шинээр байгуулагдсан байна.

Нийслэлийн өмчит компани байгуулах хуулийн үндэслэл эргэлзээтэй байна. Хувийн хэвшил бүрэн хэрэгжүүлэх боломжтой хүнс хангамж, орон сууц, программ хангамж, тээвэр, хөрөнгө оруулалтын менежмент, захиалагчийн хяналтын чиглэлд Нийслэлийн өмчит байгууллагууд байгуулагджээ.

Ашиг сонирхлын зөрчлийн өндөр эрсдэл байна. НИТХ-ын төлөөлөгчид орон нутгийн өмчит байгууллагын удирдлага, ТУЗ-д ажиллаж, тухайн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг НИТХ дээр хэлэлцэн баталж байгаа.

Дараа нь өмчит компаниудын засаглал, үр ашиг хангалтгүй байна гэсэн нэгдсэн дүгнэлтийг хийсэн байна.

Цаашид гарах эрх зүйн эрсдэлүүд байна:

- Бодлого, төсөв, төлөвлөлтийн уялдааг төсөвт тусгахаас өмнө урьдчилсан шалгуураар баталгаажуулах;
- ТЭЗҮ, зураг төсөл, газар, зөвшөөрөл магадлал, сонсголын бүрдлийг төсөл, арга хэмжээ батлах үндсэн нөхцөл болгох;
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хэрэгцээ, зах зээлийн үндэслэл, гэрээний механизм, чиг үүргийн давхардлыг тусгайлан хянах;
- НИТХ-ын төлөөлөгчдийн ашиг сонирхлын зөрчил мэдүүлэх татгалзан оролцох баримтыг төсөв хөрөнгө оруулалтын шийдвэр бүрд ил тод болгох;
- Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгууллага албан тушаалтанд хариуцлага тооцох тогтолцоог хэрэгжүүлэх, гэсэн байна.

Хөтөлбөрийн дагуу төрийн байгууллага, шинжээчийн дүгнэлт, мэдээллийг

танилцууллаа.

Одоо сонсголд оролцогч санал, хүсэлт, мэдээллийг танилцуулна. Танхимд хүрэлцэн ирсэн оролцогчдоос урьдчилан нэр авсан байна. Ингээд оролцогч Б.Дөлгөөн 4 номер дээрээс үг хэлнэ үү?

Иргэн Б.Дөлгөөн: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Намайг Б.Дөлгөөн гэдэг Эрх зүйч мэргэжилтэй. Өнөөдрийн сонсголд оролцож байгаа хамгийн залуу оролцогч байх. Тэгээд хэдэн асуулт байгаа. Асуултын дараа хэдэн үг хэлэхээр байгаа.

Нийслэлийн дарга нараасаа хэдэн асуулт байгаа. Энэ хэрэгжиж буй томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийн явц ер нь хэр байгаа вэ? Хугацаандаа хэрэгжээгүй эсвэл удааширсан төслүүд хэр байна вэ? Шалтгаан нь яг юу байна вэ? Мөн төсөв өртөг нь нэмэгдсэн төслүүд байгаа юу? Нэмэгдсэн бол ямар шалтгаанаар нэмэгдэж байгаа вэ? гэсэн асуултууд байна. Энэ асуултуудад хариулж өгөхийг хүсье.

Өнөөдрийн сонсгол үр дүнтэй сонсгол байгаасай гэж залуу хүний хувьд бодож байгаа. УИХ-аар их сонсголуудыг хийж байна. Оюу толгойн сонсгол, Нүүрсний хулгайн сонсгол гээд, тэрний хажуугаар Нийслэлийн төсвийн сонсгол орж ирж байх шиг байна. Манай Туулын хурдны зам яригдаагүй байсан бол энэ сонсгол болох уу, үгүй юу гэдэг нь эргэлзээтэй байх байсан гэсэн үг.

Нийслэлээс хэрэгжүүлж байгаа Туулын хурдны зам, Улаанбаатар метро, Трамвай дэд бүтцийн төслүүд гээд түрүүн Хотын даргын хэлсэн төсөл хөтөлбөрүүд нийслэлдээ хэрэгтэй төсөл хөтөлбөрүүд гэж залуу хүний хувьд хараад байгаа. Энэ төслүүдийг нийслэлчүүд ерөнхийдөө хүсэж хүлээж байгаа. Энэ төслийг залуучууд ч хүлээж байгаа. Метротой болчихвол бид бүхэн яармагт 2 цаг түгжрээд байхгүй. Яармагаас Улаанбаатар хотын төв хүртэл 5 минут, 10 минутыг зарцуулж явах хэрэгтэй байгаа.

Нийслэлийн 2024, 2025, 2026 оны төсөвт хөтөлбөрүүдийг НИТХ-аар хэлэлцүүлсэн байх гэж бодож байгаа. Тухайн үед нийслэлийн 45 төлөөлөгч энэ асуудлуудыг бүгдийг нь мэдээд хэлэлцээд явж байсан байх.

Туулын хурдны зам одоо олон нийтэд ил болж байгаа хамгийн маргаан дагуулж байгаа асуудал. Дээр нь НИТХ-д МАН-ын 40 нийслэлийн төлөөлөгчийг буруутгаад байх боломжгүй. Тэнд АН-ын бүлгээс 5 төлөөлөгч суугаад хяналт тавьж байгаа байх.

Нийслэл дээр 45 төлөөлөгч сууж байгаа бол тэнд асуудлуудаа яагаад хэлэлцэж болохгүй байгаа юм бэ? Заавал УИХ дээр ирээд ярьдаг байх асуудал биш гэж залуу хүний хувьд харж байна. Тэнд асуудлаа ярилцах хэрэгтэй. Төсвийн асуудал юу байгаа юм, юу нь болохгүй байгаа гэдэг асуудлуудаа тэндээ хэлэлцэхгүй байж энд хэлэлцээд байж байдаг. Ерөнхийдөө үр дүнтэй хэлэлцэж байна уу гэдэг нь эргэлзээтэй байна.

Тэгэхээр төсөл хөтөлбөрүүдээ та бүхэн энэ сонсгол дуусахаар дараа нь дахин нягтлаад хамгийн боломжтой, хямд төсөвт өртгөөр эдгээр төслүүдээ явуулж өгөөрэй гэж хүсэж байна.

Метро трамвай гэдэг бол Улаанбаатарт шаардлагатай нэг номерын асуудлууд байгаа. Бас шинээр томилогдсон хотын дарга залуу хүн байгаа. Залуу үеийнхээ төлөөллүүдийн дуу хоолойг маш сайн сонсоорой гэж би танаас хүсмээр байна. Залуу хүний өнцгөөр харахад зарим зүйлүүд алдаатай байгаа байх. Зарим шийдвэрүүд нь зөв гарах байх гэж бодож байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Б.Дөлгөөний тавьсан асуултуудад хариу өгнө. Асуултуудад нь анхаарлаа.

Одоо иргэн Б.Ганбаяр 4 номер дээр мэдээлэл өгнө үү?

Иргэн Б.Ганбаяр: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Нийслэлийн иргэн бөгөөд нийслэлийн өмчийн оролцоотой ХК-ийн хувьцаа эзэмшиж байна.

Эхний асуулт Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюунмаагаас асуулт асууя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Уучлаарай, оролцогчид үг хэлэх дэгтэй байгаа. Асуулт асуухгүй.

Иргэн Б.Ганбаяр: Ойлголоо тэгвэл шууд эрх зүйн холбогдолтой саналаа хэлээд явчхаж болох уу?

Нийслэлээс гаргаж байгаа аливаа нээлттэй болон хаалттай бондуудын мэдээллийг үнэн зөв байх тал дээр анхаарах хэрэгтэй байна. Түүнтэй холбоотой мэдээллийг СЗХ болон Монголбанкны сайт дээр байршуулах хэрэгтэй байна. Одоогоор нийслэлийн 500 тэрбумын бондын эхний тайлан гараад түүнээс хойших бүх мэдээлэл ерөөсөө орохгүй байгаа.

2 дугаарт, бонд гаргахтай холбоотой андераторын үйлчилгээ үзүүлж байгаа ҮЦК-иуд анхнаасаа аудитын тайланд муу гарчихсан байгаа. Санхүүгийн үйл ажиллагааны тайлан муу гарчихсан байхад яагаад андераторын үйлчилгээ үзүүлсэн бэ? Энэ дээрээ цаашид эрх зүйн орчинд тодорхой өөрчлөлтүүдийг оруулмаар байна.

Дараагийн дугаарт нь, нийслэл болон орон нутгаас хэрэгжүүлж байгаа аливаа төсөл хөтөлбөр арга хэмжээ дээр соёлын биет болон биет бус өв, археологийн судалгаануудыг нарийвчилан хийдэг болмоор байна. Одоогоор хуульд зөвхөн археологийн судалгаа хийж байгаа. Тэгэхээр соёлын биет өв болсон үеийн судалгаа хийж, түүнийхээ үндсэн дээр энэ төсөл арга хэмжээнүүдийг явуулдаг болмоор байна. Энийг хэлж байгаа шалтгаан нь энэ яригдаад байгаа Туулын хурдны замын трасс буюу “Жи пи эс”-ээр тогтоогдсон координатууд дээр нь Монголын нууц товчоон дээр дурдагдсан хэд хэдэн газрууд орж ирж байгаа. Тэгэхээр бид нар өвөг дээдсийн соёлыг устгаад шууд бетон гүүр тавих нь зөв үү, буруу юу? гээд маш нарийн юмнууд явагдах ёстой. Тэгэхээр энийг цаашид хууль эрх зүйн орчинд маш тодорхой оруулж өгмөөр байна.

Аудитын тухай хуульд тодорхой өөрчлөлтүүдийг оруулмаар байна. Нийслэл болон орон нутгийн өмчтэй компаниудын захиргаа нь өөрөө бонд гаргах гэж байгаа бол тэр бондтой холбоотой аудитын дүгнэлт яаж гарснаас хамаараад бондын эрх нь нээгдэх вэ, хаагдах вэ гэдгээ тодорхой зааж өгөөгүйгээс болоод өнөөдөр ингээд улсаасаа их төсвийн алдагдалтай нийслэл нь яваад байж болохгүй байна. Тэгэхээр энэ бондтой холбоотой эдгээр өөрчлөлтүүдийг оруулах хэрэгтэй байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Иргэн Б.Өлзийбат үг хэлнэ.

Иргэн Б.Өлзийбат: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монголын Барилгачдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Б.Өлзийбат байна.

Өнөөдрийн сонсгол бол болох ёстой цаг үеэсээ бараг 4 жилийн дараа болж байгаа байх. Тэгэхлээр ардчилал гэдэг нээлттэй байж хамтдаа шийдвэр гаргах процесс. 3 зүйлийг зарчмын хувьд хэлчихье.

Асуулт асуухгүй учраас нэгдүгээрт, Засгийн газар хотын төсөвт тодорхой хянан шалгах ажлыг жил болгон явуулдаг байх шаардлагатай. Тийм учраас та нар энэ шүгэл үлээж байгаа хүмүүсийг хамгаалах чиглэл дээр Засгийн газар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг яаралтай өргөн бариач. Бараг 4, 5 жил боллоо.

2-т нь Төсвийн удирдлагын тухай хуулийг өргөн барина гээд Сангийн яам 2 жил дүлгэнэж байгаа. Сайд солигдохоор нэг юм ярьдаг. Тэгээд энэ хуулиудаа өргөн барь. Монголын төрийн байгуулалт бол нэгдмэл байх учиртай.

УИХ-ын Тамгын газарт зарчмын нэг асуудал хэлье. Би 4 дэх удаагаа сонсголд сууж байна. УИХ 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт оруулснаараа парламентын хяналт шалгалтыг бий болгосон. D.Parliament цахим хуудас иргэний оролцоог бий болгосон. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулийн 5.1-д сонсголд оролцсон болон татагдсан бүх материал ил тод нээлттэй байх ёстой. Өнөөдөр та бүхэн энэ системээ бүрэн хийгээгүй, хийж байгаа боловч ажиллаагүй. Үүнийгээ хэрэгжүүл иргэдийн мэдэх эрхийг нээж өг.

3-т нь Улаанбаатар хотын Засаг дарга Б.Пүрэвдагва даргад дайх үг байна. Нийслэлийн өнөөдрийн энэ замбараагүй зүйлүүд бол Нийтийн сонсголын тухай хуулийн 9.3-т заасан төсвийн хяналтын сонсголыг нэг нь ч хийгээгүй. Иргэдийн хурал нь бүгдээрээ баасан дээр шавсан ялаа шиг Засаг даргаа тойроод бүжчихсэн. Иргэдийн хурал гэдэг иргэдийн мэдэх эрхийг иргэдийн өмнөөс ярих ёстой. Өнөөдөр маш олон ААН-үүдийн дансыг хаачихсан, маш олон ААН-үүд өнөөдөр ажил хийж байж гүйцэтгэлээ авч чадахгүй байна. Үүн дээр Иргэдийн хурал санал тавих хэрэгтэй.

Шинэ Засаг дарга бодлогодоо анхаарна уу? Ирэх жилээс эхлээд төсвийн хяналтын сонсголыг жил бүр нь хийгээрэй.

Дараачийн нэг гол зүйлийг хэлье. Нийслэлийн төрийн байгууллагууд үнэхээр данхайсан. Нийслэл дээр зөвхөн барилга хот байгуулалтын чиглэлтэй 7 төсвийн ААН байна. Улаанбаатарын орон сууцын корпорац дээр маш их авлигал хээл хахууль явж байгаа. Энэ асуудлууд дээр онцгой анхаарах хэрэгтэй. Үүн дээр бүтцийн хувьд шинэ удирдлагууд анхаараарай.

Хот гэдэг бол иргэдээс бүтдэг. Хот гэдэг бол амгалан тайван байдлыг хэлдэг. Хот гэдэг бизнесийн орчин, ААН-үүдээ дэмжих ёстой. Өнөөдөр хотод 4 иргэн хүчтэй. Тэдний саналаар машины татвар нэмдэг. 33 мянган иргэн цахим дээр нэгдэхээр тэдний саналыг үгүй гэж хэлдэг. Ийм завхарсан хөл толгой нь тодорхойгүй болчихсон нь нийслэлийн хоттой. Тэгэхээр өнөөдрийн сонсгол маш чухал.

Нийслэлийн авто тээврийн татварыг санаачилсан Монгол Улсын иргэн Энхтөрийн Батбаяр хэлсэн байна. Иргэдийн амьдрал хүнд хэцүү байхад яагаад энэ татварыг нэмээд байгаа юм бэ гэдэг саналыг гаргаад 33 мянган иргэн дэмжээд парламентаар энэ асуудал яригдсан. Өнөөдөр ч ид шид нь гараагүй байгаа. Энэ УИХ-ын систем байсан тулдаа иргэд үгээ хэлдэг болсон.

Хот гэдэгт нэг номерт иргэдийн эрх ашиг. Мөнгөтэй, тендертэй, дарга хүчтэй байж болно. Сэтгэлгүй бол ямар ч нэмэргүй байхгүй юу. Тийм учраас энэ мэтчилэн төсвийнхөө сонсгол ил тод байдлыг нээлттэй болго. Маш олон ААН-үүдийн бизнес эрхлэх боломжийг бий болго. Өнөөдөр маш олон гүйлгээ хийгдээгүй байгаа. Нийслэлийнхэн юу авах гээд байдаг юм, юу хүлээгээд байдаг юм дампуурлаа. Шалгадаг юм нь тусдаа, ажил хийсэн бол тэр юмнуудыг нь өг дөө та нар. Тийм учраас нийслэл одоо иргэдийн оролцоог хангах хэрэгтэй байна. Япон байна, Солонгос байна, бүх хотууд нь өөрийн иргэдийн оролцооны системтэй, харин манай хотод байхгүй. Нийслэлийнхэн орж ирээд парламентыг загнана, даварчихсан. Бүгд дарга нар. Тэгэхлээр үүн дээр анхаараарай.

Би зарчмын асуудлууд хэлж байгаа. Төсөлтэй бол танилцчихсан. Анхнаас нь мэдэх эрхийн төлөө сонсгол хийж байгаа 25 гишүүн гишүүддээ маш их баярлалаа.

Иргэдийн энэ сонсголыг манай парламент өөрөө унагаадаг. Өмнөх сонсголуудын мөрөөр явдаггүй, систем дээр бүх мэдээллүүдийг хийдэггүй. Хэн ч энэ сонсгол дээр төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа. Болдог л юм, дуусдаг л юм. Олон жил дарга хийчихсэн үе үе дамжчихсан хүмүүс бол бүүр нэг гаарчихсан. Тэгэхлээр УИХ-ын гишүүн Д.Лодойсамбуу шинэ залуу гишүүд энэ парламентын хяналт шалгалтыг төгөлдөршүүлээд... ААН-үүдээ төлөөлж үг хэллээ. Маргааш илүү тодорхой баримттай үг хэлэх болно. Та бүхэнд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Өлзийбатын хэлсэн асуудал, асуултуудыг сонсголын хүрээнд анхаарна. Цахим систем, мэдээллийн ил тод, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг анхаарна гэж хэлье.

Ерөнхий хяналтын сонсголын хүрээнд цуглуулсан мэдээллийг хуулийн ямарваа хязгаарлалт байхгүй бүх мэдээллийг ил тод нийтэд мэдээлэх талаар УИХ-ын Тамгын газар ажиллаарай гэж чиглэл өгье. Энийг бол бид нар линк байршуулж болно мэйлээр хүргэж болно. Ямар ч байсан хуулиар хязгаарлагдаагүй мэдээллийг ил тод тавих ёстой. Энийг анхаарч ажиллая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.9 оролцогч санал, тайлбар, мэдээлэл сонс сонсгол болохоос ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр өгч болно; гэж заасны дагуу 10 оролцогчоос санал, хүсэлт, мэдээллийн хүсэлтийг бичгээ ирүүлсэн байгаа. Мөн хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.7-д “сонсгол даргалагч сонсож байгаа асуудалтай холбогдуулан бичгээр ирүүлсэн санал хүсэлт мэдээллийн агуулгыг уншиж танилцуулна” гэж заасны дагуу Та бүхэнд уншиж танилцуулъя. Төслүүдийн талаар болоод нийслэлийн зарим нь их тодорхой төсөл хөндсөн, зарим нь бодлогын чанартай зүйлс байна. Үүнийг Ч.Лодойсамбуу гишүүн уншиж өгч хамтарч ажиллана уу.

УИХ-ын гишүүн Х.Лодойсамбуу: Иргэн Б.Нямаасүрэн 2026 оны 06 дугаар

сарын 04-нд ирүүлсэн байна. Сэлбэ төв дахин төлөвлөлтийн нэрийн дор иргэний цалингийн зээлээр авсан хууль ёсны 347 м.кв өмчлөх газрыг зүгээр дээрэмдэж аваад газар дээр маань дахин төлөвлөлтийн барилга барьж байгаад гомдолтой байна. Би дахин төлөвлөлтийг эсэргүүцээгүй. Гэхдээ тохиролцоонд хүрэх ямар ч боломжгүй үнэлгээний мөнгө 93.000.000 төгрөгөө өгөөд 104 м.кв байрыг 5 жилийн хугацаанд Нийслэлийн орон сууц корпорацын зээлээр авахыг санал болгосон. Үнэхээр утаа, түгжрэлийг шийдэж иргэнтэй ээлтэй хот төлөвлөсөн бол иргэндээ байрын зээлгүйгээр өгөөд авахад надад гомдол байхгүй. Харин ч баярлах байсан. Гэтэл Нийслэлийн удирдлагууд иргэдийнхээ үндэс өмч болох газрыг нэг өдөр ирэхэд хашаа, амбаар, 00, хашаан дотор байсан 36 м.кв үл хөдлөхийн гэрчилгээтэй байсан байшингаа буулгасан палк, болон банз, газрыг нь дээрэмдэж аваад үнэлгээний мөнгөө аваад яв гэдэг дарангуйлалын хариу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирсэн. Тохиролцооны уулзалтад иргэний өмчийг буулгаж газар дээр барилгын суурь цутгаж байгаад гомдож маргаан үүсгэсэн, ямар ч хүн гэртээ ирэхэд төр нь иргэнээ гудамжинд хөөж гаргаад иргэний хууль ёсны өмчилсөн газраас ашиг харж дээрэмдэж авсан төрдөө гомдсон. Ардчилсан улсад хувийн хууль ёсны өмчийг дээрэмдэж авч байгаад гомдож байна.

2 дугаарт, иргэн М.Одбаяр 2026 оны 06 дугаар сарын 04-нд саналаа ирүүлсэн. Нийслэлийн төсөв улмаар дүүрэг, хорооны төсөв ил тод нээлттэй байлгах тухай санал ирүүлсэн юм байна. Нээлттэй байлгаач гэдэг санал ирүүлсэн юм байна.

3 дугаарт, иргэн О.Отгонбаяр 06 дугаар сарын 04-нд санал ирүүлсэн. Нийслэлийн төсөв 10 жилд бараг 10 дахин өссөн цаашид ч өсөх байх. Тэгэхээр төсөв их байх тусам захиран зарцуулахад хяналттай татвар төлөгчдөд нээлттэй байх нь зөв гэсэн санал ирүүлсэн.

4 дүгээрт, Ж.Өсөхбаяр иргэн 06 дугаар сарын 04-нд саналаа ирүүлсэн. Маш их үргүй зардал гарган Нийслэл хотын дундуур урсдаг гурван голыг маш ихээр сүйтгэсэн ажлуудын төсөв гүйцэтгэлийг шалгах байх гэж найдаж байна. Туул голын хурдны замын хувьд та бүхэн анхаарч лавлаж байгаа байх. Миний хувьд

- Сэлбэ голын заслын ажил. Маш өндөр өртгөөр удаан үргэлжилсэн боловч өнөөдрийг хүртэл дуусаагүй, Яагаад? Голын Эко бүтэцтэй холбоотой бүх бичиг баримтуудаа бүрдүүлсэн эсэх. Яг Туулын хурдны зам шиг бүх бичиг баримт нь асуудалтай байх болов уу даа. Төсвөөс гадна БОННУ хэрхэн хийгдсэн, ТЭЗҮ бас хэн яаж хийсэн талаар шалгах. Амьд амьтны үнэлгээг бас хийсэн эсэхийг нарийвчлан үзэх. Хариуцлага яаж тооцох вэ?

- Дунд голын заслын ажил. БОННУ хийгдсэн эсэх, төсөвт өртөг хэр байна, ТЭЗҮ хэн хэрхэн хийсэн, сонгон шалгаруулалт хэрхэн явагдсан. Ажлын гүйцэтгэл юу болсон. Нөхөн сэргээлт хэрхэн хийгдсэн гэж ирээд шалгах. Одоо бол өмхий шалбааг л болсон. Хариуцлага хэрхэн тооцох эсэх?

- Түлшний хангамжийн хүрэлцээний талаар нэмж асууж шалгаасай хэмээн хүсэж байна. 2025 оны өвөл утаа багассан гэж иргэдээ басамжлан мэдэгдэхдээ түлшний хувьд савлагаа жиндээ хүрдэггүй 21-22 кг, түгээлт худалдаалах цэг хүртээмж муу, хурдан дуусдаг, ажлын цагаар борлуулдаг учир хүмүүс ажлаа тараад түлшээ авч чаддаггүй, хязгаарлалттай өгдөг учир гал тасрах аюул их байсан. Энэ жил давтагдах вий дээ.

Энэ бүхнийг шалгахаас гадна буруутай этгээдүүдэд ямар хариуцлага яаж

тооцохыг иргэдэд мэдээлэхийг хүсэж байна гэсэн байна.

5 дугаарт Д.Энхтүвшин 06 дугаар сарын 05-нд саналаа ирүүлсэн. Автобусаар зорчих сонирхол ихтэй ч гэрээсээ гараад автобусны буудал орох замдаа явганаасаа бэртчих гээд байх юм. Уг нь манайх УБ-ын төв цэгээс 1км хүрэхгүй зайд Энхтайваны өргөн чөлөө, ... гэсэн хаягт байдаг. Гэтэл ийм хүндрэл үүсээд байх юм. Нийслэл юун түрүүнд явган зорчигчдын аюулгүй байдалд анхаарлаа хандуулж, хөрөнгө оруулалтаа тийш нь чиглүүлэх нэн шаардлагатай гэж үзэж байна гэсэн санал байна.

6 дугаарт Ө.Хүдэрбаяр 06 дугаар сарын 09-нд саналаа ирүүлсэн. Хэрвээ сонсголын сэдэв, хамрах хүрээ, журамд нийцэж байгаа бол дараах сэдвийг хөндөнө үү?

- Нийслэлийн нийт төсвийн дотор урсгал зардал, орон тоо, албан тушаалтнууд, зөвлөх үйлчилгээ, зөвлөхүүд, шинээр байгуулагдсан харьяа агентлаг, төслийн нэгж, орон нутгийн өмчит компаниуд, тэдгээрт гарч байгаа зардал, үйл ажиллагааны үр дүнгийн талаар;

- Нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нэгдсэн цогцолборыг Яармагт байгуулж, түүнд гарсан нийт хөрөнгө оруулалт, зардал, анх зарласнаар түгжрэлийг бууруулахад ямар хувь нэмэр оруулсан талаар;

- Нийслэлийн төвийн болон дэд бүтцэд холбогдсон байршилд газрын дуудлага худалдаагаар зарж олох байсан орлогын алдагдсан боломжийн талаар;

- Нийслэлийн нийт өр, зээл, өнгөрсөн 2-3 жилд босгосон нийслэлийн дотоод ба гадаад бондуудын зарцуулалтын талаар нээлттэй мэдээлэл авмаар байна гэсэн байна.

7 дугаарт, Иргэн Д.Энхтуул 06 дугаар сарын 09-нд саналаа ирүүлсэн.

Асуулт 1: 2024 онд Энхтайваны гүүрнээс Тэмээтэй хөшөө хүртэлх замыг "Трүй Рөүд" компани 2.8 тэрбум төгрөгөөр засахдаа технологийн алдаа гаргаж тус тэгш бус байдлыг нь алдагдуулсан. Ингэж энхэл донхол болгосон замаа ахиад засна гэж "Трүй Рөүд" компани мэдэгдсэн. Мөн Нийслэлээс тус компаниар засуулна гэсэн боловч өнөөдрийг хүртэл засуулаагүй байна.

- Яагаад засуулаагүй вэ?
- Тус ажлыг комисс хүлээж авсан эсэх?
- Санхүүжилт нь бүрэн төлөгдсөн үү?
- Энэ компани ахин улсын болон нийслэлийн тендерт шалгарсан эсэх

Асуулт 2: Баянгол дүүргийн нутаг дэвсгэр "Барс" худалдааны төвийн хойд талын цэцэрлэгт хүрээлэнд УБТЗ-ын эзэмшлийн газар дээр баригдаж байгаа машины зогсоол

- Тус замыг ямар компани гүйцэтгэж байгаа вэ?
- Тендер зарласан эсэх?
- УБТЗ нь ОХУ-тай хамтарсан байгууллага тул тус объектыг барих талаар ОХУ-тай зөвшилцсөн ТУЗ-ийн шийдвэр байгаа эсэх?

Асуулт 3: Хан Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших Нисэхийн тойргийг давхар гүүрэн замын уулзвар болгоно гэж 2024 онд ажил эхэлсэн боловч дутуу орхисон,

2025 онд ахин нэг ч ажил хийгдээгүй.

- Тус замыг ямар компани гүйцэтгэж байгаа вэ?
- Тендер зарласан эсэх?
- Тус ажлыг комисс хүлээж авсан эсэх?
- Санхүүжилт нь бүрэн төлөгдсөн үү?
- Энэ компани ахин улсын болон нийслэлийн тендерт шалгарсан эсэх?

Асуулт 4: Нийслэлийн өмнөх удирдлагууд 100 айл, СБД-ийн 9, 11-р хорооны айлуудыг нүүлгэн худалдан авч Үндэсний урлагийн театр барих газрыг бүрэн чөлөөлсөн ч одоогийн удирдлага газар дээр нь орон сууц барих зөвшөөрөл олгочхоод одоо Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн газар луу "дайрч" байгааг хууль хяналтын байгууллага, засгийн газар шалгах хэрэгтэй.

- Үндэсний урлагийн театр барих газрыг бүрэн чөлөөлсөн нь үнэн үү?
- Худал хэлэн чөлөөлсөн тус газар дээр ямар барилгын компаниуд орон сууцны барилга барьсан бэ? Тендер зарласан уу?
- Одоо цэцэрлэгт хүрээлэнгийн газар луу дайрч байгаа нь Үндэсний урлагийн театр барих зорилготой юу. Хятадуудад газар худалдах зорилготой юу? гэж асуусан байна.

8 дугаарт иргэн Г.Эрдэнээ 6 дугаар сарын 9-нд асуулт ирүүлсэн.

БГД-ээс НИТХ-д сонгогдсон н.Сэмжидмаа нарын 6 гишүүн болон Нийслэлийн Засаг дарга асан Х.Нямбаатар нарын 7 төлөөлөгч санаачилсан “Гандантэгчилэн хийд орчмыг цэцэрлэгт хүрээлэн болгон өөрчлөх тухай” 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 26/31 тоот тогтоолыг НИТХ-аар батлуулсан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч асан Х.Нямбаатарын 2024 оны 05 сарын 20-ны өдрийн А/575 тоот (“Гандантэгчилэн хийд” орчимд газар олголт болон барилгын үе шатны зөвшөөрлүүдийг олгохыг түр зогсоох тухай) захирамжийн улмаас иргэд өөрсдийн эзэмшил, өмчлөлийн газарт барилга, бүтээн байгуулалт хийж, ажлын байр бий болгох, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжгүй байдалд хоёр жил гаруй болж байна.

1.2025-2026 оны нийслэлийн төсвөөс Гандан орчимд 1.8 га газрыг чөлөөлөхдөө (1м.кв газрыг 1,2 сая төгрөгөөр үнэлэн авсан) газар болон үл хөдлөх хөрөнгөнд нь хэдэн иргэнд, нийт хэдэн төгрөг зарцуулсан бэ?

2.2026 онд Гандан орчимд нэмж хэчнээн га газрыг чөлөөлөхөд хэдэн төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байгаа вэ?

3.Гандан орчмын төлөвлөлт, чөлөөлөхтэй холбоотой 20 гаруй тэрбум төгрөгийг 2026 оны улсын төсөвт суулгуулсан нь зарцуулагдсан уу, үүнийг яг ямар зориулалтаар ашиглахаар тусгуулсан вэ?

4.Дээрх 26/31 тоот тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Гандан орчмын 50 га газрыг чөлөөлөхөд хагас их наяд орчим төгрөгийг зарцуулахаар байгаагаас гадна газар дээрх үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь түүнээс ч өндөр дүн гарахаар болов уу. УБ хотын нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагагүй ийм төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэрээр татвар төлөгчдийн мөнгийг зарцуулах явдлыг эсэргүүцэж байна. Хувийн хэвшилд бүтээн байгуулалт хийх эрх чөлөөг олгож нийслэлийн төсвөөр хийгдэж ашиглалтгүй шахам байгаа дэд бүтцийн шугам хоолойд түшиглэн Гандан орчмын

хөрсний болон агаарын бохирдлыг шийдвэрлүүлэх бүрэн боломжтой гэсэн байна.

Иргэдээс бичгээр ирсэн саналууд учраас үг үсгийн алдаатай, цэг таслалууд нь замбараагүй байгааг сонсож байгаа хүмүүс ойлгож хүлцээрэй.

9 дүгээрт иргэн Ц.Батболд 06 дугаар сарын 09-нд саналаа ирүүлсэн байна.

Би Туулын хурдны зам төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг баталсан НИТХ-ын шийдвэрийг илт хууль бус болохыг тогтоолгохоор Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан хуульч байна.

Тус сонсголд оролцож захиргааны хэргийн ажиллагааны явц болон Үндсэн хуулийн 59.1 дүгээр зүйлд заасан "...нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ." гэсэн заалтыг өнөөг хүртэл буруу ойлгож ирснээс олон хууль бус асуудал үүссэн. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл буюу Захиргааны үйл ажиллагааны үндсэн зарчим одоогийн захиргааны байгууллагад мөрдөгдөж, хэрэгждэггүй учраас нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхол байнга хөндөгдөж байгаагийн нэг нь "Туулын хурдны зам" төсөл хөтөлбөр байсан талаар санал хэлж, өөрийн биеэр оролцмоор байна гэсэн. Энэ хүсэлтийг нь авсан байгаа.

10 дугаарт иргэн Э.Тэмүүжин 06 дугаар сарын 10-нд санал ирүүлсэн. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үүднээс хэрэгжүүлсэн төслүүдийн талаар асуулт асууж бодитой хариулт авмаар байна гэсэн байна.

Саналыг уншиж дууслаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Урьдчилж бичгээр ирүүлсэн саналыг Та бүхэндээ уншиж танилцууллаа. Бичгээр ирүүлсэн санал дээрх үндсэн асуудлуудыг үдээс хойш УИХ-ын гишүүд асуулт хариултынхаа цагийн үед анхаарч асууж хариулна гэж бодож байна.

Нэгдүгээрт нь нийслэлээс хэрэгжүүлж буй мега төслүүдийн төсвийн гүйцэтгэл, тодотгол, аудитын тайлан дүгнэлт гэсэн. Энд эдийн засгийн үр ашгийн талаарх хураангуй танилцуулгыг шинжээч Б.Данаасүрэн хийнэ.

2 дугаарт нь АТГ-аас мэдээлэл өгөх ёстой. АТГ-аас ажлын хэсгийн дарга УИХ-ын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танаа гээд албан бичиг ирүүлсэн. Энэ бичгийн агуулга нь болохоор хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр мэдэгдэх бололцоотой. Тэгээд зөвшөөрөл аваагүй учраас цаасаар мэдээлэл хүргүүлж байна гэсэн ийм агуулгатай. Гэхдээ энд 2 зүйл байна.

Энэ хөтөлбөрт орсон агуулгаар нийслэлийн хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буй хэргийн талаарх мэдээлэл. Нийслэлийн хэмжээнд 2024 оноос хойш хийсэн авлига ашиг сонирхлын зөрчлийн талаарх судалгаа авсан арга хэмжээний талаар мэдээлэл хийхийг хүссэн.

Тэгээд хурал даргалагчийн зүгээс хэлэхэд энэ бол хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын материал биш учраас прокурорын зөвшөөрөлд хамаарахгүй гэж үзэж байгаа. Ажил хариуцсан төрийн байгууллагаас сүүлийн жилүүдэд ямар ажил хийсэн хэчнээн хэмжээний шалгалт явуулсан тоон мэдээлэл ерөнхий мэдээллийг ерөнхий хяналтын сонсгол дээр ирж мэдээлэл хийхийг хүсье.

Энийг Тамгын газрынхан дамжуулж өгөөрэй гэж хүсье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сонсголоо эхлүүлье. Үдээс өмнө хийсэн сонсголын үеэр хийгдсэн танилцуулгуудаас та бүхэндээ товчхон эргээд нэг хэдэн тоо сануулъя.

Нийслэлийн төсвүүд сүүлийн жилүүдэд их өргөн хурдацтай өссөнөөс үүдээд төсвийн алдагдал 2,4 их наяд, Монгол Улсын төсвийн алдагдал 1,4 их наяд байна гэж танилцуулсан.

Энэ өрийн баталгаа, бондын баталгааг Засгийн газар гаргаж өгсөн. Засгийн газрын баталгаа буцаад УИХ дээр төсөв өргөн баригдана. Тэгэхээр төсвийн алдагдал эдийн засагт хувь нөлөө шууд харагдаж байна гэж танилцуулсан.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 2026 онд 4,6 их наядаар батлагдаад гүйцэтгэл нь 0,6 их наяд байна. Нийслэлийн үнэт цаас 2,9 их наяд. Засгийн газраас зөвшөөрөгдсөн үнэт цаас 2,9 их наяд, нийслэлээс гарсан үнэт цаас 2,7 их наяд үүнээс үлдэгдэл нь 2,6 их наяд байна.

Хувийн хэвшлийн хийх боломжтой бүрэн чадвартай хүнсний үйлдвэрлэл, орон сууц, программ хангамж, тээвэр, хөрөнгө оруулалтын менежмент гэх мэтчилэн бизнесийн үйл ажиллагаа дээр ААН олноор нь байгуулж ажилласан байна гэж шинжээчийн танилцуулгаар хүрлээ. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ гээд нийт 44.7 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд дээр дамжуулж хийсэн байна. Үүний задаргаа нь байхгүй гэж танилцуулсан.

Нийтдээ 16 мега төслийн нийт хөрөнгө оруулалтын дүн нь 28,9 их наяд байна. Энэ нь 2025 оны улсын төсөвтэй харьцуулахад бараг 93%-тай тэнцүү байгаа. Энэ том тээврийн төслүүд метро, трам, Эл Ар Ти, хөнгөн галт тэрэг, тусгай замын автобус, дүүжин тээвэр, хурдны зам, тойрог, энэ төслүүдийн хоорондын уялдаа холбоо, нийлбэр хүчин чадал тодорхойгүй байна гэсэн шинжээчийн дүгнэлтийг танилцууллаа.

Нийслэлд олон тооны ААН-үүд, компаниуд байгуулаад ажиллаж байгаа ХХК-иуд байна. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд байна. Тэгээд энэ компаниуд дээр нийслэлд албан тушаал хашиж байгаа иргэдийн төлөөлөгч нар удирдлагад нь ажиллаж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл үүсгэж байна гэж шинжээчийн танилцуулгаар та бүхэнд хүрсэн.

Эрчим хүч, нүүрсний уурхай, тээвэр, программ хангамж гэх мэтчилэн олон төрлийн үйл ажиллагааг энэ компаниудаар дамжуулж хийж байна гэх мэтчилэн мэдээлэл байна.

Ингээд үдээс хойших сонсголын 2 илтгэл яваад, тэгээд УИХ-ын гишүүдийн асуулт хариулт явна. Илтгэл тус бүр хуулиар 10 минутад багтааж илтгэлээ танилцуулна. Эхний илтгэл нийслэлээс хэрэгжүүлж буй мега төслүүдийн төсвийн гүйцэтгэлийн талаар шинжээч Б.Данаасүрэн дүгнэлт хэлнэ.

Шинжээч Б.Данаасүрэн: Сайн байцгаана уу, Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Миний сэдвийн хувьд аудитын дүгнэлт гэсэн байгаа. Гэхдээ энэ төслүүд нь хэрэгжиж дуусаагүй, дээрээс нь ТЭЗҮ дээр, Туулын хурдны замын төсөл дээр маргааш Аудитын газрын дарга нь өөрөө дүгнэлтээ хэлэх учраас энэхүү дүгнэлтээ

нийслэлээс хэрэгжүүлж байгаа мега төслүүдийн төсвийн гүйцэтгэл, эдийн засаг, санхүүгийн шинжилгээнд хийсэн дүгнэлт гэсэн энэ агуулгын хүрээнд ярья.

Эдгээр төслүүдийг харахад 39% нь олон төрөлт тээврийн хэрэгслийн авто замын сайжруулалтаар 30% нь, дулааны 5 дугаар станц, орон сууцжуулалт гэх мэтчилэн төслүүд байгаа.

Сая гишүүний хэлснээр 28,9 их наядын төсөвт өртөгтэй 16 төслийн төсөвт өртөг нь 2025 оны орон нутгийн нийт төсвөөс 3.6 дахин, Улаанбаатар хотын төсвөөс өөрөөс нь 6.5 дахин их мөнгөн дүн байгаа учраас эдгээр төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай зарцуулах нь маш чухал асуудал байгаа. Энэ төслүүдийн хувьд төсөвт өртгөөр нь харьцуулаад үзвэл Метроны төсөл 30%-ийг буюу хамгийн их хувийг эзэлж байгаа. Дараа нь 1, 2 дугаар тойрог зам, Сэлбэ 5 дугаар дулааны станц, нөгөө талаас Туулын хурдны зам гэсэн төслүүд бараг 70 хувийг нь дангаараа эзэлж байгаа 6 төсөл байгаа. Энэ төслүүдийн хувьд төсөвт өртөг нэлээн өндөр учраас эдгээрийн зарцуулалт нь хэр байна, төсвийн гүйцэтгэл нь хэр явагдаж байна гэдэг нь их анхаарал татсан асуудал. Тэр үүднээс бидэнд ирсэн мэдээлэлд суурилж судалгаа хийгээд үзэхэд нийт 16 төслийн 10 төсөл нь 2025-2027 он хүртэл ихэнх нь хэрэгжих төслүүд байгаа.

Цаг хугацааны хувьд хэрэгжих хугацаа дундаа орчхоод байхад эдгээр төслийн гүйцэтгэл нь ямар байна гэдэг нь их чухал ач холбогдолтой үзүүлэлт байдаг. Эндээс харахад нийт 28,9 их наяд төсөвт өртгийнхөө 5%-ийг нь одоогоор зарцуулсан байна. Энэ зарцуулалт дээр дүүжин замын тээврийн зарцуулалт бол 26%-тай, Туулын хурдны зам болон Баянхошуу дэд төвийн зарцуулалтууд 21-22%-тай байна. Бусад төслүүдийн хувьд зарцуулалт нэлээн хангалтгүй байгаа нь төсвийн төслийн бэлтгэл хэр хангагдсан, санхүүжилтийнхээ эх үүсвэрийг бүрэн шийдсэн эсэх, төслийн удирдлагын хүрээнд хэр үр дүнтэй нэгдсэн удирдлагаар хангаж байна гэдгийг одоо төсвийн гүйцэтгэл харуулж байгаа. 2026 онд нийт төсөвт өртгийнхөө 22.3%-ийг буюу 6,4 их наядыг зарцуулахаар төлөвлөсөн. Гэхдээ яг одоогийн байдлаар гүйцэтгэл нь нэг хувь хүрэхгүй байгаа. Тэгэхээр төслүүд яг цаг хугацаанд хэрэгжих үү, дээрээс нь төслийн хүрээнд гарч ирж байгаа санхүүжилтүүд нь бүрэн шийдэгдсэн үү гэдэг нь их чухал байгаа. Тэгэхээр эндээс та бүхэн харж болж байгаа байх. Төсвийн зарцуулалт, гүйцэтгэл хангалтгүй байна мөн төслийн бэлтгэл хэр хангагдсан бэ гэдгийг өмнөх шинжээчид дүгнэсэн.

Төсвийн бэлтгэлийн явцад хангалттай боловсруулалт хийгдээгүй төсөл цаг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлүүд байгааг манай шинжээчид тодорхой хэлсэн байгаа. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой нэг асуудал бол 5 хувийн гүйцэтгэлтэй байна гэдэг нь өөрөө санхүүжилтийн эх үүсвэрүүд нь шийдэгдсэн үү гэдгээс хамаарч байгаа.

Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд 6 эх үүсвэрээс санхүүжүүлэхээр энэ төслүүдэд тусгасан байгаа. Төр, хувийн хэвшлийн түншлэл 25%-ийг, нийслэлийн төсвөөс 19%-ийг, улсын төсвөөс бол багахан хувь гарч байгаа, буцалтгүй тусламж 2%-ийг гээд санхүүжилтийн 6 эх үүсвэр дотор гадаад зээл, гадаад бонд буюу нийтдээ 54% буюу 15,5 их наяд төгрөгийг гаднын зээлээр санхүүжүүлнэ гээд заачихсан байгаа. Гаднын зээл, гаднын бонд 2 бол агуулгын хувьд яг адилхан зээл. Тэгэхээр зээл гэдэг буцааж төлөгдөх учраас зээлийг цаг хугацаанд нь зөв зохистой ашиглах, эргээд зээлээр санхүүжих төслүүд аль болох үр ашигтай, өгөөжтэй байх нь их чухал байдаг. Ингэж байж санхүүгийн ачаалал, төсөвт ирэх дарамт багасна. Тэгвэл энэ үүднээс санхүү эдийн засгийн шинжилгээнүүд хийгддэг. Санхүү, эдийн

засгийн шинжилгээг хийхдээ Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын 278 дугаар тогтоолууд байгаа. Эдгээр төслүүдийн нийгэм эдийн засгийн үр нөлөө эдийн засгийн үр ашиг хөрөнгө оруулалт нь өгөөжтэй юу гэдгийг тооцох, нөгөө талаас энэ төслүүд төсөвт хэрхэн нөлөөлөх вэ гэдэг ачааллыг нь тооцохыг хуулиар шаарддаг.

Энэ шаардлага хэр хангагдаж байна гэдгийг эдийн засаг санхүүгийн шинжилгээ дээр хийж үзсэн. Төсвийн тухай хуулийн 28.1-ээр энэ 16 төсөл бүгдээрээ 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй дэд бүтэц хөгжлийн хөрөнгө оруулалтын төслүүд учраас томоохон төсөл гэдэг ангилалд орно. 16 мега төслөөс төсөвт өртгийн 70%-ийг бүрдүүлж байгаа 6 төсөл дээр илүү төвлөрч ажилласан байгаа. Эдгээрийн нийт төсөвт өртөг 20.3 их наяд байгаа. Эдгээр төсөл дээр эдийн засаг, санхүүгийн шинжилгээ хэр хийв гэдгийг харж үзэхэд 6 төслийн хувьд нэгээс бусад дээр нь эдийн засгийн хувьд өгөөжтэй гэж гаргасан байгаа.

Сэлбэ төслийн хувьд эдийн засаг, санхүүгийн шинжилгээг яг бүрэн утгаар нь хийгээгүй. Зөвхөн ерөнхий эдийн засаг дээр свот шинжилгээ хийсэн гээд орхисон байгаа. Сэлбэ төсөл үнэхээр эдийн засгийн болон санхүүгийн хувьд өгөөжтэй байсан уу гэдэг тооцоолол нь байхгүй гэсэн үг.

Тооцооллуудыг харж байхад нийтлэг ажиглагдаж байгаа зүйл бол тооцооллыг өөр өөр стандартаар хийсэн учраас хооронд нь харьцуулахад төвөгтэй. Зарим нь Хятадын компани, зарим нь Солонгосын компани, дийлэнх нь Монгол компаниуд. Тэгэхээр тодорхой аргачлал эдийн засаг, санхүүгийн шинжилгээ дээр бүрэн хангагдаагүй. Төсөөлөл нь их өөдрөг байсан учраас эдийн засгийн хувьд өгөөжтэй гэсэн агуулгууд гарсан.

Жишээлбэл, Туул хурдны замын төсөл дээр хэт өөдрөг төсөөлөл гарсан. Тээврийн хэрэгслийн ашиглалтын зардал зорчих хугацааны хэмнэлт гэдэг 2 зүйлийг өгөөж гэж үзээд түрүүн хэлсэнчлэн байгаль орчин, соёлын гэх мэтчилэн нөлөөллийг зардал байдлаар мөнгөн дүнгээр илэрхийлж тооцоололд оруулаагүй. Тийм болохоор, Туул хурдны төсөл дээр цэвэр өнөөгийн үнэ цэний аргаар тооцсон дүн нь 255.4 буюу нийт төсөвт өртгийн 38%-тай тэнцэхүйцээр ашигтай ажиллана гэсэн эдийн засгийн төсөөллийг гаргасан байна. Энэ нь үнэхээр бодитой юу гэдэг нь тун эргэлзээтэй байгаа.

Шинжээчийн хувьд дүгнэлт хийхэд, санхүүжилтийн эх үүсвэрүүд нь бодитой шийдвэрлэгдээгүй мега төслүүдийн хувьд хугацаа хойшлох эрсдэл маш их байна. Яагаад гэвэл өнөөг хүртэл санхүүжилтийн 5-хан хувь нь зарцуулагдсан байна. Хугацаа хойшилно гэдэг төсөвт өртгийг нэмэгдүүлнэ. Гадаадын зээлийн хувьд ашиглалт хангалтгүй болно. Эргээд зээлээ төлөх эрсдэл нэлээн их байгаа.

Түүнчлэн ижил төрлийн төслүүд их байна. Жишээлбэл Метро, Эл Ар Ти, Би Ар Ти, дүүжин тээвэр, хурдны зам нь бүгдээрээ түгжрэлийг бууруулах гэсэн ерөнхий зорилгын хүрээнд хийгдэж байгаа. Эдгээр бүх ажил нэгэн зэрэг ашиглалтад орохоор түгжрэл хэдэн хувиар буурах вэ? Нөгөө талаар эдгээр төслүүдийн нийлмэл нөлөөллийг үзэхээр төсөл болгоны ТЭЗҮ дээр гараад байгаа шиг тийм их олон хүн зорчиж чадах уу? Яагаад гэвэл зорчигчид хуваагдах учраас энэ төслийн өгөөжүүд нь дандаа буурах магадлалтай харагдаж байна.

Төслүүдийн эдийн засгийн шинжилгээ дээр зөвхөн эерэг нөлөөг авч үзсэнээс биш тухайн төсөл байгаль орчин, нийгэм, бусад одоо хүчин зүйлд ямар сөрөг

нөлөөлөл орох вэ гэдгийг мөнгөн дүнгээр илэрхийлж тооцоолоогүй учраас эдийн засгийн өгөөж өнөөгийн үнэ цэн нь хэт их өөдрөгөөр төсөөлсөн, бодитой бус байх магадлалтай гэж дүгнэж байна.

Шинжээчийн хувьд дараах 3 чиглэлээр зөвлөмж өгч байна.

Төлөвлөлтийн шат дээр Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын тогтоолд заасан шаардлагуудыг ТЭЗҮ дээр бүрэн хангаж боловсруулалт хийдэг болох;

Тендер зарлахдаа эдийн засаг, санхүүгийн шинжилгээг нэгдсэн стандартаар хийхгүй бол харьцуулагдахад төвөгтэй байгааг анхаарч үзэх;

Төслүүдийн хувьд төсөвт үзүүлэх ачааллыг тооцоогүй, зээлийн эргэн төлөлтийг нарийн тодорхой тусгагдаагүй дутагдалтай тал ажиглагдсан. Энийг цаашид засаж залруулах;

Төслийг батлах шатанд Улаанбаатар хотод энэ төслүүдийг эрэмбэлдэг тодорхой аргачлал байхгүй байна. Сангийн яаман дээр эрэмбэлэлтийг тодорхой хэмжээнд хийдэг. Нийслэл дээр аргачлал байхгүй гэдгийг бид тодруулсан. Энэ хүрээнд нэг ижил аргачлалаар төслүүдийн ач холбогдлын зэрэглэлээр нь эдийн засаг, нийгэмд үзүүлэх өгөөж, Төсвийн тухай хууль болон Өрийн удирдлагын хуульд заасан шаардлагуудыг хангасан байдлаар эрэмбэлээд хамгийн ач холбогдолтой төслүүдээ сонгох ёстой. Энэ үйл явц нийслэл дээр явагддаггүй юм байна. Иймд цаашид анхаарч эрэмбэлэлтэй хийдэг болох;

Ил тод байдлыг хангах үүднээс төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналыг нийтэд ил тод болгох нь чухал байна. Сангийн яамны Пи Ми систем дээрээс Туулын хурдны зам, Хүннү хотын зураг төслийн төсвийн мэдээлэл байна. Бусад мэдээлэл байхгүй байгаа учраас иргэд мэдэх боломжгүй байна. Иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах тухай заасан хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллах хэрэгтэй байна гэсэн дүгнэлтийг өгч байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Дараагийнх нь АТГ-аас нийслэлийн хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буй хэргийн талаар мэдээлэл, нийслэлийн хэмжээнд 2024 оноос хойш хийсэн авлига ашиг сонирхлын төслийн талаарх судалгаа авсан арга хэмжээний талаар мэдээлэл хийхээр байгаа. АТГ-ын дэд дарга Г.Азжаргал мэдээлэл өгнө.

АТГ-ын дэд дарга Г.Азжаргал: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

АТГ-аас прокурорын байгууллагаас хэрэг бүртгэлд мөрдөн байцаалт дээр зарим мэдээллийг өгөх зөвшөөрөл олгогдоогүй байна. Гэхдээ одоо мөрдөн байцаалтад саад болохгүй, хувь нэр хэлэхгүйгээр тодорхой мэдээллийг өгье.

УЕП-ын тушаалаар 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр 3 байгууллагын хамтарсан ажлын хэсэг гараад шалгалтын ажил явагдаж байна. Үүнээс Туулын хурдны зам нэртэй 2,3 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээний тендер сонгон шалгаруулалт, түүнийг санхүүжилт олгохдоо нийтийн албан тушаалтнууд Эрүүгийн хуулийн тусгай хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй.

2-т нь шинэ тойрог авто зам төслийн урьдчилсан ТЭЗҮ, зураг төсөв нэртэй 2016,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендер сонгон шалгаруулалт, Сэлбэ дэд төвийн. Орон сууц иж бүрэн цогцолбор хорооллын нийт 7 багц ажил зэрэг болно. Нийслэл хотод нийтийн тээврийн 6, Авто замын салбарын 4, Барилга хот байгуулалтын Дэд төвийн салбарын 4, Эрчим хүчний салбарын 5, дэд бүтэц усны салбарын 5 төсөл хөтөлбөр буюу нийт 24 төсөл байгаагаас 11-д нь санхүүжилт олгогдоогүй. 13 төсөлд нь хэрэгжиж эхэлж байгаа буюу тодорхой хувийн санхүүжилт олгогдсон төслүүдийг шалгалтын ажил явагдаж байна.

Нийт шалгалтын явцад 30 төсөл хөтөлбөртэй холбоотойгоор 30 дансны нийт 2,6 их наяд төгрөгийн дансны зарлагын гүйлгээг прокурорын зөвшөөрлөөр хязгаарласан. Одоогийн байдлаар 8 хүнийг Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан, 3 хүнийг цагдан хорьсон мэдээлэлтэй байна. Нийслэл хот, НИТХ, НЗДТГ болон түүний харьяа байгууллагуудад хийсэн хянан шалгалтын тоон мэдээллийг манай хэлтсийн дарга М.Даваатогтох өгөх үү?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: М.Даваатогтох дарга үргэлжлүүлээд танилцуулъя.

АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Даваатогтох: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. АТГ-аас нийтийн албан тушаалтны ХОМ-ийг, хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг түүнчлэн нийтийн албанд томилогдохын өмнө ХАСУМ-ийг хянадаг.

Энэ талаарх тоон мэдээг та бүхэнд танилцуулъя. АТГ-аас 2024 онд нийслэлийн хэмжээнд томилогдохоор нэр дэвшсэн 1725 мэдүүлэг гаргагчийн урьдчилсан мэдүүлгийг хянасан байна. Үүнээс 80 мэдүүлэг гаргагч нь их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. Их хэмжээний өөрчлөлт гэдэг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу 198 сая төгрөгөөс дээш хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн байна.

2025 онд нийт 821 нийтийн албан тушаалтныг хянасан. Үүнээс 693 албан тушаалтныг зөрчилгүй гэж үзсэн. 98 албан тушаалтны албан тушаалтанд томилогдвол зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдал байгааг анхааруулсан 6 албан тушаалтныг илт зөрчилтэй гэж томилох эрх бүхий этгээдэд хүргүүлсэн байна. 2026 онд нийт 310 албан тушаалтны ХАСУМ-ийг хянасан үүнээс 257-г зөрчилгүй гэж үзсэн 22-ыг анхааруулсан 3 албан тушаалтныг илт зөрчилтэй гэдэг мэдээллийг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлсэн байна.

ХОМ-ийн талаар танилцуулъя. Нийслэлийн хэмжээнд 2024 онд нийт 40 албан тушаалтныг шалгаад үүнээс 7 албан тушаалтныг зөрчилгүй гэж үзсэн 23 албан тушаалтныг зөрчилтэй гэж үзээд хариуцлага тооцох эрх бүхий этгээдэд хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн байна. 2025 онд нийт 10 албан тушаалтныг шалгасан. Үүнээс 4 зөрчилгүй, 4 зөрчилтэй гэж үзэж эрх бүхий этгээдэд хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн. 2026 он гараад нийт 14 албан тушаалтныг нийслэлийн хэмжээнд ХОМ-ийг хянаж байна. Үүнээс 2 зөрчилгүй, 9 албан тушаалтныг хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.

АТГ мөн улсын хэмжээнд авлига ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шийдвэрлэдэг. Энэ хүрээнд нийслэлд хамрагдах мэдээллийг танилцуулъя.

2024 онд нийт 19 гомдол мэдээллийг хянасан. Үүнээс 2 гомдол мэдээллийг хууль тогтоомж зөрчсөн гэж үзэж эрх бүхий байгууллагад шилжүүлсэн байна. 2025 онд нийт 36 нийслэлийн албан тушаалтнуудад холбогдох гомдол мэдээллийг хүлээн авч шалгаад 19-ийг зөрчилгүй гэж үзсэн, 9 гомдол мэдээлэлд хууль зөрчигдсөн байна гэж үзэж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна. 2026 онд нийт 16 гомдол мэдээллийг хүлээж авч хяналт шалгалтын ажиллагаа явуулж байна. Үүнээс 5-ыг нь зөрчилгүй гэж үзсэн, нэг гомдол мэдээлэл дээр албан тушаалтан хууль тогтоомж зөрчсөн гэж үзэж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн тоон мэдээтэй байна. Танилцуулж дууслаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Баярлалаа. Ерөнхий хяналтын сонсголд оролцож байгаа УИХ-ын гишүүд, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнууд сонсголд оролцогчдоос асуулт асууж хариулт авна. Асуулттай УИХ-ын гишүүд нэрсээ өгнө үү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.5-д гишүүн оролцогчоос асуулт асуух хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж хариулт авч болно. Мөн хуулийн 126 дугаар зүйлийн 126.2-т “энэ хуулийн 126.1.5, 126.1.6-д заасан үйл ажиллагаанд олонх, цөөнхийн төлөөлөл ээлжлэн асуух үг хэлэх боломж олгоно” гэж заасны асууя. Да.Цогтбаатар гишүүн асуулт асууя.

УИХ-ын гишүүн Да.Цогтбаатар: Энэ сонсголд оролцож байгаа иргэд, нийслэлийн удирдлагууд болон сонсголыг зохион байгуулж байгаа УИХ-ын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

2024 оноос хойш өнөөдрийг хүртэл төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, мега төслүүд дээр нь хийгдэж байгаа сонсголын хүрээнд авагдаж байгаа материалуудыг харахад хяналтгүйгээр хулгай хийгдчихсэн байна гэдэг ганцхан дүр зураг харагдаж байгаа. “Үндсэн хууль” танхимын гадаа коридорт тавьсан байгаа постеруудаас илүү тодорхой харагдана. Энийг манай хэвлэлийнхэн харуулах байх.

Улаанбаатар хотод 2024 оноос хойш зарлагдсан тендерүүдэд шалгарч байгаа компани нь хамгийн багадаа 2 удаа шалгарч байгаа. Түүнээс дээш удаа шалгарч байгаа компаниуд 56% гэж байгаа.

Манай нийслэлийн төлөөлөгч нар бүгдээрээ нийслэлийн өмчит ААН-үүд дээр ажиллаж байна. Энэ нь 43 ААН байна гээд шинжээчийн дүгнэлт дээр гарчихлаа.

Манай бүлгийн хурал одоо давхардаад явж байгаа. Сая бүлгийн хурал дээр Б.Энхбаяр сайд нийслэлд 113 ААН байна гэдэг танилцуулгыг давхар хийлээ. Эндээс харахаар нийслэлийн төлөөлөгч нар бүгдээрээ ямар нэгэн байдлаар тендер авч байгаа ААН-үүдэд нөлөөлдөг юм уу? бүгдээс нь давхардсан тоогоор ажил авдаг юм байна. Тэгээд бүгдэд нь ямар нэгэн байдлаар удирдах албан тушаал хашдаг юм байна. Одоо нийслэл дээр мега хулгай нүүрлэсэн байна гээд бид дүгнэж болохоор байгаа.

Өмнө нь, 2024 онд Төсвийн байнгын хорооны хурал дээр орж ирээд авто замын татварыг нэмэхдээ 2 хүнээс санал авч байгаад авто замын татвар хураамжийг нэмчихсэн гээд УИХ-ын гишүүдийг бараг загнаад сууж байсан нөхдүүд одоо түрүүчээсээ АТГ-т шалгагдаад 461-д хоригдчихсон сууж байгаа.

Шинэ хотын дарга одоогийн хотын нөхцөл байдлыг шууд өнөө маргаашгүй алга урвуулчихсан юм шиг өөрчилнө гэж би итгэхгүй байна. Харин гарц нь юу байж болох вэ? гэвэл магадгүй нийслэл хэдэн төлөөлөгчтэй вэ? Энэ бүх төлөөлөгчийг АТГ, цагдаад бүгдийг нь шалгуулчих юм бол, шалгалтын хариу хэр хурдан гарахаас хамаараад та ажлаа цааш нь явуулах боломжтой байх.

Тэрнээс таны удирдаж байгаа энэ нийслэлийн иргэдийн төлөөлөгчид бүгдээрээ давхар буюу бүүр хэдэн давхар дээлтэй. Тэгээд төсвийнх нь мөнгөнүүдийг ярихаар хамгийн бага нь жишээлэхэд 10 их наядаар яригдаж байгаа. 10 их наядаар яригдаж байгаа бүх төсөл, тендерүүдийн цаана дандаа хулгай гарсан гэдгийг нь бид сая шинжээчдийн дүгнэлт дээр тэмдэглэж авахааргүй олон хулгай яригдсан.

Тэгэхээр та нийслэлийг нэг урагш нь хөдөлгөө гэж бодож байгаа бол хамгийн түрүүлээд миний саналаар бол бүгдийг нь хуулийн байгууллагад шалгуулаад нэр цэвэр гэсэнтэй нь хамтарч ажиллаад явбал илүү үр дүнд хүрэх байх гэж бодож байгаа юм.

2 дугаарт, Нийслэлийг бид зүгээр бетонон ширэнгэн ой болгосон. Жишээлэхэд Сэлбэ хотын урсгалыг хаасан, Сэлбэ голын урсгалыг сайжруулна гээд баахан төсөл хөтөлбөр нэрийн дор голыг ухаж төнхөөд 2,3 жил болчихлоо. Гэтэл Сэлбэ голын эргэж байгаа эргэлтийнх нь хэсэг дээр Эко н.Нямдаваа гэдэг МАН-ын Бага хурлын гишүүн парк байгуулна гэж хэлээд газрыг нь аваад орон сууц барьчихсан.

Төв шуудангийн урд талд баригдаж байгаа өндөр барилга баригдсан. Одоо халагдчихсан Х.Нямбаатар дарга нийслэлд нэг ч барилга шинээр барихгүй гэж амлаад байсан. Гэтэл нүдэн дээр Улаанбаатарт байгаа хамгийн өндөр байшинг барьж байна. Тэнд хүн зогсох нь байтугай, гишгэх ч зайгүй газар дээр маш өндөр барилгыг барьж үзүүлж байгаа. Энэ бол танай намын хулгай, танай намын луйвар. Дээрээс нь Б.Чойжилсүрэн сайд байна. Хөл гишгэх газар болгон дээр Б.Чойжилсүрэн сайд байшин барьж түгжрэл нэмж байгаа. Нөгөө хотын даргын амлаад байсан амлалт дахиад байхгүй байгаа. Одоо бүр Зайсанд Богд уулаа даваад барих юм шиг байгаа.

Уг нь бүтээн байгуулалтыг эсэргүүцээд байгаа юм биш. Гэхдээ бид Богд уулаа тойруулаад нэг Хүннү дагуул хот барина гээд явсан. Уулаа тойроод замтай, хэдэн станц, хэдэн цэвэрлэх байгууламж барьчихвал хүссэн хүсээгүй тараад нүүхээр харагдаад байгаа. Өнөөдрийг хүртэл хийсэн ажил нэг ч байхгүй. Бүгдээрээ нэг баахан төсөл хөтөлбөр ярьж, мөнгө хулгай хийсэн асуудлууд гарч байгаа.

АТГ сая ирэхгүй байж байгаад ирлээ гэдэг мэдээллийг авсан. АТГ болдог бол нийслэлийнхэн дээр бүгдэд нь хэрэг нээж шалгаад цэвэр байгааг нь цааш ажлыг нь үргэлжлүүлээд, асуудалтай буюу олон төсөл тендер хөтөлбөрүүдэд холбогдсон хүмүүсээс эртхэн салгахгүй бол нийслэлийн төсөв хүн амаа дагаад маш их хурдацтай өсөж байна. Одоо алдагдлынх нь хэмжээ улсын төсвийн алдагдлаас их хэмжээнд гараад явчихлаа Б.Пүрэвдагва дарга. Тэгэхээр энэ асуудлыг маш сайн анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Туулын хурдны замыг барихад трасс баталсан тушаал 2013 оноос хойш ерөөсөө нэг ч байдаггүй гэж ойлгосон. Яг ийм шийдвэр байна уу? Шийдвэр байвал надад одоо гаргаж ирээд үзүүлээч гэдэг нэг асуулт байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Уучлаарай гишүүн нийт 20 минут дотор харилцан ярилцах болохоор та богино, богиноор асуугаад байвал илүү үр дүнтэй байж магадгүй. Эхний асуултаас эхлээд хариулъя.

ХББОСЯ-ны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр: Г.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Туулын хурдны замын трасс 2013 онд Засгийн газрын тогтоолоор батлагдсан байгаа.

Үүнээс магадлалын ерөнхий дүгнэлтээр нарийвчилсан зураг батлагдаж гарсан байгаа. 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус хурлын тэмдэглэлээр 6 эгнээ болгож үүрэг даалгавар өгсөн. Үүний дагуу ТЭЗҮ-г шинэчлээд 6 эгнээ болгосны дараагаар 2025 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор солбицол батлах тухай Туулын хурдны замын трассыг баталсан байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Да.Цогтбаатар гишүүний микрофоныг нээж өгье.

УИХ-ын гишүүн Да.Цогтбаатар: Мэдээлэл өгсөнд баярлалаа.

2025 онд Засгийн газраас баталсан трасс байгаа. Дандаа иргэдээс ирж байгаа асуултууд гэдгийг манай хотынхон сайн ойлгож аваарай гэж хүсье.

Эмээлт эко аж үйлдвэрийн парк дээр маш олон ажлууд хийгдэж байна. Үүнтэй холбоотойгоор Хөгжлийн банк дээр МБҮ гэдэг компанийн зээл МАН-ын ЕНБД Я.Содбаатартай холбогддог. Нийслэлтэй бас холбогддог. Нийслэл хотын махны хэрэгцээг үнийн шоктой холбоотой гэдэг юм уу, нийлүүлэлтийн тасалдалттай холбоотой гэх хамааралгүйгээр зохицуулахаар нэг компанийн асуудал явсан. Гэтэл одоо нөгөө зээлийг нь олгоно гэж байсан албан тушаалтнууд нь албан тушаал ахиад явчихдаг, хэрэгжүүлнэ гэж байсан компани нь одоо хууль шүүхийн байгууллагын хаалга татаад явж байгаа. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Дараагийнхаа асуултыг хариулт авсны дараа асууя.

Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн гүйцэтгэх захирал Б.Мягмар: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн гүйцэтгэх захирал Б.Мягмар байна.

Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн анх байгуулагдсан үндсэн чиг үүрэг нь Улаанбаатар хотын төвлөрлийн суурьшлын бүс болсон Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны 30,25 га газарт арьс ширний үйлдвэрүүд төвлөрсөн. Тухайн орчинд хөрсний бохирдол ихээр үүссэн тул зайлшгүй үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх асуудал хөндөгдөж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор Эмээлтийн эко аж үйлдвэрийн парк дэд бүтцийн ажлыг эхлүүлэхээр үйлдвэрүүдийн нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг зэрэг явуулах зорилт тавьж байгаа. Одоо 28 арьс ширний үйлдвэрүүд Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд байгаа. Энэ хүрээнд 8 арьс ширний үйлдвэр гэрээ болон газар ашиглах гэрээ байгуулсан. Үүнд махны чиглэлээр 2 ААН, дайвар бүтээгдэхүүний чиглэлээр 1, ноос ноолуурын чиглэлээр 1 гэсэн үйлдвэрүүд гэрээ байгуулан ажиллаж байгаа.

Хөгжлийн банктай холбоотой ямар нэгэн асуудал байхгүй, нийслэлийн төсвөөр үйл ажиллагаа явагдаж байгаа. Нийт 475 тэрбум төгрөгийн хөрөнгө

оруулалтын эх үүсвэр шаардлагатай, үүнээс 225 тэрбум төгрөгийг нийслэлийн төсвөөр шийдвэрлээд үлдсэн 179 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн асуудлыг хаанаас шийдвэрлэх вэ гээд нийслэлийн удирдлагууд болон холбогдох салбарын яамтай хамтарч ажиллаад, холбогдох санал өгсөн байгаа. Хөгжлийн банктai холбоотой мэдээ, мэдээлэл манайд байхгүй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Да.Цогтбаатар гишүүний микрофоныг нээе.

УИХ-ын гишүүн Да.Цогтбаатар: Б.Пүрэвдагва даргаас эхний асуултад хариу сонсчихъя. Бүх төлөөлөгч нараа хуулийн байгууллагад шалгуулчхаад ажлаа эхэлж чадах уу, одоо ингээд үргэлжлээд бүх хулгайтай нь зууралдаад явах уу гэдэг асуултын хариуг авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Пүрэвдагва даргын микрофоныг нээж өгье.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Та бүхэнд дахин өдрийн мэнд хүргэе.

Нийслэл дээр хяналт шалгалт явж байгаа. АТГ, Эрүүгийн цагдаагаас Нийслэлийн холбогдох албан тушаалтнууд дээр хяналт шалгалт явагдаж, зарим нэг нь хоригдоод явж байгаа тохиолдлууд байна. НЗД-ын хувьд эргэлзээтэй байгаа асуудлууд дээр аудитын шалгалтыг оруулсан. Тухайлбал, бордюрын асуудал дээр. Нийслэлийн өмчит компаниуд өөрийн өмчит объектод мөртөө бусад хувийн объектуудад үнэтэй түрээслэн суудаг. Энэ асуудал дээр хүртэл аудитын шалгалт оруулаад явж байгаа. Хэрвээ хууль зөрчсөн байвал НЗД-ын хувьд хариуцлага тооцоод явахад бэлэн байна.

УИХ-ын гишүүн Да.Цогтбаатар: Хариуцлага тооцох эрх танд байгаа байх. Гэхдээ та давхар дээлтэй төлөөлөгч нараа хүчрэхгүй гэдгийг бодитойгоор хэлэх гэсэн юм. Тэгээд яаж ажиллах нь таны эрх. Хэсэг хугацааны дараа дүнгээ танай баг тавиулах байх. Тэр үед тодорхой, бодитой үр дүн гаргасан байгаасай гэдэг үүднээс санал хэлж байна.

Б.Мягмар дарга миний ойлгосноор өөрөө төлөөлөгч байгаа байх. Хэдэн жил төлөөлөгч хийж байгаа вэ? МБҮ гэдэг компанийн асуудал миний мэдэж байгаагаар бараг 10 жил болж байгаа. Нийслэлийн Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн төслийг та хэдэн жил хариуцаж явж байгаа юм бэ?

Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн гүйцэтгэх захирал Б.Мягмар: МБҮ гэдэг компани Нийслэлийн Эмээлтийн эко аж үйлдвэрийн парктai ямар нэгэн төрлийн гэрээ байгуулсан харилцаа байхгүй. Сая авсан мэдээллээр ХХААЯ-ны Дархан парктai холбоотой асуудал байж магадгүй юм шиг байна. Энэ талаар мэдээлэл надад байхгүй байна.

Миний бие 2020 онд анх Нийслэлийн Иргэдийн Хуралд сонгогдсон, 2024 онд дахин сонгогдсон. 2022 онд нийслэлийн удирдлагууд арьс ширний үйлдвэр ялангуяа танай сонгогдсон тойрогт олон жил буюу 16 жил гацсан энэ төслийг та урагшлуулах хэрэгтэй байна гэсэн санал тавьсан. Ялангуяа МАН сонгогдох үед Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, 19 дүгээр хороо, 13 дугаар хороо гээд олон дүүргийн иргэдийн нөлөөлөлд орчихсон.

Мөн 21 аймагт арьс шир үнэ цэнгүй хаягдаж байхад энэ төсөл 16 жил гацсан. Энэ төслийг урагшлуулах хүсэл зорилгоор энэ ажлыг хогийн цэг байхаас нь эхлээд ажиллаж байна. 160 га талбайн тал орчим нь арьс ширний битүү хог хаягдал байсан.

Энэ оны 3 дугаар улиралд цэвэрлэх байгууламж, дулааны станцын дэд бүтцийн ажлыг эхлүүлэхээр бэлтгэл хангаж ажиллаж байгаа. Энэ төслийг явуулахад нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол дүүрэг гээд 3 дүүрэгт арьс ширний үйлдвэрүүд байдаг. Энэ төслийг урагшлуулахаар ажиллаж байгаа.

Энд онцлон хэлэхэд нийслэлийн төлөөлөгчдийг нэлээн их ярьж байна. Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчид гэдэг бол иргэдээ төлөөлж байгаа та бүхэнтэй санал нэг байна. Гэхдээ Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч доороо ямар нэгэн ажлын алба, цалин, урамшууллын зүйл байдаггүй.

Тэгэхээр энэ төлөөлөгч нар бүгд ардаа амьдралтай. Энд Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч байсан хүмүүс байгаа учраас нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчдийг ажиллах нөхцөлөөр хангасан тохиолдолд бид заавал аж ахуйн ажил эрхлээд яваад байх хүсэл сонирхол байдаггүй. Хан-Уул дүүргийн иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн төлөө явж байгаа гэдгийг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: НИТХ дээр ажил хийхгүй байх нөхцөл бүрдүүлэх шаардлагатай гэсэн коммент нэмж хэлж байх шиг байна. Да.Цогтбаатар гишүүн нэмэх үү?

УИХ-ын гишүүн Да.Цогтбаатар: Баярлалаа. Ер нь Нийслэлийн иргэдийн хуралд өрсөлдөхдөө бид цалин мөнгө авахгүй, нийслэлээ хөгжүүлэе гэж явсан байх. Цалин мөнгө авна гэдгээ та эрт хэлж байсан бол сонгогдох юм уу, үгүй ч юм уу би сайн мэдэхгүй байна. Санал хэлээд ер нь өндөрлөө. Ер нь асуулт асуугаад тодорхой хариулт авч чадахгүй юм байна. Мэдээлэл ч байхгүй юм шиг байна.

Өнгөрсөн өвөл Улаанбаатар хот тогны асуудал, дулааны асуудалтай нэлээн хэцүү өвөлжсөн. Энэ дээр сайн анхаарч ажиллахгүй бол дахиад энэ жилийн өвөл таны өмнө нийслэлийн шинэ даргын өмнө тулгарна.

Тэгээд энэ дээр зоригтойхон шиг шийдвэр гаргаж байгаад явахгүй бол нийслэлийн ажил урагшаа явахгүй. Сая нэг хурал дээр нэг сайд нь “би ёстой тэнэг зоригтой тулдаа энэ асуудлыг оруулж ирж байна” гэдэг шиг ажиллахгүй бол та яг ингээд академик зарчимч байдлаар хандах юм бол нийслэлийн ажил урагшаа явахгүй байх гэдгийг хэлэх гэсэн юм.

2 дугаарт, нийслэлийн төсвийн асуудлаар өнөөдрийн сонсгол яагаад явагдаж байгаа юм бэ гэхээр өмнөх баг, удирдлагууд иргэдийг ёстой нохой хуцаж байна чинээ тоогоогүй явсан. Тийм учраас нийслэлийн иргэд бүгдээрээ бухимдсан. Ядаж байхад Туулын хурдны зам нь яасан ч үнэтэй зам юм. Улаанбаатар хотод ганц байгаа том гол дээр хийх гэж байгаа учраас нийслэлийн иргэд нэлээн бухимдалтайгаар үзэл бодлоо илэрхийлсэн.

Тэгээд иргэдийн мэдэх эрхийг хангах үүднээс энэхүү сонсгол зохион байгуулагдаж байгаа учраас та бүгд цаашдынхаа ажилд сайн анхаарч ажиллах хэрэгтэй байна. Иргэдийн нэр барьж ажил, албан тушаалд очсоны дараа цалин хөлс,

ажиллах нөхцөлгүй байдаг талаар яриад дээр нь тансаглал, хангамж хэрэгтэй юм шиг байна яриад байж болохгүй байх.

Нийслэлийн 2 сая хүн амьдарч байгаа энэ түгжрээд байгаа, борооныхоо усанд живчих гээд байгаа, хөлдчих гээд байгаа энэ хотын асуудал үнэхээр хүнд байгаа гэдгийг нийслэлийнхээ иргэдэд болон одоо хамт ажиллаж байгаа хүмүүст зарчмынх нь дагуу ойлгуулж байж урагшлаарай гэж захиж хэлье. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Би Да.Цогтбаатар гишүүний асуулттай холбоотойгоор дахиад жоохон тодруулаад Б.Пүрэвдагва даргаас 2 зүйл дээр байр суурийг нь асууя.

1 дүгээрт, бидэнд ирсэн мэдээллээр улсын бүртгэл дээр нийслэлийн 80 компани байгуулсан байна. Үүнээс 5 компани татан буугдаад, 75 компани үйл ажиллагаа эрхэлж байгаа. Шинжээч нар 75 компанийг шүүгээд үзэхэд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдөөс 40 компанийн ТУЗ-ийн гишүүнд, 17 компанийн гүйцэтгэх удирдлагад байна.

Ингээд ажил хийдэг юм байж. Гэхдээ энд нэг зүйл байна. Нийтийн албанд “Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн агуулгаар энд зөрчил байхгүй гэж үзэж байна уу? гэсэн нэг асуулт байна.

Нөгөөх нь энэ компаниудын үйл ажиллагаа нь нийтийн хоол, цахилгаан эрчим хүч, барилга, программ хангамж гэх мэтчилэн хувийн хэвшил хийх бүрэн боломжтой үйл ажиллагаа явуулаад байдаг. Тэгэхээр ингэж байгуулж байгаа нь хууль зүйн хувьд ямар нэгэн зөрчил байна уу? гэдэг асуултын хүрээнд байр суурийг нь сонсьё.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Хурал даргалагчийн асуултад хариулъя.

1 дүгээрт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн хурал (НИТХ)-ын төлөөлөгч давхар ажил хийхийг хориглосон ямар нэгэн хууль зүйн заалт бол байхгүй. Тухайн ажилд томилогдохдоо АТГ-аас дүгнэлт авч байдаг.

2 дугаарт, НИТХ нийслэлийн өмчит байгууллагуудын өмчийн эзэн байдаг. Хууль эрх зүйн талаас ч, журам дүрэм талаас ч ямар нэгэн хууль зөрчсөн зүйл байхгүй.

Гэхдээ яг амьдрал дээр асуудал гардаг. Би 2020-2024 онд НИТХ-ын төлөөлөгчөөр ажиллаж байсан. Да.Цогтбаатар гишүүний хэлдгээр иргэддээ амлалтууд өгдөг. Хотын иргэдийн өмнө тулгарсан асуудлуудыг шийдэх, нийслэлийн өмнө тулгарсан асуудлуудыг шийдэх ажилдаа ороход Нийслэлийн иргэдийн хуралд бодлого шийдвэр гаргахад оролцдог боловч гүйцэтгэх засаглалын эрх мэдэл дутдаг тал байгаа. Хөрөнгө мөнгийг үр ашигтай зарцуулах талаас хориглосон хууль, дүрэм журам байгаа бол тэрийг мөрдөөд явах тухай асуудал яригдах болов уу гэж бодож байна. Хэрвээ хууль зөрчсөн, хулгай хийсэн зүйл байгаа бол хариуцлагаа хүлээгээд явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Энэ хулгайны асуудал биш л дээ. Гэхдээ хуулийн 2 заалт байна.

1 дүгээрт нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөвшөөрснөөр сэргийлэх тухай хуулийн 11.12-т “албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж нэг заалт байна.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39.2-т “хурлын төлөөлөгч эрх үүргээ хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзана” гэсэн зохицуулалт байна.

Энэ дүгнэлтүүд хаанаас гарч ирсэн бэ гэхээр олон том төслүүдийн шийдвэр гаргаж төсөв баталж байгаа. Нийслэлийн төслүүдийг хэрэгжүүлэх шийдвэр гарч байгаа. Тухайн шийдвэр гарч, төсөв баталж байх үед өөртэй нь холбоотой өөрийнх нь удирдаж байгаа байгууллагатай холбоотой шийдвэр дээр иргэдийн төлөөлөгч нар мэдэгдэл хийж тэмдэглэл хөтлүүлж оролцохоос татгалзсан зүйл байна уу? Хурлын протокол байна уу? гээд шинжээчдээс шаардсан. Энэ талаарх мэдээлэл ирээгүй байгаа. Тайлбарыг авна, гэхдээ амжаагүй гэж ойлгож байгаа. Хугацааны хувьд албан бичгийг нэлээн эрт явуулсан байгаа. Тэгээд энэ заалтууд дээр та зөрчил байхгүй гэж үзэж байгаа юу? Энийг дахиад асуучихъя.

2 дугаарт нь Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “нийслэл нь орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд этгээдтэй байж болно” гэж, 15.2-т “хуулийн этгээд нь хувийн өмчийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй ажил үйлчилгээг одоо тийм хуулийн этгээд үүсгэж гүйцэтгүүлж болно” гэсэн агуулга байдаг. Тэгэхээр энэ компаниудын нэрийг яах вэ? Дараагийн шинжээчийн дүгнэлтүүд дээр хэлээд явах байх. Хувийн хэвшлийг гүйцэтгүүлэх боломжгүй үйл ажиллагаа гэж дүгнээд байгаа юу? гэдэг асуулт байна.

Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Өнгөрсөн хугацаанд ямар шийдвэр гаргаж, ямар арга барилаар ажиллаж ирж байсан юм бэ? гэдэг президентийг харж явж байгаа. Бид та бүгдийн зүгээс, шинжээчдийн гаргаж байгаа дүгнэлтүүдийг өнөөдөр сонсоод сууж байна.

Зарим зүйл дээр зохицуулалт хийх шаардлагатай гэж анзаарагдаж байгаа. Нийслэлийн иргэдийн хурлын ашиг сонирхолтой холбоотой зүйл дээр манай Иргэдийн хурлаас хариулах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Пүрэвдагва дарга саяхан Солонгосын даргатай хүлэмж байгуулах санамж бичиг зурсан. Энэ дээр иргэдээс ирсэн асуултын хувьд энэ хүлэмжийг хувийн хэвшлийн байгуулж болохгүй юм уу? Энэ хуулийн заалттай зөрчилдөхгүй юу? гэсэн асуулт байна.

Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Тайлбар өгье. Энэ дээр нийслэлийн төсвөөс нэг ч төгрөг гарахгүй ажил байгаа. БНСУ-ын олон улсын харилцааны хамтын ажиллагааны байгууллага гэж байдаг. Койка байгууллагаас 19 сая ам.долларын тусламж үзүүлж байгаа. Манай улсын хувьд 4 улирлын турш цаг агаарын хүнд нөхцөл байдалд амьдардаг, нийт нарийн ногооны 92%-ийг урдаас импортоор авч байгаа. Энэ хэрэгцээг хангах зорилгоор хувийн хэвшил ногоочдодоо хүнсний ногоо үйлдвэрлэдэг ААН-үүддээ боломж олгох төсөл юм. Нийслэлийн

зүгээс газар, зөвшөөрлийг нь гаргаж өгч байгаа. Өөрөөр хэлбэл гаднынхан бидэнд манай хувийн хэвшлийнхэнд тусалж байгаа төсөл юм.

Засаг даргын хувьд хувийн хэвшлийнхнээ дэмжсэн бодлого барьж байгаа. Өнгөрсөн 7 хоногт 120 тэрбум төгрөгийн зах зээлийг хувийн хэвшлийнхэндээ нээж өгсөн. Хүүхдийн хүнсний хангамжийг гүйцэтгэдэг 4 төрийн өмчит, нийслэлийн өмчит байгууллага байсан. Бизнесийнхний хийж чаддаг зүйлийг нийслэл, төр хийхгүй гэдэг зарчмыг баримталж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Иргэнээс ирсэн асуулт. Нийслэл бол хамтарч хүлэмж барихгүй юм байна, газрыг нь, талбайг нь, дэд бүтцийг нь бэлдэж өгөөд хувийн хэвшлийг дэмжиж байгаа юм байна гэсэн хариултыг авлаа.

Ямар нэг үйлчилгээнд нийслэлээс, улсаас, төрөөс мөнгө гаргахгүйгээр хамтарч ажилла гээд хамтарсан компани байгуулаад “Эксклюзив” давуу эрх олгоод зах зээлийн нэг сегментэд тоглох эрх бүхий компаниуд үүсгэгчихсэн байгаа юм байна. Эрх зүйн хувьд хэр шударга зөв зүйтэй зүйл вэ? гэдэг эргэлзээтэй байгаа.

УИХ-ын гишүүн Д.Лодойсамбуу микрофон нээж өгнө үү?

УИХ-ын гишүүн Д.Лодойсамбуу: Сонсголд оролцож байгаа бүх хүмүүстээ өдрийн мэнд хүргэе. Асуулт ерөнхийдөө давхардчихлаа.

Сая Засаг дарга нийслэлийнхнийхээ хийж чаддаг ажлыг давхардуулж хийхгүй гээд хэлж байна. Ж.Золжаргал гишүүн мөн нийслэл 80 компани байгуулсан, эдгээрийн хариуцаж байгаа ажлыг хувийн хэвшил гүйцэтгэж хийж чадахгүй гэж дүгнэлт гарч байж энэ компаниуд үйл ажиллагаа явуулах боломж бүрдэх тухай хуулийн зохицуулалтыг уншаад байгаа. Нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хувийн өмчийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй ажил үйлчилгээг энэ хуулийн 15.1-д заасан хуулийн этгээдээр гэрээ байгуулаад гээд уншсан.

Тэгэхээр одоо өөрийг чинь шинэ Засаг дарга болсон учраас нийслэлийн 80 компанийн талаар тодорхой асуугаад байна. Хувийн хэвшлүүд барилга барьж чадахгүй гэж үзээд байгаа юм уу? Одоо өнгөрсөн удирдлагын талаар ярихгүй. МАН бөгөөд та бүхэн одоо үргэлжлүүлээд засаглаж байгаа. Зөвхөн даргын нэр солигдож байгаа асуудал. Тэгэхээр одоо шинэ Засаг даргын хувьд юу гэж бодож байгаа вэ? гэдгийг асууж байна.

Барилгыг хувийн хэвшлийнхэн барьж чадахгүй гэж дүгнэлт гарсан юм уу? Нийтийн үйлчилгээний салбар, хүлэмжийн асуудал мөн бусад олон асуудлуудыг энэ 80 компани хийж байгаа. Энэ ажлуудыг хувийн хэвшлийнхэн хийж чадахгүй гэдэг дүгнэлт гарсан уу? Тэр дүгнэлт гарч байж хууль хэрэгжих нөхцөл үүсээд байгаа. Ер нь өмнө нь дүгнэлт гарсан байна уу? Та юу гэж бодож байгаа вэ? гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт, УИХ-ын гишүүн Ж.Золжаргал Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуулийг заалтуудыг уншаад өглөө.

Харин таны хэлж байгаагаар өмнө нь явсан жишиг нийслэл өмчтэй учраас өмчөө захирч удирдах удирдлагаар хангах үүрэгтэй байдаг юм гээд та хэлж байна. Гэтэл цагаан дээр хараар хуульд заасан байна. Харин нийслэлд 45 хүн компанийн

ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нь өөрсдөө байдаг компанидаа төсөв баталж, ажил өгөөд байгаад байгаа юм.

Тэгээд энэ одоо зөв юм уу? Буруу юм уу? гэдэг нь хуулиар болохгүй гээд заачихсан. Гэтэл орон нутгийн ... нийслэл нь өмчтэй байхыг зөвшөөрчихсөн гэж байгаа. Тэгэхдээ ямар өмчтэй байх вэ? Ямар компани байгуулах вэ? гэдгийг хувийн хэвшлийнхэн хийх боломжтойг хийхгүй гээд хуульд заасан байгаа. Энэ дээр НИТХ-аас маш тодорхой хариулах хүн байна уу, үгүй юу?

ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нь байдаг төлөөлөгч нар төсөв баталж, тодорхой шийдвэр гаргаж байгаа компанидаа ажил өгч байгаа шийдвэрүүд дээр ашиг сонирхлын зөрчил үүснэ гээд дүгнэлтийг гаргуулсан уу? гаргуулаагүй юу? гээд тодорхой асууя. Энийг НИТХ-аас бүүр тодорхой хариулаад өгмөөр байна.

АТГ хууль уншиж өгөөд байгаа. Ашиг сонирхлын тухай хууль ингээд улайм цайм зөрчсөн, зөрчигдөөд яваад байгаа, жишиг тогтсон байдал байгаад байгаа. Энэ хуулийн зөрчил гэж харагдаж байна уу? Харагдахгүй байна уу?

Компанийн удирдах зөвлөлд Иргэдийн хурлын 45 төлөөлөгчийн 43 төлөөлөгч ТУЗ-ийн гишүүн бөгөөд гүйцэтгэх удирдлагад нь байдаг хүмүүс сууж байгаад, өөрсдөө төсвөө батлаад, өөрсдөө хэрэгжүүлээд явдаг байх юм бол ашиг сонирхлын тухай асуудлыг дахиж яриад ч яах юм бэ авлигын асуудал яриад ч яах юм? Ийм байхад зүгээр ингээд хараад суугаад байдаг байх юм бол АТГ-аар ч яах юм. Тэр газрын дарга гэж байгаад ч яах юм.

Тэгэхээр хуулийн заалтуудыг маш тодорхой уншаад өгч байгаа. Энэ дээр 1 дүгээр асуултыг НЗД, 2 дугаар асуултыг НИТХ-аас, 3 дугаар асуултыг АТГ-аас хариулт авъя. Яг ямар санагдаж байна? Энэ зөв юм уу, буруу юм уу? Энэ хууль зөрчсөн байна уу, үгүй байна уу? Ямар дүгнэлт хийж болж байна вэ? гэсэн ийм 3 асуултад хариулж өгнө үү.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Б.Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя.

Томилгоотой холбоотой асуултын хувьд томилгоо бүрд бид АТГ-аас дүгнэлт гаргасны дараа шийдвэрээ гаргадаг. Тэгэхээр зөрчилтэй, зөрчилгүй гэдгийг бид тодорхойлохгүй. Дүгнэлт ирсний дараа томилгоо хийж байгаа учраас бид зөрчилгүй гэж үзэж томилгоо хийдэг гэсэн үг.

Одоогийн байдлаар нийслэл өөрөө барилга бариад байгаа тохиолдол байхгүй. Энэ төсөл хөтөлбөрүүд бүгд Төсвийн тухай болон Тендерийн тухай хуулиар зохицуулагдаж явдаг. Сэлбэ дэд төв дээр гээд үзэхэд нээлттэй сонгон шалгаруулалтаар 113 блок 8585 байрыг 7 гүйцэтгэгч компани хийж байх жишээтэй. Бусад төслүүд тухайлбал, Шархадны төв, Баянхошуу төв, Дамбадаржаа гээд бүх төслийг хувийн компаниуд нээлттэй сонгон шалгаруулалт болон худалдан авах ажиллагаагаар шалгаруулаад гүйцэтгэлээ хийгээд явж байгаа.

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эрхэм гишүүний асуултад хариулъя. ТӨБЗГ буюу Нийслэлийн өмчийн харилцааны газраас хуулийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орох төлөөлөгчдийг НИТХ-д оруулдаг. ТУЗ-ийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг чадвартай, тухайн хуулийн

этгээдийн ТУЗ-ийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх гэх мэт тодорхой шаардлага, шалгуур хангасан хурлын төлөөлөгчид, төрийн албан хаагчид хараат бус гишүүд гээд орж ирдэг. Хэрэв шаардлага хангасан тохиолдолд НИТХ-аар томилоод явж байгаа.

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал гэж юуг хэлэх юм бэ гэж. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тодорхой зааж өгсөн байгаа. НИТХ-аас төлөөлөгчдийнхөө нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажилладаг байгаа. Энэ хүрээнд бид ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж ажиллаж байгаа.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд томилохоос өмнө АТГ-т ХАСУМ-ийг хүргүүлдэг. Тэгээд мэдүүлгийн хүрээнд ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдал үүсээгүй байна гэсэн дүгнэлт ирсний дараа Нийслэлийн иргэдийн хурлаас томилоод явж байгаа.

Орон нутгийн өмчит компанийн удирдлагад буюу гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа компаниудын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа хүмүүс тухайн асуудлыг хэлэлцэх тохиолдолд нэгжийн хуульд заасны дагуу “Хурлын төлөөлөгч эрх үүргээ хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзана” гэж заасан байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэр төслүүдийн шийдвэр гаргахдаа өөртэй нь холбоотой, удирдаж байгаа байгууллагынхаа шийдвэр гарах үед хуралд оролцоогүй гэдэг протоколыг УИХ-ын Тамгын газар холбогдох байгууллагаас шаардсан байгаа. Энэ мэдээллийг бид дахин шалгана.

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар: Ойлголоо.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хэрэв хугацаанд нь ирүүлээгүй бол нуун дарагдуулах үндэслэл рүү орчих вий. Тиймээс энэ бүхэн дээр та бүхэн анхаараарай. Ч.Лодойсамбуу гишүүний тодруулж асуусан асуултын дараагийнхыг сонсох уу? АТГ-аас хариулт өгье. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

АТГ-ын дэд дарга Г.Азжаргал: Гишүүний асуултад хариулъя. Томилох эрх бүхий этгээдээс тухайн томилогдох албан тушаалтны ХАСУМ-ийг АТГ хүлээн авч, улсын бүртгэлийн системээс тухайн этгээдийн өөрийн мэдүүлсэн хамаарал бүхий байдал, бусад хувийн байдалд үндэслэн мэдэгдэл гаргадаг. Хуулиараа энэ дээр дүгнэлт хийхгүй. Хянаж үзээд Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 29.7-д заасны дагуу мэдэгдлийг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлдэг. Тодорхой тохиолдолд тухайн албан тушаалтан нийтийн албанд томилогдох нь ашиг сонирхлын илт зөрчил үүсгэх нь гэсэн дүгнэлт хийдэг. Үүнд авлигын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн, тухайн албан тушаалтан болон түүний хамаарал бүхий этгээдүүд эрхлэх албан тушаалтай зөрчилдөхүйц юм уу тийм чиглэлийн компанитай байх, удаа дараа санаатай гэмт хэрэг үйлдсэн гэх мэт зөрчлүүд дээр илт сонирхлын зөрчил үүсэх нь гэдэг мэдэгдлийг хүргүүлдэг. Хуулийн хүрээнд ИТХ-ын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг орон нутгийн өмчит компанид ажиллахыг хориглосон хуулийн зохицуулалт байхгүй байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ч.Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Сая М.Халтар дарга бүгдэд нь сайхан жишгийг хэлж өглөө. Ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гэдэг үндэслэлээр тухайн хэлэлцэж байгаа асуудлаас гарч байсан тохиолдол байгаа гэж хэллээ. Б.Пүрэвдагва дарга сонсож байгаа байх. Тэгэхээр энд ийм асуудал үүсдэг байх. Тодорхой тохиолдлууд байгаа бол бүх асуудал дээр байр сууриа илэрхийлдэг байх ёстой. Томилохын өмнө АТГ дүгнэлт гаргадаг ч томилогдсоны дараа асуудал үүсэх эсэх дээр хуулийн зөрчил байгаа юм байна гэдгийг бас ойлголоо. Нийтийн албаны болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.6-д нэгдмэл сонирхолтой этгээд байх юм бол ашиг сонирхлын зөрчил үүснэ гээд томъёолчихсон. Нэгдмэл сонирхолтой этгээд гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг, 3.1.2-т хувийн ашиг сонирхол гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг ойлгоно гэж тодорхойлсон байдаг. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага гэдэг чинь тухайн компаниасаа цалин аваад явж байгаа. Одоо ийм жонхуурсан асуудал үүсчихсэн байна. Манай АТГ-ын дарга нар хараад "Яг тийм ээ" гэж дотроо бодож байгаа. Зүгээр яг хурлын төлөөлөгч гэдэг үг хайгаад байх шиг байна. ИТХ-ын төлөөлөгчид өөрсдөө удирдах зөвлөлд нь, гүйцэтгэх удирдлагад нь ажилладаг компанитай холбоотой шийдвэрүүдийг гаргаад яваад байдаг юм байна. Томилогдохоос нь өмнө АТГ-аас дүгнэлт гаргадаг, тэр дээр ямар нэгэн зүйл байхгүй гээд явчихдаг. Томилогдсоныхоо дараа ийм зүйл үүсчхээд байна. Одоо яах вэ? Хэн нэгэн гомдол гаргах ёстой юу? Нийслэлийн иргэдийн хурал тэр чигээрээ ашиг сонирхлын зөрчлийн бүтэн бүлэг болчихсон байна. АТГ дүгнэлт гаргаснаас хойш, албанд очсоноос хойш болж байгаа процессыг одоо яах вэ, гомдол гаргах уу? М.Халтар дарга тийм тохиолдлууд байгаа гэж хэлж байна. Тэр тохиолдлуудын яг протокол баримтыг нь өгчихсөн байх ёстой юм байна.

Өнөөдөр сонсгол явж байна, муу ч сайн ч Улсын Их Хурал дээр сонсгол явж байгаа учраас ийм мэдээллээ өгөөч ээ гэж шаардаад нэхээд тэрийг харж сууж байгаад бид нар яримаар байна. Ийм тохиолдол дээр тэр хүний оролцоо нь өөрөө "Оролцохгүй" гэж татгалзах санал гаргасан, санал гаргаагүй явсан гэдэг асуудлаар Тамгын газар ажлуудыг зохион байгуулна. Энэ мэдээллээр хангана. Тэгэхээр одоо энэ тохиолдолд АТГ-ынхантайгаа би дахин ярих гэж байна. Энэ хуулийн заалтыг яах вэ? Нэгдмэл сонирхолтой этгээд мөн үү, биш үү? ТУЗ-д нь ажиллаж байгаа, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байгаа нөхдүүд?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: АТГ хариулья, 4 дүгээр микрофон нээж өгье.

АТГ-ын дэд дарга Г.Азжаргал: Тухайн албан тушаалтанд хамаарахыг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 8.2-т хуульчилсан байгаа. Албан үүргээ гүйцэтгэх явцад өөрийнх нь хувийн ашиг сонирхол нийтийн албаны ашиг сонирхолтой зөрчилдөхүйц нөхцөл үүссэн бол мэдэгдэл, тайлбарыг удирдах эрх бүхий албан тушаалтандаа гаргахаар маш тодорхой хуульчилсан байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ч.Лодойсамбуу гишүүн тодруулья.

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Хуулийн 8.2-т ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй бол мэдэгдэнэ гэсэнг манай иргэдийн хурлын төлөөлөгч дотор байгаа ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагынханд мэдэгдэж байсан уу?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Асуултыг нээлттэй үлдээж байна. Иргэдийн төлөөлөгч бөгөөд ТУЗ-ийн гишүүн, байгууллагын удирдлага мэдэгдэж байсан уу? Ч.Лодойсамбуу гишүүн үргэлжлүүлэе.

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Энийгээ мэдэгдэх ёстой гэж байгаа юм. Мэдэгдэж байсан уу гэдгийг хэнд мэдэгдэх ёстой гэхээр эрх бүхий албан тушаалтан гэхээр хурлын удирдлага нь дарга л байх. Мэдэгдэж байсан зүйл байхгүй юу тэ? М.Халтар дарга хариулчих.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 7 дугаар микрофон нээж өгнө үү.

НИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар: Асуултад нэмэлтээр хариулъя. НИТХ-аар төсвийн асуудал хэлэлцдэг. Энэ төсвийн асуудлыг хэлэлцэхэд тухайлсан нэг ААН, тийм байгууллагуудаар гэдэггүй, ерөнхийдөө нийтлэг байдлаар явдаг. Тэгэхээр энэ дээр зөвхөн хуралдаанаар ороод тухайн төлөөлөгчөөс хамаарч шийддэггүй, 45 төлөөлөгчийн нийтийн хамтын шийдвэр гаргадаг. Тийм учраас тухайн төлөөлөгчөөс албан ёсны мэдэгдэл гаргаж байсан тохиолдол алга байгаа. Гэхдээ тухайн асуудлыг хэлэлцэхэд "Би оролцохгүй" гээд гарч байсан төлөөлөгчид байгаа гэдгийг түрүүн би хэлсэн.

Мөн нэг зүйл тодруулж хэлэе. Нийтийн албаны болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.1.2-т байгаа энд "Улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт, хязгаарлалт" гэж байгаа. Манай нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчид энд тусгагдаагүй гэдгийг бас зориуд хэлэе. Тухайлбал 20.1-д Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүн, аймаг, НЗД-ын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, төрийн албаны удирдах албан тушаал эрхлэх, төрийн болон орон нутгийн өмчит компани, УҮГ-ын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно; гэж заасан байгаа. Яг энэ тохиолдолд НИТХ-ын төлөөлөгч гэсэн заалт байсан бол энэ нь жинхэнэ хууль зөрчсөн асуудал болох ёстой. Гэхдээ энэ дээр хориглолт байхгүй гэж би үзэж байна. Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн тухайд миний хувьд бас тодорхой санал хэлчихье гэж бодлоо. Түрүүн нэг зүйл...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэрийг дараа нь хэлчихье. Ч.Лодойсамбуу гишүүн.

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39.2-т "Хурлын төлөөлөгч эрх үүргээ хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзана" гэсэн зохицуулалт байна. Энэ чинь хууль мөн биз дээ? Нийслэл чинь мега төслүүдтэй холбоотой төсөв баталдаг. Энэ мега төслүүд чинь нийслэлийнх мөн биз дээ? Бид нар нийслэлийн мега төсөл, төсөв, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалттай холбоотой сонсгол хийж байна. Энэ бүхэнд 45 төлөөлөгчийн 43 нь оролцчихсон байна. Татгалзсан ердөө 8 тохиолдол, бусад нь татгалзаагүй. Энд цагаан дээр хараар бичсэн хуулийг ИТХ тэр чигээрээ зөрчсөн байна. ТУЗ-д томилоод, гүйцэтгэх удирдлагад томилоод, цалин өгүүлээд, дээр нь

нийслэлийн төсвөөс ажил өгөөд, өөрсдөө тэрийгээ хийгээд, ингэж хурлаа барьдаг юм байна ш дээ. Энэ чинь авлигын систем, сүлжээ биш юм уу? Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39.2-т түрүүнд миний уншсан заалтыг зөрчсөн байгаа тохиолдолд одоо яах вэ? Гомдол гаргаад иргэдийн хурлыг бүгдээр шалгуулах уу? АТГ-аас би асууя. Энэ тохиолдлуудыг одоо байгаа хуулиараа яах ёстой вэ? Гомдол гаргах юм уу, эсвэл АТГ өөрсдөө бүх шийдвэрийн оролцоо дээр санал өгсөн, өгөөгүй байдлыг нэг бүрчлэн шалгах юм уу?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Энэ асуудлыг цаашид үргэлжлүүлж ярилцана. Дараагийн хариултын дээр та бүхэн анхаараарай. Хоёрдугаарт, асуултад хариулж байгаа хүмүүс овог, нэр, албан тушаалаа эхлээд мэдэгдэх шаардлагатай байна. Б.Мөнхсоёл гишүүний микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл: Өмнө давтагдсан асуултыг яалт ч үгүй дахин асууя гэж бодож байна. Энэ засаглалтай холбоотой маш нарийн асуудал учраас гишүүн болгон асуугаад байгаа юм. Та бүхэн мэдэж байгаа. Сая Туулын хурдны замын асуудалтай холбоотойгоор иргэд ямар их цочирдон хүлээж авч байна. Ямар их, авлига, хээл хахуулийн асуудал байгааг бүгд мэдчихсэн. Үүнтэй холбогдуулан энэ сонсголыг ч гэсэн зохион байгуулж байна. Өөрөөр хэлбэл Ж.Золжаргал гишүүний хэлсэнчлэн иргэд мэдэхийг хүсэж байна. Яагаад мэдэхийг хүссэн бэ гэвэл мэдээлэл ил тод биш байгаа учраас. Зориуд ингэж хяналт шалгалт хийдэг сонсгол зохион байгуулж байж мэдээлэл олж авдаг болж байгаа нь өөрөө бас буруу зарчим, буруу жишиг болчхож байгаа. Нэмэлт ажиллагаа болчхож байна. Асуулт асуухад хариулт тодорхойгүй болохоор бас хэцүү байна. Б.Пүрэвдагва нийслэлийн шинэ захирагч, хотын дарга ажлаа зөв эхлэхэд энэ сонсгол маш их тус болж байгаа гэж харж байна.

45 НИТХ-ын төлөөлөгчид байна. Үүний 42 нь нийт нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд нийт 104 суудал эзэлж байна. 104 суудлын 65 буюу 62.5% нь 19 төлөөлөгчид төвлөрч байна. Ч.Лодойсамбуу гишүүн ээ, 19 төлөөлөгчид хүртэл төвлөрч байна гэдэг ийм нарийн мэдээлэл сая ухаж гарч ирлээ. 19 гишүүн гэдэг чинь 42 төлөөлөгч дотроос 19-д нь төвлөрчхөөд байна. Тэгэхээр энэ засаглалын асуудал хөндөгдөж байна. Энэ нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчид больё гээд гараад ирсэн чинь эргээд муу засаглалын жишиг үүсгэчихсэн, авлигын асуудал үүсчихсэн ийм хэцүү байдалд орчихсон. Энэ нь өөрөө эргээд дам нөлөө ихтэй, сөрөг нөлөөтэй. Иргэдийн итгэл үнэхээр буураад байна.

Та нарын хүсэж байгаа том ч бай, дунд ч бай, жижиг ч бай төслүүдийг чинь явуулахад хүндрээд байна. Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа хүмүүст итгэхийн аргагүй болчхоод энэ чинь өөрөө та нар ч гэсэн эх орны иргэд шүү дээ? Хамаатан, садан, гэр бүл чинь энд л хамт амьдарч байгаа. Тэгэхээр энэ улсын хөгжилд маш том саад тотгор учраад байгаа учраас ингэж асууж байгаа юм. Мэдээллийн ил тод байдал чухал байна, ашиг сонирхлын зөрчлийн асуудлууд байна. Заавал ийм сонсгол хийж юмыг ухаж гаргаж, тэрэнд нь дутуу хариулсан байдлаар бус, байнгын ийм мэдээллийн ил тод байдал бүрдэх нь их чухал байна.

Энэ дээр хариулт хэрэггүй байх. Манайхан зөндөө асуугаад яг тодорхой хариулт ирээгүй, цаашид энэ процесс үргэлжлэх юм байна гэж Ж.Золжаргал гишүүний хэлснээс ойлголоо. Энийг тэгээд зориуд протоколд үлдээе.

Алдарт Туулын хурдны замын төсөлтэй холбоотой НЗД-аас асуух асуулт

байна. УИХ-ын гишүүний хувьд Туулын хурдны замын төслийн талаар мэдээлэл хүсээд 2026 оны 3 дугаар сарын 26-нд Нийслэлийн замын хөгжлийн газар, Нэгдсэн төслийн удирдлагын газар, хувийг нь НЗД, НИТХ-ын дарга руу албан бичиг илгээсэн. Гэтэл өнөөдрийг хүртэл Нэгдсэн төслийн удирдлагын газраас албан бичгээр хариу аваагүй байгаа. Албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хуулийн дагуу албан тушаалтнууд 30 хоногийн дотор хариу ирүүлэх ёстой шүү дээ. Биелээгүй байна, энэ тохиолдолд яах вэ? Тэгэхдээ азаар энэ хоёрын хариу ирээгүй ч гэсэн би өөр нийт 6-7 албан бичиг явуулсан, бусад нь хариу ирүүлсэн. Иргэд хүчтэйгээр өөрсдийн санаа бодол, зөвлөмж, эсэргүүцэл, шүүмжлэлээ илэрхийлсээр энэ төсөл сая бүр зогсоогүй, түр зогсоосон гээд өглөө танилцууллаа. Тэгэхээр байдал ямар байгаа мэдээллийг сайн өгөх хэрэгтэй. Энэ чинь эргээд УИХ-ын гишүүд, улс төрчид хэн нь ч эсэргүүцэхийн төлөө эсэргүүцээгүй. Асуудал үүсэхээр л анзаараад анхаараад, адилхан нэг эх оронтой бүгд санаа зовоод асуудал хөндөхөөр явж байтал ингээд бусармаг асуудал нь ил гараад байна. Энэ мэдээлэл үнэхээр асуудалгүй, үнэхээр зөв зүйтэй зүйлийн төлөө явж байсан бол мэдээллүүдээ гүйцэд өгөөч. Б.Пүрэвдагва хотын дарга маш сайн засаглалыг бий болгох хэрэгтэй.

Сайн засаглалыг бий болгохын тулд мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоо, элдэв буруу зүйлүүд, авлигаас ангид байх энэ суурь зарчмаа бүтцэдээ сайхан оруулах хэрэгтэй. Ингээд асуултынхаа хариултыг авна.

Дараагийн асуулт нь Сэлбэ, Баянхошуу дэд төвтэй холбоотой. Сая тусламж зээлийн төсөл дахин орж ирээд 3 төслийг явуулах гэсэн юм. Сэлбэ дэд төвийн дэргэдэх орон сууцны асуудал чинь буцаагдаж, хасагдаж байж дахин орж ирж байж гишүүд дэмжлээ шүү дээ. Чуулган дээр энэ 20 мянган айлын орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ гээд санхүүгийн загварыг нь тодорхойлсон боловч санхүүгийн загвар нь бонд буюу хот өөрөө бонд гаргаж эрсдэлийг өөртөө хүлээж авч байгаа юм байна. Яагаад ийм шийдвэр гарчав? Хэний шийдвэр вэ? Тэр эрсдэлээ эргээд дааж чадах уу? Яагаад 100% нийслэлээс гаргасан бондоор санхүүжүүлж байгаа вэ? Энэ талаар илүү тодруулсан хариулт авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хэнээс асуух вэ? Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Б.Пүрэвдагва дарга, 10 дугаар микрофон.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Ил тод, нээлттэй байдал дээр санал нэг байгаа. Сая гарсан шийдвэр дээр иргэд яагаад бухимдаад байна вэ гэвэл мэдээлэлгүйгээс болоод зөв буруу байр суурьтай байгаа. Би ажлаа авангуутаа ажлын хэсэг байгуулж чиглэл өгсөн. Манай ulaanbaatar.mn сайд дээр 6 дугаар сарын 25-ны өдрөөс нэг шинэ платформ нээгдэх гэж байна. Энэ нь нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүх төслүүдийн явц, ТЭЗҮ, шалгарсан гүйцэтгэгч байгууллага, хэрэгжилт, төсвийн зардал, гүйлгээ гээд бүх зүйлийг ил тод, нээлттэй болгох юм. Учир нь нийслэлийн мөнгө чинь иргэд, татвар төлөгчдийн л мөнгө. Тэгэхээр ил тод, нээлттэй ажиллана гэдгээ танд мэдэгдье. Туулын хурдны зам дээр хууль хүчний байгууллагын шалгалт явагдаж байгаа. Бид эцсийн шийдвэрийг хүлээж байна. Хууль хүчний байгууллагын шалгалт явагдаж байгаа учраас энэ дээр шууд тодорхой байр суурь илэрхийлэх цаг нь одоогоор биш байна. Зүгээр миний баримталж байгаа зарчим бол нэгдүгээрт, байгаль экологийг эвдэхгүй байх шаардлагатай, хоёрдугаарт, төсвийн мөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагатай, эдийн засгийн тооцоог харна гэсэн ийм байр суурьтай хүлээцтэй байж байгаа. Хэд хэдэн хувилбар бэлдсэн, манай баг дүн шинжилгээ хийгээд бэлэн байдалтай байна.

Хууль хүчний байгууллагын шалгалтын шийдвэрийг хүлээж байна. Сэлбэ дэд төвийн шийдвэр бол УИХ дээр ч яригдаж байсан, Засгийн газрын шийдвэр, тогтоолтой, Нийслэлийн иргэдийн хурлын тогтоолтойгоор явагдаж байгаа ажил. Сэлбэ дэд төв дээр манайхнаас У.Баатар дарга ирчихсэн байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Б.Мөнхсоёл гишүүний албан бичигт хариу ирэхгүй байгаа тал дээр Нэгдсэн төслийн удирдах газраас хариулт өгөөч. 3 дугаар микрофон нээж өгье.

"Сэлбэ хорин минутын хот корпорац" ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Яагаад төр, хувийн хэвшлийн түншлэлээр 100% хийнэ гэххээд төр өөрөө орон сууцны төслөө хэрэгжүүлэв гэж асууж байх шиг байна. ТЭЗҮ дээр 100% төр хувийн хэвшлийн түншлэлээр хамтарч хэрэгжүүлнэ гэсэн заалт байхгүй. Анх Засгийн газрын тогтоол, Нийслэлийн иргэдийн хурлын тогтоолын хүрээнд баригдах нийт 10 мянган айлын орон сууцыг богино хугацаанд хийж хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан. Энэ хүрээнд Сэлбэ 20 минутын хот корпорацыг чиг үүргийн дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр 2025 оны 1 дүгээр сард байгуулсан. Уг төслийн хүрээнд эхний ээлжийн 8,575 айлын орон сууцны худалдан авах ажиллагаа 2025 онд багтаж дууссан. Одоогийн байдлаар 102 блокийн ажил амжилттай үргэлжилж байгаа. Яг өнөөдрийн нөхцөл байдлаар нэг хоногийн хоцрогдолгүй цаг хугацаандаа явж байна.

Мөн уг 40 орчим га газар дээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах олон нийтийн бүсчлэлийг гаргасан. Үүнийг бас ТУЗ болон тохирох шийдвэрүүдээ гаргаад үйл ажиллагаа явж байна. Яг одоогоор шалгарсан компани байхгүй байна. Уг төслийн хүрээнд 700-800 мянган м² талбай бүхий 20 минутын хот концепцыг бүрдүүлж байгаа. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдах төслийн загварчлалууд бий болж байгаа. Ирээдүйд бид 2.5-2.7 их наядын хувийн хөрөнгө оруулалтыг татаж энэ төслийг амжилттай хэрэгжүүлэх юм. Агуулгын хүрээнд харахад Сэлбэ 20 минутын хот төсөл маань зөвхөн орон сууцны төсөл биш юм.

Энэ дотор нийгмийн дэд бүтэц сургууль, цэцэрлэг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдах бусад үйлчилгээний орон зайг оруулж шинэ эдийн засгийн бүсчлэлийг бий болгож байна. 2013, 2015 оны өмнөх ТЭЗҮ дээр ч 40-50 мянган хүн амтай хотын дэд төв болно гэж дурдагдсан. Тэгэхээр энэ нь 2020, 2023, 2024 онд шинээр гарч ирсэн биш, үргэлжилж байгаа. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хийж чадаагүй ийм томоохон бүтээн байгуулалтыг төр өөрөө богино хугацаанд хийж хэрэгжүүлэх зорилгоор ажиллаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сэлбэ дэд төв, Туул дээр маргааш тусдаа, дэлгэрэнгүй ярихаар байгаа. Б.Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл: Нөгөө хүн байхгүй гээд түрүүний асуултад хариулаагүй биз дээ? Дараа нь хариулах юм байна, зөв үү? Сэлбэтэй холбоотой маргааш Туулын хурдны зам, Сэлбэ дээр нарийвчилсан танилцуулга хийгдэнэ гэж ойлгосон.

Түрүүн товчхон асуугдсан тул бас гүйцээж асууж байна. Гол асуудал яагаад ингэж асуугаад байгаа вэ гэхээр хувийн хэвшил, хувийн секторыг дэмжих тухай улс орон даяар яригдаж байна шүү дээ. Зөвхөн нийслэлд биш, чуулган дээр байнга энэ

асуудал яригдаж байгааг өөрөө ойлгож байгаа байх. Татварын реформ хийгдэхгүй, асуудалтай, 100% хүссэнээр явахгүй байна гэхээр ядаж зах зээлийнх нь багтаамжийг битгий булаацалдаасай гэсэн асуудал бас яригдаж байгаа. Үүний завсраар хувийн сектор, нээлттэй зах зээл, нээлттэй эдийн засаг, чөлөөт зах зээл гэдгийг өөрөө мэдэх байх. "Тэгж байх шиг байна, ингэж байх шиг байна" гээд яаж ийм давилуун ярьдаг юм бэ? Жоохон хүндэтгэлтэй.

Хоёрдугаарт, энэ дээр хувийн хэвшлийн оролцоо яагаад чухал вэ гэвэл олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэр ашиглаагүй нь зээлийн хүүгийн зардлыг ихэсгэж төслийн өртгийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Яагаад чуулган дээр энэ саналыг дэмжээгүй, яагаад олон гишүүн дэмжээгүйг өөрөө мэдэж байна уу? Маргааш үргэлжлүүлээд ярь, би гэлтгүй олон гишүүн асуух нь тодорхой. Өглөөнөөс хойш манай шинжээчид зөндөө чухал асуудал хөндчихлөө. Нийслэлийн төсөв орхигдоод, анхаарал хараанаас гараад байна. Та нар санаж байвал ОУВС-ийн хүмүүс Төсвийн байнгын хорооны зарим гишүүдтэй уулзаж байна. ОУВС Монгол Улсын эдийн засаг 2017 онд дефолт болохоос өмнө хамгаалаад "өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-т орохдоо дураараа бонд гаргадаг асуудлыг бас цэгцлэх хэрэгтэй гэсэн. Ер нь төсвөөс гадуур ийм бүртгэлгүй зарцуулалтыг хумих, хязгаарлах, бүртгэлтэй зарцуулалтаа оновчтой болгох, төсвийн сахилга бат чухал гэж хэлсэн. Заавал гадаадын хүмүүсээс биш, монгол хүмүүс өөрсдөө мэдээд хэлээд байгаа. Үүнтэй холбоотой олон асуудлыг өглөө ярилаа. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 1,4 их наядаас илүү том асуудал нийслэл дээр яригдаж байна. Аюул болно шүү гээд чиг үүргээ заагаа тодорхойл гээд Сангийн сайд З.Мэндсайхан өөрөө хэлээд гарлаа шүү дээ. Энд нэг бие биеэ хуураад жүжиг тоглох шаардлагагүй, адилхан монгол хүмүүс шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн байна уу, НИТХ байна уу, Хотын дарга байна уу, хэн ч бай бүгдээрээ нэг эх оронтой учраас тал талаас санаа зовоод энд сууцгааж байгаа гэж ойлгож байна. Хэн ч хэнийг яллах гээгүй, бүгдээрээ хамтдаа урагшилъя, хөгжье. Яавал зүйтэй вэ? Б.Пүрэвдагва хотын захирагчид хэлж байна. Энэ бол чамд олгогдож байгаа том боломж. Бүх юмыг чинь дэлгэж өгч байна, тодруулж өгч байна, засаглалын асуудал ярьж байна. Яагаад гишүүн болгон төлөөлөгч болчихоод давхар хашаад байгаа юм бэ гэдгийг асууж байна. Ч.Лодойсамбуу гишүүн зоригтой хэлж байна шүү дээ. "Авлигын сүлжээ үүсчихсэн юм биш үү?" гээд ухаж яриад залуучуудаа бид нар хойноосоо аягүй буруу залж байна гэж миний хувьд санаа зовдог. Ээж хүний хувьд бүгдээрээ энэ чөтгөрийн тойрогт төрчихсөн, бүгд сайхан амьдрахын тулд ямар нэгэн балай, буруу юманд орохгүй бол амьдардаггүй ийм хачин чөтгөрийн тойрогт орчихсон. Бид нар энэ цаг хугацаандаа аль болохоор сайн засаглалтай, ил тод, хөдөлмөр чадамж дээрээ сайхан амьдардаг тогтолцоог төрд ч, төрийн бус ч, олон улсад ч, хувийн секторт ч ажиллаж байгаа бүх залуучуудаа тэгш, зөв боломжоор хангамаар байна. Тэгш хуваарилалт биш шүү. Тэгш боломж, хөдөлмөрлөхийг хүссэн нь сайхан амьдардаг нийгмийг бүтээх гээд байна. Дундаж давхаргаа зузааруулах гэж байна, энэ бүхэн чинь саад болоод байна. Маш их санаа зовоосон асуудал. Энд асууж барахгүй, энд тэндээс нь бүгдээрээ цөмөөрөө асуугаад байна. Бүгдээрээ сайн бод. Хүн болгон бодох хэрэгтэй. Ингэж дуусгая. Худлаа хариулаад яах вэ!

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Н.Алтаншагай гишүүн асуулт асууж үг хэлнэ.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Хурал даргалагч хурлын эхэнд сонсголын зорилгыг танилцуулсан. Энэ сонсгол нь 2024-

2026 оны хооронд нийслэлийн төсөв хэрхэн бий болсон, ямар дүнд хүрсэн, яаж бүрдсэн, яаж зарцуулсан талаар нээлттэй хэлэлцэх, иргэдэд мэдээлэл өгөх зорилготой. Хэлэлцүүлэг явснаараа давуу талтай. Хотынхоо иргэдэд ямар хууль, эрх зүйн орчинд ажиллаж байгаагаа мэдээлэх боломж бүрдэнэ гэж нэгдүгээрт харж байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд ИТХ-ын бүрэн эрхийг хуульчилж өгсөн. Үүний нэг нь Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах эрх, энэ эрхэд хөндлөнгөөс халдах эрхгүй бөгөөд Үндсэн хуулийн үзэл баримтлалаар баталгаажуулж өгсөн заалт байгаа. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан тэр өөрчлөлтөд төрийн бодлогын залгамж халааг тогтвортой байлгах асуудал багтсан. Тодруулбал хөгжлийн бодлого тогтвортой байхыг Үндсэн хуульд заасан гэсэн үг.

Зарим гишүүд ярьж байна. НИТХ 35-36 жил буруу яваад ирсэн юм мэтээр засаглалын өнцгөөс хэлбийлгэж асуудаг. Нийслэл Улаанбаатар хотын хувьд өнгөрсөн 30 жилийн алдаа дутагдалд шалтгаалан олон сөрөг үр дагавартай тулгарч байгаа. Үе үеийн хотын дарга нар бүх гишүүдийн амны уншлага болчихоод байгаа. Уншиж өгье. Нийслэлийн иргэдийн хурлын 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 25/111 дүгээр тогтоолоор батлагдсан 16 мега төсөл байгаа. Энэ төсөл бол 36 жилийн хуримтлагдсан асуудлыг арилгахад зориулагдсан төсөл гэж ойлгож байгаа. 2022 онд Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдсэн. Үүгээр Улаанбаатар хот бие даан хөгжих санхүүгийн эх үүсвэрээ өөрөө шийдвэрлэх, олон төрөлт солонгорсон эдийн засгийг бий болгох эрх зүйн боломжуудаа нээж авч чадсан.

Өнөөдөр бүтээн байгуулалтын ажлууд эхэлсэн. Энэ ажлуудыг эхлүүлээгүй, зориглож хийгээгүй бол та нар энд сууж байхгүй. Төсөв хараад л, боож өгсөн төсөвт нь тааруулаад л, гэдсээ илээд л явчих ийм гунигтай дүр зураг байсан. Өмнөх хотын даргыг сайшааж, магтаж байгаа юм биш. Баг хамт олноороо зоригтой орж чадсан, том төслүүдийг эхлүүлж чадсан. Хотын иргэн хүний хувьд би баяртай байгаа. Улаанбаатар хот нь нийгэм, эдийн засгийн хамгийн том төвлөрөл болчихоод байгаа. Монгол Улсын хүн амын 55%, нийгэм эдийн засгийн 80-85% Улаанбаатар хотод эргэлдэж байгаа. 2 сая хүн амтай, тэгэхээр хүссэн хүсээгүй Улаанбаатарт төвлөрөл байна.

- Нэгдүгээрт, энэ 16 мега төсөл байгаа. Улаанбаатар метро хэрэгтэй юу? хэрэгтэй. Хүн амын төвлөрөл бүр ихсэж, түгжрэл нь дээд цэгтээ тулчихсан;
- Хоёрдугаарт, тусгай авто замын автобус буюу BRT хэрэгтэй юу? Маш олон жилийн судалгаагаар тодорхойлогдсон;
- Гуравдугаарт, Улаанбаатар Трамвайн 1, 2 дугаар шугам;
- Дөрөвдүгээрт, агаарын дүүжин замын тээвэр;
- Тавдугаарт, тойрог хурдны зам хэрэгтэй юу? Улаанбаатарчууд бүгд гараа өргөөд дэмжинэ;
- Зургадугаарт, Сэлбэ хот орон сууцжуулалтын төсөл хэрэгтэй юу, 10 мянган айлын орон сууц хэрэгтэй юу? Хэрэгтэй л байгаа. 2024 оны бүх шатны сонгуульд Монгол Ардын Нам үүнийг дэвшүүлэн оролцсон, мөрийн хөтөлбөрт нь багтсан. Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах гэдэг үндсэн том концепци мөрийн хөтөлбөр дотор багтсан. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дотор энэ бүгд орсон. УИХ, Засгийн газрын маш олон тогтоол шийдвэрүүд гарсан;
- Долоодугаарт, Туул усан цогцолбор;

- Наймдугаарт, Дулааны-V цахилгаан станц байна. Үүнийг өнгөрсөн 35 жилийн хугацаанд хийвэл хийх л байсан. Хийж чадаагүй. Улаанбаатар нь хөлдөх гээд аргаа бараад НИТХ дээр яригдаж, санхүү нь шийдэгдэж байсан асуудал.
- Есдүгээрт, Хөрсний ус, үерийн хамгаалалт байна. Бороо их орвол асуудал үүснэ. Улаанбаатарт 1989 оноос хойш газар доогуурх далд шугам сүлжээний бүтээн байгуулалт хийгдээгүй. Би өөрөө орон нутгийн удирдлагад, дүүргийн Засаг даргаар 4 жил ажилласан, нийслэлийн иргэдийн хуралд 4 жил сууж байсан. Тиймээс бодит мэдээллээ хотын удирдлагууд өгөх хэрэгтэй.
- Аравдугаарт, дэд төвүүдийг түшиглэсэн орон сууцжуулах хөтөлбөр байна. Гишүүд хоорондоо зөрчилтэй зүйл яриад байгаа. Нэг хэсэг нь хууль, эрх зүйдээ баригдаад орон сууц барьж болохгүй гэдэг, зам талбай шинэчилж болохгүй, бордюр сольж болохгүй, зам барьж болохгүй гэнэ. Тэгээд хотод амьдарч байгаа иргэдийн аюулгүй байдал, амьдрах орчныг яаж таатай болгох вэ? Хараад суугаад, хүлээгээд байх уу?
- Арван нэгдүгээрт лаг шатаах үйлдвэр байна. Бид хог хаягдлаа яаж шийдэх вэ? Лагаа шатаах, эрчим хүч гаргадаг үйлдвэр рүү шилжихгүй бол яана? Улаан давааны хогийн цэг, Цагаан давааны хогийн цэг, Морингийн даваа гэсэн 3 цэг дээр л хогоо хаяж байгаа. Яг XIII зууны үе шиг хашаанаас нь авчраад хаяж, булж байна. Тэгэхээр энэ төслийг хэрэгжүүлэх нь зайлшгүй;
- Арвангурав дугаарт олон түвшний уулзвар байна;
- Арвандөрөв дүгээрт Туул хурдны зам төсөл, Хүннү хотын дэд бүтэц, Эмээлт эко аж үйлдвэрийн парк багтаж байна.

Энэ бол яг 36, бараг сүүлийн 40 жил хуримтлагдсан асуудлууд. Өнөөдөр яригдаж, эрэмбэлэгдээд, түрүүн хэлсэнчлэн 2022 онд Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчилсний үндсэн дээр хот эдийн засгийн суурь боломжуудаа нээж авсан. Тэгж байж энэ том төслүүд хөдөлж эхэлсэн юм. Магадгүй цочирдмоор санагдаж байгаа: яагаад ийм их мөнгөтэй болчхов, яагаад ийм ийм бүтээн байгуулалт хийдэг юм бэ? Иргэд бидэнтэй хүсэж байгаа "хийгээд, бүтээгээд өгөөч" гэж. Тэгэхээр энийгээ хотын удирдлагууд бас зоригтой, дорвитой явуулах ёстой. Хүн болгоны аман дагавал улс хөгжихгүй, өдрөөс өдөрт доош орж, хойшоо малтана. Улаанбаатар хот гэдэг бол зөвхөн хурдны замаар шийдэгддэг, тодорхойлогддог асуудал биш. "Бордюр л солиод байна" гээд байна. Замаа шинэчилж байгаа учраас үүнийг дагаад шинэчлэгдэж байна гэж би ойлгож байгаа. Тийм мэдээлэлтэй байна. Энэ дээрээ нэгдүгээрт бодит хариулт өгөөч. Хоёрдугаарт түрүүн шинжээчийн нэг асуултын танилцуулга дээр гарч байна лээ. Сонгинохайрхан дүүргийн бейсболын талбай төлөвлөгдөөгүй, газар нь байхгүй, зураг төсөв нь өгөгдсөн гэсэн боловч 2024 онд эхэлчихсэн ажил шүү дээ. Би дүүргийн Засаг дарга байхдаа Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Хүүхэд залуучуудын театрын хойд талд 2 га газар чөлөөлсөн, 42 нэгж талбар гарсан, ердөө нэг айл зөвшилцөөгүй үлдсэн байсан. Зураг төсөв нь бэлэн байгаа. Үүнийг нийслэлийнхэн тайлбарлаж өг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тодруулаарай. Н.Алтаншагай гишүүний асуултад нийслэлээс хэн хариулах вэ? Б.Одбаяр дарга, 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Н.Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр байна. Хашлага солих нь өөрөө авто замын барилгын ажлын нэг хэсэг байгаад байгаа. Төсөвт өртөгт орж байгаа нийт төсөвт өртгийн 1-3% нь авто замын хашлаганд зарцуулагдаж байна. Хашлага гэдэг нь явган зам, гудамж, замын ангилал

руу орно гэсэн үг. Хот тосгоны барилгажилтын норм ба дүрмээр авто замын зураг төсөл дээр, барилгын ажлын зурагт гудамж барихад 2 талд нь явган зам хийгддэг. Явган замыг авто замын зорчих хэсгээс 15 см-ээс дээш өндөртэй байдлаар гаргаж өгдөг. Ингэснээр авто зам дээр явж байгаа тээврийн хэрэгсэл...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Уучлаарай, Б.Одбаяр дарга аа, та техникийн нэр томъёо, сантиметр, энэ тэрийг яриад яахав, шууд гишүүний асуултад хариулаад явахгүй бол цаг нь багтахгүй.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: 2024-2025 онд нийтдээ 232 км авто замын засвар, шинэчлэлийн ажлыг нийслэл Улаанбаатар хотод хийсэн байгаа. Энэ нь нийт гол гудамж замынхаа 80%-ийг шинэчилсэн гэсэн үг. Авто зам шинэчлэх ажлын хүрээнд зайлшгүй хийгдэх ажил нь хашлагыг өндөрлөх шаардлагатай байдаг. Үүний хүрээнд авто замын зураг төсөл дээрээ нийт төсөвт өртгийнхөө 1-3%-д хашлага солино гэдэг бол стандартын дагуу зайлшгүй хийгдэж байгаа ажлуудын нэг гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Н.Алтаншагай гишүүний микрофоныг өгье. Бейсболын талбайтай холбоотой мэдээлэл өгөх хүн байна уу? 7 дугаар номерын микрофоныг өгье. Овог, нэр, албан тушаалаа хэлье.

НЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулга: НЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулга байна. Н.Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Бид нар шинжээчдийн гаргасан саналтай ерөнхийдөө санал нэгдэхгүй байна. Тоо шинжилгээ дутуу хийсэн болов уу гэсэн бодолтой байна. Нийслэл төсвөө төлөвлөхдөө Хөгжлийн бодлогын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 278 дугаар тогтоол, бүх бодлогын баримт бичгүүдтэйгээ нийцүүлж төлөвлөдөг. Энэ хүрээнд 2024, 2025 оны аудитын дүгнэлт дээр ч нийслэлийн хөгжлийн бодлоготой нийцсэн байна, эрэмбэ дараа нь эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой байна гэсэн дүгнэлтүүдийг баримтаар бичсэн байдаг. Зарим тухайлсан асуудал дээр нийслэлийн төсөв батлагдах явцдаа иргэдийн саналыг, иргэдийн төлөөлөгчдийн саналыг нийцүүлэх, Төсвийн тухай хуулийн 6.5.5-д заасны дагуу олон нийтийн саналыг харгалзах учраас өргөн барьснаасаа бага хэмжээгээр өөрчлөгдөж төлөвлөгддөг. Улаанбаатар хотын хувьд төсвийн хөрөнгө оруулалт хийхэд төвөгтэй, хүндрэлтэй нөхцөл байдаг. Газрын асуудал болон бусад асуудлууд шийдэгдээгүй гэж шинжээчид, аудитын байгууллагууд зөрчил гэж үздэг эрх зүйн зөрчлийн асуудлууд байна. Бейсболын талбайн хувьд анх төсөв төлөвлөхдөө "газаргүй" гэсэн шинжээчийн дүгнэлт гарсан. Энэ хүрээнд бид НИТХ-аараа газар зохион байгуулалтын төлөвлөгөө баталж, газар чөлөөлөлтийн төлөвлөгөөндөө нийслэлийн төсөв өргөн барихаасаа өмнө "газар чөлөөлнө" гэдгээ төлөвлөөд, батлаад явчихсан байсан. Ийм төсөл, арга хэмжээ байгаа. Газар бүрэн чөлөөлөгдчихсөн, барилгын ажил хэрэгжээд явахад ямар ч асуудалгүй. Санхүүжилтийг Засгийн газрын тодорхой журмын дагуу, магадлал гарчихсан, гүйцэтгэлээр санхүүжүүлээд хууль, дүрэм журмын дагуу явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Н.Алтаншагай гишүүн үг хэлж болно шүү дээ.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Баярлалаа. Улаанбаатар хот тэлэх тусам шинэ тулгамдсан асуудлууд үүсэж байна. Саяхан Улсын Их Хурлаар батлагдсан цахилгаан дугуйтай холбоотой асуудал, зохицуулалтын асуудлууд хүртэл явж байна. 7 дугаар сарын 1-ээс хэрэгжинэ. Шинжлэх ухаан, технологитой холбоотой

тулгамдсан асуудлууд Улаанбаатар хотод сорилт болж улам цаашаа явна. 5-10 жилийн дараа эргэж харахад энэ сонсгол нэг тийм инээдэмтэй зүйл харагдана. Хүссэн хүсээгүй бид бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлаа хийнэ. Улсын төсөвт баригдахгүйгээр хот өөрөө бүх боломжоо дайчлаад явах ёстой. Дэд бүтцээ татах, зам харгуйгаа шинэчлэх, сургууль цэцэрлэгээ бие даан шийдэх хэрэгтэй. Хууль эрх зүйн хувьд боломж нь бүрэн нээгдсэн. Энэ хүрээнд бүх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд явж байгаа. Шинэ хотын удирдлагын баг ажлаа хууль эрх зүйн хүрээнд улам эрчимжүүлэх, урагшлуулах, алдаа дутагдалтай зүйл байвал засаад явна. Энэ сонсголтой холбоотой мэдээллүүд цаашаа үргэлжилнэ. Маргааш Туул хурдны зам, тойрог хурдны замтай холбоотой асуудлууд яригдах байх. Энэ дээр тодорхой асуултууд, саналуудаа хэлнэ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: УИХ-ын гишүүн Р.Батболдын микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Нэг ажлын хэсэг давхцаад байгаа учраас хэлье гэсэн зүйлээ хэлээд ганц нэг асуугаад гарья. Төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь зөв, хот ажил хийх ёстой — энийг дэмжиж байгаа. Гэхдээ төсөл хөтөлбөрийн санхүүжилтээ өөрөө төсвийн хуультайгаа уях ёстой юм гэдгийг нэгдүгээрт хэлж байгаа. Тэгэхээр яагаад хот өөрөө Улсын төсвийн алдагдлаас илүү 2,3 их наядын алдагдалтай төсөв баталчхаад яваад байгаа нь өөрөө асуудал үүсгээд байна.

Мэдээж сүүлийн 2 жилд нийслэлийн төсөв бараг 3 дахин нэмэгдчихээд байгаа. Тэгээд хийж байгаа ажлуудаа эрэмбэлж чадаж байна уу, үгүй юу гэдэг асуудал байгаад байна. Нийслэлийн шинэ захирагч сууж байна. Та энэ засаглалын асуудлаа нэг тийш нь шийдэх хэрэгтэй. Хотын 45 төлөөлөгчийн 43 нь ямар нэгэн байдлаар төрийн ажил, аж ахуйн ажил хийгээд явдаг ийм байдал байж болж байгаа юм уу, үгүй юу? Хэн нь хэндээ хяналт тавих гээд байгаа юм бэ? Нэг асуудал гарахаар "чиний наад асуудлыг асуудалгүй явуулж байгаа, чи энийг минь дэмж" гэдэг байдлаар хотын төлөөлөгчид ажлаа хийгээд яваад байдаг юм уу? Энэ дээр бодолтой хандах ёстой. Жишээ нь түрүүн би хэлсэн, хотын хийгдэж байгаа ажлуудыг дэмжээд байгаа.

Гэтэл хотын хийж байгаа ажил улсын төсвөөр хийж байгаа ажлаас яагаад үнэтэй болчихоод байдаг юм бэ? Хувийн хэвшлийн хийж байгаа ажлуудаас яагаад өртөг нь өндөр гараад байдаг юм бэ? Маш их давуу байдалтай байгаа шүү дээ. Тэгсэн хэр нь яагаад хувийн хэвшлийн хийж байгаа ажлыг үнэтэй болгоод байдаг юм бэ гэсэн асуудал байна. Энэ дээр их анхаарал хандуулж ярих ёстой. Жишээлбэл Н.Алтаншагай гишүүн сая хэлж байх шиг байна. Хот байшин барих ёстой юу, эсвэл нөхцөлийг нь бүрдүүлчхээд хувийн хэвшлээрээ хийлгэх юм уу? Хувийн хэвшил өөрөө байшин барьчхаад борлуулах үнэ нь 3,5 сая байхад хотын барьж байгаа барилгын өртөг яагаад 3,8 сая болчихсон яваад байдаг юм бэ? дэд бүтэц, холболтын зардал, газрын үнэ ороогүйгээр? Энэ асуудлыг л яриад байна. Тэгэхээр энэ дээр хэн хяналт тавиад байгаа юм? Хотын 45 төлөөлөгчийн хэн нь хяналт тавиад яваад байгаа юм бэ? Замын газрын даргаас асуумаар байгаа юм. Та нар "15 см өндөр байдаг" гэх мэт стандарт яриад л байгаа.

Жишээлбэл, ТЭЦ 4-ийн зам түрүү жил ашиглалтад орсон, 4 эгнээ болсон. Сая 5 сард бордюрыг нь сольж байна. Энэ ямар учиртай юм? Анхнаасаа яаж хүлээж авдаг юм? Анхнаасаа стандартаа ярьдаггүй юм уу? Хэн энийг хийлгээд байдаг юм? Та нарын бордюр чинь дуусах болоогүй юм уу? Та нар хэчнээн төгрөгөөр энэ явган зам, бордюрыг солих гэж байна? Төсөвлөчихсөн юм уу, эсвэл материалаа татаад

худалдаад аль хэдийнээ аваад ирчихсэн байж байгаа юу? Бид дахиад хэдэн сарын хугацаанд, эсвэл 2027 ондоо энэ замаа шинэчлээд бордюраа солиод явах юм уу? Та нарт нөөц нь ямар байгаа юм? Яг хэдэн төгрөгийн материал авчирчхаад тэрийгээ шахаж дуусгах гээд яваад байна аа? Зарим газар нэгийг нь босоогоор нь тавиад, нэгийг нь хөндлөн хэвтүүлээд тавьчихсан бордюруудын зураг нь олон нийтийн сүлжээгээр яваад байна. Та нар энийг яг юу гэж бодож байгаа вэ? Стандартын дагуу яваад байгаа юм уу? Ганц нэг зүйл асуумаар байна. Энэ явган замын чулуу, бордюртайгаа та нарт хэчнээн хэмжээний үлдэгдэл байгаа юм бэ, хэчнээн төгрөгийн татан авалт хийчхээд хэн нь шахаагаа хийчхээд бушуухан шиг хийж дуусгах гээд байгаа юм бэ? Энийгээ нэг хэлээд өгөөч. Ийм л асуудал байна. Хотын даргын анхаарах зүйл нь тэр 45 төлөөлөгчийнхөө асуудлыг нэг тийш нь шийдээд, хяналттай явмаар байна. Тэгэхгүй бол хяналт алга, бүгдээрээ нэг нэг аж ахуй авчихсан, тэгээд хэн хэн дээрээ хяналт тавих гэхээр болдоггүй ийм асуудал үүсээд байна. МАН бараг дангаараа гэхэд болно. 45-аас ердөө 5 төлөөлөгч АН-д байгаа биз дээ? Тэгэхээр МАН чинь 300 мянган гишүүнтэй гэж байгаа, хотод нь 100 мянган гишүүн байдаг гэхэд, та нарт ядаж энэ 140 хэдэн ААН-ийг удирдаад явчих боловсон хүчин байдаг байлгүй гэж бодож байна. Энийг бас анхаарч ажиллаач. Төлөөлөгчид төлөөлөгчдийнхөө ажлыг хийгээд, хяналтаа тавиад явмаар байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 8 дугаар микрофоноос хариулт өгнө үү.

НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах: Р.Батболд гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн төсвийн талаар Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлд орон нутгийн төсвийг тодорхой заагаад өгсөн байдаг. 57.2-т "Орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн хуульд нийцүүлэн алдагдалгүй төлөвлөн баталж хэрэгжүүлнэ" гэж заасан. 57.3-т "Орон нутгийн төсвийг урьд оны үлдэгдлээр санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага санхүүжүүлэх эх үүсвэр нь хэтрэхгүй байна" гэж заасан. Нийслэл хотын 2024 оны төсвийн орлогын гүйцэтгэл 3 их наяд 91,1 тэрбум төгрөг, төсвийн зарлага 3 их наяд 361,3 тэрбум төгрөг, тэнцлээр 271,2 тэрбум төгрөг гарч ирж байна. Тэгтэл төсвийн тухай хуулийн 57.3-д заасны дагуу он дамжих мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 490,6 тэрбум төгрөг байсан. Тэгэхээр он дамжуулсан буюу мөнгөн хөрөнгийн үлдэгдлээсээ бид хөрөнгө оруулалтын зардал дээр тусгаад байгаа учраас алдагдалтай гэж харагдаад байна. Тэгж тайлбарлагдаад байна гэж үзэж байна. 2025 оныг мөн адил авч үзэхэд төсвийн орлого 3 их наяд 826,6 тэрбум төгрөг, төсвийн зарлага 4 их наяд 526,2 тэрбум төгрөг, тэнцэл 702,2 тэрбум төгрөг. Үүнээс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2 их наяд 919,7 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаа. Үүнээс үнэт цаасны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1 их наяд 671,1 тэрбум төгрөг. Иймд бид нийслэлийн төсвийг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 57.3-ын дагуу урьд оны зарцуулагдаагүй үлдэгдэл, хөрөнгө оруулалтын үлдэгдлийг оруулаад яваад байгаа юм. Энэ бол Төсвийн тухай хуулиараа эрхийг нь нээгээд өгсөн байгаа юм. Орон нутгуудад өмнөх 10 жилд ч ингэж л явж байсан асуудал байгаа. Энэ дээр шинжээч буруу ойлголтоор "алдагдалтай" гээд тайлбарлаад байх шиг байна. Бид нар мөнгөн хөрөнгийн хуримтлагдсан үлдэгдлээсээ зарцуулалт гаргаад байгаа учраас энэ нь Төсвийн тухай хуулиараа эрхийг нь олгочихсон байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: 9 дүгээр микрофоныг өгье.

Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Б.Мөнхбат: Гишүүний асуултад хариулъя. Сэлбэтэй

холбоотой асуудал маргааш яригдах учраас нэг бүрчлэн асуудлыг нарийвчилж танилцуулах учраас давхардуулаад яахав. Маргааш гишүүнд Сэлбийн төсөлтэй холбоотой нэг бүрчлэн мэдээллийг асуултаар өгье. Бордюртой холбоотой асуудал ярьчихлаа. ТЭЦ 4-ийн зам өнгөрсөн жил хөнгөн хучилт хийгдсэн. Энэ жил ажил үргэлжилж байгаа. Тийм учраас өнгөрсөн жил бордюр тавиад энэ жил ахиж сольж байгаа зүйл огт биш. Энэ нь бүрэн шинэчлэгдэж дуусаж, комисс ажиллаж, бүрэн дуусах ажил байгаа. Явган замтай холбоотой ажил гэхэд 2025 онд 97,724 м² явган замыг шинэчлэх их тендер зарлагдсан, ААН-үүд шалгарсан. Энд нийслэл ямар ч материал өөрөө худалдаж авдаггүй. Худалдан авах ажиллагаанд шалгарсан хувийн ААН-үүд тухайн төслийнхөө хийх ажлын материалын таталт болон бусад зардлуудыг өөрсдөө зохион байгуулдаг. 2025 онд нийтдээ 97,742 м² талбайг шинэчилснээс явган зам дээр 48,220 м² талбайг шинэчилж хүлээж авсан. 2026 онд үргэлжлээд 69,708 м² талбайг хийхээр ажиллаж байна. Одоогийн байдлаар 69 мянгаас нь 23,328 м² талбай хийгдээд байгаа. Явган замыг 1,5 м өргөнтэйгөөр үзвэл нийтдээ 54,2 км урт явган зам хийхээс одоогийн байдлаар 38 км замыг хийгээд дуусаж байна. Үүнтэй холбогдсон бордюр солих, авто замын шинэчлэлтэй холбоотой бордюр солих асуудлыг "Зөвхөн бордюр л солиод байгаа" мэтээр зарим тохиолдолд олон нийтийн сүлжээгээр мэдээлээд байна. Бид бол авто зам болон явган замын шинэчлэлийн хүрээнд бордюр сольж байгаа, тэрнээс биш шинэчлээгүй замын хэсгийн бордюрыг ямар нэгэн байдлаар солиогүй. Үүнтэй холбоотой НЗД-ын зүгээс олон нийтэд зөв мэдээлэл өгөх ажлын хэсэг байгуулсан, удахгүй иргэдэд мэдээллээ өгнө. Нийслэл нэг ч материал татан авалт хийдэггүй, ААН-үүд тухайн төсөл хөтөлбөрийг хийхийн тулд өөрсдийн материалаа татаж хэрэгжүүлж байгаа гэдгийг нэмэлтээр хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Р.Батболд гишүүн.

УИХ-ын гишүүн Р.Батболд: Б.Мөнхбат дарга аа ААН-үүд нь өөрсдөө аваад татан авалтаа хийгээд явж байгаа юм. Тэгэхдээ бас ингэж яриад байх нь зохистой ч байдаг юм уу, үгүй ч байдаг юм уу. Та очоод харах юм бол 1 дүгээр хороололд хийгдэж байгаа зам хотын төвд 40 мянгатад хийгдэж байгаа зам. За ийшээ яваад одоо хаа хүрдэг юм. Багшийн дээд дээр ч гэдэг юм уу бүгдээрээ адилхан нэг хэлбэртэй, нэг загварын, нэг газраас ирсэн л материал байгаа байхгүй юу. Тэгэхээр зүгээр нэг ААН болгон өөрсдөө ажлаа авчхаад тэрэндээ тохируулаад материалаа авчраад юм хийгээд байгаа гэдэг бол бас үндэслэлтэй байх уу? үгүй юу? Үүнийгээ бас бодоорой. Яах вэ тайлбар чинь болж л байна. ААН-үүд нь ажлаа хийж байгаа. Ойлгож байна. Тэгэхдээ эрэмбэлээд явах юм бол хамгийн нэгдүгээрт хийх ажил чинь бас мөн үү, биш үү? Одоо би өөрөө 10 дугаар хороололд амьдардаг хүн. Манай 10 дугаар хорооллын 2 талын тэр замыг бүгдийг нь хуулаад сольчихсон. Ер нь бол шаардлагагүй байсан. Одоо ингээд яваад байх юм уу, эсвэл одоо нийслэлээс хийгдээд байгаа ажлууд чинь энэ хойшоогоо 7 буудал, Дамба, Амгалан гээд ч юм уу гараад явахаар одоо Сонгино, Толгойтоор гудамжнуудаа сайхан чулуулаад явсан бол хэлэх үг алга. Зүгээр байгаа бордюраа солиод байгаад л яваад байгаа чинь үнэн шүү дээ. Ер нь бол тэгэхээр энийг нэг их хамгаалаад байх юм бол байхгүй. Засвар үйлчилгээний ажил хийх хэрэгтэй юу гэвэл хийх хэрэгтэй байсан байх. Түүнээс биш бүтнээр нь нийтээр нь солиод явах нь энэ улс чинь тийм их мөнгөтэй болчихсон юм уу л гэдэг асуудал байгаа юм. Бид нар яг одоо та ЧД-ээс жишээлбэл, сонгогдсон байдаг гэр хороолол руугаа татсан замаа хийж байсан бол би танд алга ташаад гоё болж байна гээд хэлнэ шүү дээ. Гэтэл болохгүй байна шүү дээ. Дахин дахин зүгээр байгаа юмыг хуулаад солиод байгаа юм. Энийгээ сайн бас бодоорой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Би энэ дээр Р.Батболд

гишүүний асуулт дээр тодруулаад нэг мэдээлэл өгье. Та бүхэндээ нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн аудитын 3.1.6-д захиалагчийн хяналт хэрэгжиж буй 34 төсөл арга хэмжээний төлөвлөлтийн бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй буюу зураг төсөв магадлалаар баталгаажаагүй газрын зөвшөөрөл болон газар чөлөөлөлт шийдвэрлэгдээгүй байршил тодорхойгүй нөхцөлд гүйцэтгэгчид 380 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон, 380 тэрбум төгрөгөөс 321 тэрбум нь урьдчилгаа төлбөр олгосон. Өөрөөр хэлбэл, бэлтгэл хангаагүй төсөлд урьдчилгаа төлбөрт 320 тэрбум төгрөгийг зарцуулсныг шинжээчид биш нийслэлийн аудитын дүгнэлтээр гаргасан байгаа. Энэ дотор нь бордюр яриад байгаа болохоор энэ талаар мэдээлэл ирж байна. Явган хүний гарц, явган хүний зам талбай явган хүний зам талбайн тохижилт гээд эд нар нэг ойролцоогоор 40-50 орчим тэрбум төгрөг юм уу даа. Тэгэхээр зураг төсөвгүй зам засаад байж болдог юм уу гэдэг асуулт гарч байгаа юм. Зураг төсөвгүй зам засаад байгаа юм биш үү. Тэр нэг замын голд давхар бордюр тавьчихсан байна шүү дээ. Хоорондоо 20 см тэрийг бол техникийн хувьд тайлбарлаад тавьж болдог юм гээд дүгнэчихсэн. Тэрийг та нэмээд хариулаад өгөөч. Бордюртай холбоотой төсвийн алдагдал ярьсан алдагдлыг Сангийн сайдын танилцуулга дээр ярьсан шүү. Нийслэлийн төсвийн алдагдал 2,4 их наяд, улсын төсвийн алдагдал 1,4 их наяд. 1,4 их наядтайгаа харьцуулахаар 232% байна гэж. Энэ бордюртай холбоотой тийм зүйл байна. Б.Пүрэвдагва дарга нэмж мэдээлэл хийх үү.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Р.Батболд гишүүний асуулт дээр нэмэлтээр хариулъя гэж бодож байна. Ер нь төрийн өмчит ААН дээр барьж байгаа бодлого маш тодорхой байгаа. Манай нийслэлийн өмчит 114 байгууллага байна. Үүн дээр үр ашгийн болон чиг үүргийн шинжилгээ хийгээд цөөлөх бодлого барина. Нэгдүгээрт, чиг үүрэг давхар давхардсан ААН-үүдийг нэгтгэх бодлого барина. Дээрээс нь бизнесийнхний хийж чадах чиг үүргүүдийг бизнест нь чөлөөлж өгнө. Манай нийслэлийн өмчит байгууллагуудын ТУЗ-д бол хувийн хэвшлийн төлөөллийг хараат бус төлөөллийг оруулах бодлого барьж байгаа гэдгээ тодотгож хэлэх гэсэн юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Ганзориг гишүүн асуултаа асууя.

УИХ-ын гишүүн П.Ганзориг: За сонсголд оролцож байгаа Та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн нийслэлийн 2024-2026 оны төсвийн гүйцэтгэл, томоохон хэрэгжиж байгаа мега төслүүд, төсвийн үр ашиг, энэ асуудлуудтай холбоотой үр дагавруудыг ярьж байна. Улсын Их Хурлын гишүүд асууж байна. Нийслэлийн төлөөллүүд, холбогдох газрууд нь хариулж байна. Тэгээд бид энэ асуудлыг үр дагаврын талаас нь нэг удаагийн шинж чанартай гал унтраах гэж байгаа юм шиг яриад юу ч шийдэгдэхгүй. Өөрөөр хэлбэл, энэ хэдэн мега төсөл дээр асуудал гарлаа гээд АТГ нь байна уу, аудит нь байна уу, хяналт шалгалт хийгээд, нэг төрийн албан хаагчид, хэдэн хүмүүсээр туг тахисан болгоод л дуусна.

Би энийг яагаад хэлж байна вэ гэвэл НИТХ-ын төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Иргэдийн Хурлын төлөөлөгчөөр 2020-2024 онд 4 жил ажилласан. Энэ Иргэдийн Хурлын байгууллагын гажуудал, дотоод асуудлыг нь маш сайн мэднэ. 4 жилийн хугацаанд буюу 2020-2024 онд Нийслэлийн Иргэдийн Хурал дээрээс ярьж байсан. Тэгэхээр энэ бол үр дагаврыг нь нэг удаагийн сонсгол хийгээд, олон нийтэд яриад, нэг хэдэн хүнийг шоронд хийгээд ингээд дуусчихна гэж бодож байвал энэ том андуурал.

Хэнбугай ч хотын дарга болсон юу ч өөрчилж чадахгүй. Нэг нэгнийгээ намнах хэрэгсэл болоод л дуусна. Улс төрийн МАН-ын дотоод зовлон, зодоон болоод л дуусна. Гол асуудал нь юу байгаа вэ гэвэл энэ чинь тогтолцооны гажуудал байхгүй юу. Нийслэлийн Иргэдийн Хурал буюу нутгийн өөрөө удирдах байгууллага чинь Засаг даргаа хянаж чадахаа байчихсан. Угаасаа л хянаж чадахгүй явсаар ирсэн шүү дээ. Иргэдийн Хуралд нийслэлийн 1,6 сая иргэдийн 40-хөн хувь нь очиж сонгуульдаа оролцдог. Тэндээс талаас илүүг нь МАН аваад, буюу нийт одоо сонгогчдын 30 гаруйхан хувиар л 45 төлөөлөгчийнхөө 40-ийг нь бүрдүүлчихдэг. Нийт иргэдийн 70 хувь нь сонгохгүй байгаа шүү дээ, дэмжихгүй байгаа. Тэгээд хотынхоо даргыг МАН өөрөө томилдог, томилсоор ирсэн. Тэгээд тэр 45 төлөөлөгчийнхөө 40-ийг нь Засаг дарга нь өөрөө орон нутгийн өмчит компанийн удирдлагууд, төслийн удирдлага, ТУЗ-ийн дарга, гишүүн гээд томилоод өөрийнхөө удирдлагад оруулчихдаг. Тэгэхээр ийм гажуудчихсан, завхралдсан тогтолцоогоор бол энэ өөрчлөгдөхгүй ээ. Тэгэхээр бид нар юу өөрчлөх ёстой вэ? Энэ сонсголыг үр дүнтэй болгохын тулд юу өөрчлөх ёстой вэ гэвэл энэ гажуудлынхаа шалтгааныг өөрчлөх ёстой.

Энэ бол сонгуулийн тогтолцоо. Одоо ганцхан нийслэлийг бид нар яриад байна. 2020-2024 онд Нийслэлийн Иргэдийн Хуралд 3 нам байсан. МАН, АН, ХҮН нам гээд. ХҮН намаас 3 төлөөлөгч байсан. П.Наранбаяр, Д.Гантулга, миний бие бид 3 ажиллаж байсан. Тэгээд нийслэлийн олон асуудлыг бид нар хөндөж ярьж байсан. Тухайлбал, нийтийн тээвэр дээр 10 жилийн хугацаанд 2 их наяд төгрөгийн татаас өгсөн. Нийтийн тээвэр нь хүртээмж, чанар юу ч өөрчлөгдөөгүй. Тэр байтугай сүүлд ногоон автобусны хулгай гараад, тэрийг нь бид нар илчилж байж нэг юм жаахан анхааралд орж эхэлсэн шүү дээ. Тэгээд нэг түр зуурын юм болоод л өнгөрсөн. Би бас Хан-Уул дүүргийн Иргэдийн Хуралд 4 жил ажиллаж байхад одоо Засаг дарга нь Ж.Алдаржавхлан, 8 жил Засаг дарга хийсэн хүн. Иргэдийн Хурлын төлөөлөгч нь бүгд орон нутгийн өмчит компанийн захирлууд болгоод өөрийнхөө удирдлагад оруулчихдаг. Төсвөө батлуулахын тулд Иргэдийн Хурлын төлөөлөгч нь Засаг даргынхаа үүдийг сахидаг. Нөгөө талдаа тэр нь нөгөө намынхаа хорооны дарга нь.

Ийм засаглалын хямралд орчихсон тогтолцоо яаж Иргэдийн Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага өөрөө бие даасан байдал, хараат бус байдал, иргэдийн нүд, чих, дуу хоолой болж явах юм бэ? Тэгэхээр бид эндээс сонгуулийн тогтолцоогоо өөрчлөх л асуудлыг шийдэхгүй бол болохгүй ээ. Тэгэхээр би хотын даргаас асууя. Одоо энэ тогтолцоонд бид дор хаяж Нийслэлийн Иргэдийн Хуралд нийт 45 төлөөлөгчийн байна уу, нийт төлөөлөгчдийнхөө тоог өөрчилнө үү? Ядаж талыг нь холимог тогтолцоогоор сонгож, олон намын тогтолцоо, хяналтын тогтолцоо, сөрөг хүчний дуу хоолойг оруулж, түүгээр дамжиж иргэдийн одоо хяналтыг, хатуу хяналтыг тавихгүй бол энэ өөрчлөгдөхгүй. Та дийлэхгүй. Энийг өөрчилж, таны нөгөө талд чинь Нийслэлийн намын хороо чинь байж байгаа, дарга нь өөр хүн байж байгаа, бүлэг чинь байж байгаа. Шал өөр юм ярина тэнд. Тэгээд бид иймэрхүү зүйлийг хэлээд хэлбэр төдий болно. Тэгэхээр энэ сонгуулийнхаа тогтолцоог нэгд өөрчлөөд, Нийслэлийн Иргэдийн Хурлынхаа байна уу, аймаг, сум, дүүргээ цуг оруулаад, ядаж талыг нь холимог тогтолцоо буюу пропорциональ элемент оруулах дээр манлайлал үзүүлж, энэ Улсын Их Хурал дахь намынхаа бүлэгтэй, намынхаа Удирдах зөвлөлтэй ярьж ажиллаж чадах уу?

Хоёрт, дэлхий дээр байгаа одоо хөгжиж хөгжчихсөн улсуудын ер гаруй хувь нь хотын даргаа иргэдээсээ шууд сонгодог. Энэ тогтолцоо руу шилжүүлэх дээр бас манлайлал үзүүлж, дуу хоолой болж ажиллаж чадах уу?

Гуравт, Иргэдийн хурлынхаа төлөөлөгчид Засаг даргынхаа шууд удирдлага

дор төсөв мөнгө болоод бусад хараат байдлаасаа гаргаж, бие даасан, хараат бус байдлаар ажиллуулж чадах уу? Энэ тогтолцоог өөрчлөөгүй цагт өнөөдрийн яриад байгаа таны энэ мэдээллийг нь ил тод болгоно, засаглалыг нь сайжруулна гээд байгаа зүйл бол түр зуурын нэр төдий зүйл. Юу ч өөрчлөгдөхгүй. Тэгэхээр дараа дараагийн аль ч шатны Засаг дарга нар нь бай, одоо байгаа системээр Иргэдийн Хурлынхаа төлөөлөгч буюу өөрийгөө хянадаг төлөөлөгчдөө өөрийнхөө удирдлагад оруулчихсан цагт дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэнэ. Тэгсээр ирсэн, тэгсээр ч байх болно. Тэгэхээр энэ асуудлыг манлайлал үзүүлээд намынхаа системээр өөрчлөж чадах уу? Мэдээж Иргэдийн Хуралд энэ хуулийг нь өөрчлөөд явах санаачилга, хууль эрх зүйн бололцоо байхгүй. Ингэж ажиллаж чадах уу? Тэгээгүй цагт бид нар нэг хэдэн төслийн гүйцэтгэл, үр ашиг, хяналт, эрэмбэ, төсөвт өртөг нь өндөр, нам байна гэдэг зүйл яриад нэг удаагийн үзэгдэл болж дуусна. Тэгэхээр үр дүнтэй болгохын тулд энэ дээр нэг тодорхой хариулт авчхаад тэгээд тодруулъя. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За, хотын дарга 10 дугаар микрофон нээж өгье.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва: Эрх зүйн шинэчлэл бол тэр чигээрээ УИХ-д бүрэн эрх нь байгаа. Та сая хэллээ, НИТХ-д эрх нь байхгүй. Одоогоор сонгогдсон энэ 45 төлөөлөгч бол яг өнөөдрийн Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, журмын дагуу иргэдээсээ сонгогдоод ирчихсэн ийм л 45 төлөөлөгч шүү дээ. П.Ганзориг гишүүн, та бид хоёр ч гэсэн 2020 онд яг энэ хуулиар сонгогдоод орж ирж байсан. Хуулийн дагуу л юмнууд явж байгаа. Цаашдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчлэл хэрэгтэй юм байна лээ. Нэг талдаа иргэд, сонгогчид төлөөлөгчийг төлөөлөгч чигээр нь ойлгохгүй тал байдаг. Гүйцэтгэх засаглалын төлөөлөл юм шиг. Нэгдүгээрт, энэ ойлголтыг тодорхой болгох шаардлагатай. Хоёрдугаарт, нэгэнт иргэдээс сонгогдсон бол ажиллах боломжоор нь бид нар хуулиар хангаж өгөх шаардлагатай байх. Ямар ч төсөв байхгүй, зарцуулалт байхгүй төлөөлөгч эргээд иргэд дээрээ очоод нүүрээ хийх газаргүй болдог. Тэгээд иймэрхүү асуудлаас болоод л бид нарын ярьж байгаа нөхцөл байдал үүсэж байгаа шүү дээ. Гол шалтгаан нь, миний хувьд бол ямар нэгэн хувийн ашиг сонирхол байхгүй учраас энэ зүйлүүдийг шинэчлэх тал дээр хатуу байр суурьтай байж чадна. Хамгийн эцсийн эрх нь бол УИХ дээр байж байгаа. Хот, тосгоны тухай хууль дээр Засаг даргыг бүх нийтээр сонгох тухай заалтууд мөн хэрэгжээд, ярилцаад, хэлэлцэгдээд явж байгаа. Тэгээд УИХ-ын гишүүд маань бас энэ дээр анхаарч байгаа байх гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Ганзориг гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн П.Ганзориг: Өнөөдрийн сонсголыг үр дүнтэй болгохын тулд бид нар үр дагавраас илүүтэйгээр, миний хэлээд байгаа санаа бол учир шалтгааныг нь шийдэхгүй л бол болохгүй. Иргэдийн хурлын төлөөлөгчдийн асуудлыг би маш сайн мэднэ. Зовлонг нь мэднэ. Иргэдээ төлөөлөөд ажилладаг, ажиллах орон зай, ялангуяа төсөв мөнгөн дээр тойрогтоо шийдэх асуудлууд нь хязгаарлагдмал. Тэгэхдээ иргэдийнхээ хурлын түвшинд тэр төсөв мөнгийг нь шийдээд явах тал дээр Иргэдийн Хурал нь өөрөө шийдвэрээ гаргаад л явах бүрэн боломжтой. Одоо тэр тухайн төлөөлөгчдийнхөө оруулж ирж байгаа санал үндэслэлтэй байх юм бол төсвийг нь шийдээд явах ийм боломжууд нь байж байгаа шүү дээ. Миний хэлээд байгаа санаа бол Иргэдийн Хурлын төлөөлөгчдийн бие даасан, хараат бус, хүчтэй,

Засаг даргадаа хяналт тавиад явах боломжийг нь нэгд бүрдүүлэхгүй л бол энэ асуудал шийдэгдэхгүй. Засаг даргаасаа хараат Иргэдийн Хурал яаж бие даасан шийдвэр гаргаж чадах юм? Яаж иргэдээ төлөөлж чадах юм? Энийг нь дэмжиж өгөх гээд байгаа. Иргэдийн Хурлын төлөөлөгчдийнхөө тэр бие даасан байдлыг л дэмжиж өгөх гээд байгаа юм. Нөгөө талдаа ийм байдал байгаа болохоор энэ зах замбараагүй том төсвийн тэлэлтүүд одоо нийслэл дээр гарч байна. Тэгэхэд чинь 16 төсөл 29 их наяд төгрөгийн өртөгтэй. Үүнд зориулаад 2.5 их наядын бондыг Засгийн газрын хоёр тогтоол, Улсын Их Хурлын нэг тогтоолоор гаргаад авчихсан. Төсвүүдээ батлахдаа анхнаасаа энэ мега төслүүдээ тухайн төслүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн нөлөө, байгаль орчны нөлөө гээд олон асуудлуудынх нь тооцоо судалгаанууд нь бас дутмаг. Уг нь ийм байдалтай гаргаж байхад Иргэдийн Хурлын төлөөлөгч нар чинь энэ дээрээ дуу хоолой нь болоод, хяналт шаардлагаа тавиад явж байх ёстой байхгүй юу. Ийм юм байхгүй байгаагаас болоод л энэ том асуудлууд чинь нөгөө “ниргэсэн хойно нь хашхирав” гэгчээр явсных нь дараа бид нар үр дагавартай нь зууралдаад байгаа юм.

Тэгэхээр эхнээс нь бол энэ тогтолцоог зөв болгохын тулд энэ рүү чиглүүлэх дээр МАН-ын л манлайлал чухал. Энэ бол нийслэлийн иргэдийн 45 төлөөлөгчийн асуудал биш шүү. Нэг дүүргийн, аймгийн Иргэдийн Хурлын төлөөлөгчдийн асуудал биш. Олонх болоод явж байгаа МАН энэ асуудлаа, энэ гажуудлаа нэг засахгүй бол болохгүй. Улсын Их Хурал дээр бол 2024 онд 126 гишүүнтэй болж, 5 нам эвсэлд ороод тодорхой хэмжээнд олон ургалч үзэлцээд, олон асуудлууд дээр бас тодорхой байр сууриуд нь зөрдөг. Тэрэн дээрээ үндэслэлээ тайлбарлаад, хянаад, шалгаад явдаг.

Ингээд зөв голдирол руугаа орж байна шүү дээ. Түр зуур харахаар ингээд төр бужигнаад байгаа юм шиг мөртөө цаашдаа эрүүлжих гээд оролдоод байгаа оролдлого гэж энийг нөгөө талаар бас ойлгож болно. Тэгэхээр өөрчлөх дээр бас онцгой анхаарч ажиллахгүй бол эцсийн эцэст яадаг вэ гэвэл ажил хийсэн, тэр ажлыг хийж байгаа, тэр төслийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчид нь байна уу, төлөөлөгчид нь байна уу, хувийн компаниуд нь байна уу, бас зөв зүйлийн төлөө явж байгаа хүмүүс зөндөө байгаа байх. Бас хохироод үлддэг.

Тэд нараараа туг тахиад, түр зуур намжаагаад өнгөрдөг ийм тогтолцоо л үргэлжлээд явах гээд байна. Тийм болохоор энийг нэг сууриар нь засчихаасай гэж бодсоны үүднээс энийг би хэлж байгаа юм шүү. Тэрнээс биш одоо би энэ төсөл болгоны үр ашиг, эдийн засгийн тооцоо, үндэслэл, эрэмбэ гээд л асуугаад байвал зөндөө юм байна. Энийг бид нар ярилаа, хэллээ гээд иргэдэд нэг мэдээлэл өгөөд л өнгөрнө. Тэгэхдээ нөхцөл байдал буюу тогтолцоо өөрөө өөрчлөгдөхгүй. Тамын тогооны үлгэр шиг л юм явж байгаа шүү дээ. Энэ нь бол үргэлжлээд яваад байна аа. Тэгэхээр энийг бас анхаарч, энэ рүү нь та өөрөө манлайлал үзүүлж, намынхаа Удирдах зөвлөлийн хэмжээнд санал солилцоосо гэж хүсэж байна. Удирдах зөвлөлөөс би таныг санал болгож тавигдсан гэж ойлгож байгаа. Хоёрт нь, Улсын Их Хурлын намынхаа бүлэгтэй бас намынхаа шугамаар холбогдоод ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Тэнд байгаа Улсын Их Хурлынхаа бүлгийн гишүүдэд ойлгуулж, дэмжүүлэх тал дээр анхаараарай. Мэдээж Улсын Их Хуралд байгаа бусад, одоо ХҮН нам, АН гээд. За би одоо ХҮН намын зөвлөлийн даргын хувьд энэ асуудлуудыг хууль санаачлах эрхийнхээ хүрээнд манлайлаад ингээд явна. Тэрийг дэмжээд бид нар явсан цагт бол энэ цаашдаа тогтолцоогоороо өөрчлөгдөж, энэ авлига, хээл хахууль, алдаа завхрал цэгцрэх боломж бүрдэх юм гэдгийг хэлье. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: УИХ-ын гишүүн

П.Сайнзоригийн микрофоныг өгнө үү.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Баярлалаа. Юун түрүүнд өнөөдөр нийслэлийнхээ иргэдээсээ уучлалт гуймаар байна. Бид олон жилийн турш нийслэлийн иргэдийг аятай тухтай амьдрах стандартад нийцсэн төрийн үйлчилгээтэй, өмч хөрөнгийг нь хамгаалсан, утаа униаргүй, түгжрэлгүй амьдруулах ажлаа хийж чадаагүй 30 жил мөлхөж байгаад өнөөдөр хийж байгаа хүмүүсийн шийдлийг нь гаргангуут гэнэт цочиж байгаа юм шиг асуудалд улс төржүүлж зарим талаасаа хандаж байгаад нь харамсаж байгаа. Ийм зүйл болж байгаад нийслэлийн иргэдээсээ уучлалт гуйж байна.

Би П.Ганзориг гишүүнтэй санал нэг байна. Тухайлсан төслийн талаар асуувал зөндөө юм асууж болно. Гэхдээ суурь зарчмын асуудлуудаа хэлж ярих нь зөв байх. Үндсэн хуульд заасан нутгийн өөрөө удирдах ёс, төрийн байгууламжийн нэгдмэл байдал гэдэг зүйлүүдийг бид үнэхээр ойлгохгүй хольж хутгаж иргэдийг төөрөлдүүлж байна. Би үүнд харамсаж байгаа. П.Ганзориг гишүүний хэлж байгаа саналуудыг УИХ-ын олон гишүүд маань сонсоосой гэж хүсэж байна. Энэ чинь бид нарын баталсан хууль шүү дээ. Сангийн сайдын хэлээд “пүү паа” гээд гарч яваад байгаа заалт 2011 онд Төсвийн тухай хуулийг шинэчлэн батлахдаа л оруулсан заалт. Одоо хүртэл түүний хэрэгжилтийг дүгнэж асуудлыг ярьж чадаагүй байж байгаад өчигдөр бүх зүйл болчихсон юм шиг ярьж байна. 2022 онд нэгжийн хуулийг баталж байхад ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гээд хүнд “Энэ орон нутгийн хямрал руу явууллаа шүү, болиоч ээ” гэж хэлсэн юм. Аваагүй. Ажлын хэсэг дээр дараа нь гэр хорооллыг орон сууц болгох, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах хууль буюу 2023 онд энэ алдааг засах гээд өргөн барьсан, хасагдсан. Би юу хэлэх гэж байна гэвэл засаглал талаасаа иргэдийн төлөөлөгчдийн хурлуудыг давхар ажил хийлгэхгүй байх, түрүүн ярьсан цалин хөлс, эсвэл урамшууллыг нь олгох.

Манай Ч.Лодойсамбуу гишүүн залуу хүн, тэгэхдээ Үндсэн хуулийг зөв унших хэрэгтэй. Хоёрын хооронд улс төржиж болохгүй. Хууль санаачлах эрхтэй, хамтраад санаачилъя гэвэл санаа нийлж байна. Тийм санаа нийлэх гишүүд олдож байгаад баяртай байна. Гол асуудал юу вэ гэхээр жишээ нь Ч.Лодойсамбуу гишүүн, энд сууж байгаа Г.Амартүвшин хоёр Хан-Уул дээр адилхан зардал, хүн хүчээр гарч ирсэн шүү дээ. Үнэндээ хэлэхэд бид нар зүгээр юмыг булзааруулаад яриад байж чадна. Гэвч бодит нөхцөл байдал, төрийн бодлогын шийдвэрүүд юунд аваачив гэдгийг бодох хэрэгтэй. Нэгжийн хуулийг хийчхээд одоо энэ хуулийн дагуу ажиллаж байгаа хүмүүсийг буруутгаад "Та нар яагаад ингээд байгаа юм?" гэж болохгүй шүү дээ. Угаасаа УИХ-аас баталж өгсөн хууль эрх зүйн орчин нь шүү дээ. Тиймээс энэ зүйлүүдийг гишүүд маань ойлгоосой. Одоо хурал даргалагч ер нь гаргах зөвлөмж, энэ тэрээ сайн бодоосой гэж хүсэж байна. 2022 онд алдаа гарна гэдэг зүйлийг хангалттай хэлсэн. 2023 онд энэ алдааг засах гээд холбогдох хуулийн төслийг өргөн бариад унагаасан.

Нийслэлийн, ядаж нийслэлүүдийн ИТХ-д давхар ажил хийлгэхгүй байдлаар урамшууллыг нь олгоод үлдээчихье, Засаг даргадаа хяналтаа тавиагүй гэсэн. "Үгүй ээ" гээд тухайн үеийн манлайллыг одоо та бүгдийн сонсгол зохион байгуулж байгаа хүмүүсийн үзэн ядаад байгаа Х.Нямбаатар дарга өөрөө санаачлаад гүйсэн. Дагуулж чадаагүй. Ийм зүйл байгаа. Өнөөдөр УИХ-ын түвшинд бүх зүйлийг ярьж болно гэдэг ийм буруу сэтгэлгээнээс одоо Улаанбаатарыгаа яриад сууж байгаа. Дараа нь аймаг, аймаг дээр болж байгаа бүх юмаа татаж ярих юм байна л даа. Өнөөдрийн баталсан хууль эрх зүйн орчинд асуудлуудыг шийдэхийн төлөө явж байхад Өмнөговь тэнд дааж давшгүй ногдол ашгаараа нутгийн хишиг тараагаад явж байхад хэн ч ярихгүй

шүү дээ. Одоо ярих юм байна л даа, энэ маягаараа бүгдийг нь ярих байх. Энд 126 хүн бүгдийг төвлөрүүлж удирдаж шийдвэр гаргадаг гэдэг энэ балай сэтгэлгээнээсээ бид нар салах ёстой. Өгсөн эрх мэдэл, түүнийгээ зөвөөр хэрэгжүүлж байна уу гэдэг дээр хяналтаа тавихыг би хэзээ ч үгүйсгээгүй. Энэ сонсгол нэг талдаа олон зүйлүүдийн зааг ялгааг харагдуулж байна. Үнэхээр буруутай янз бүрийн юмнуудыг хууль хяналтын байгууллага нь шалгах биз. Зааг ялгааг гаргах зүйл рүүгээ явж байгаад таатай байна. Улаанбаатар хот түгжрэлээсээ салах хэрэгтэй биз дээ. Хөрсний бохирдлоосоо, агаарын бохирдлоосоо салах хэрэгтэй. Энэ түгжрэлээс болж гэр бүлд зарцуулах цаг гэж байхгүй. Орон сууцанд аятай тухтай амьдрах хэрэгтэй. Өнөөдөр орон сууцанд амьдарч байгаа хүмүүс халуун усны төлбөрт 40-50 мянган төгрөг төлж байхад гэр хороололд амьдарч байгаа хүмүүс халуун усны газар ороод үйлчилгээгээ авахад үүнээсээ 3 дахин илүү төлдөг шүү дээ. Ийм аймар өрхийн зардал нэмэгддэг. Тэр хүмүүс өөрийгөө гэр бүлдээ зарцуулах цагаа нүүрсээ хагалж, нүүрсээ зөөгөөд суудаг юм. Тэгэхээр энэ орон сууцжуулах бодлогыг зайлшгүй хийе ээ гэдэг зүйл байгаа. Үнэхээр гэр хорооллын амьдралд үзээгүй, тэрүүгээр явж үзээгүй хүмүүс өнөөдөр гоё ганган юм яриад нутгийн өөрөө удирдах ёсны хүмүүсийг авчирч суулгаад загнаад сууж байгаад харамсаж байна. Тэр хүмүүс уг нь гудамжинд гараад ажлаа хийж байх ёстой. Бид хэн рүүгээ сонсголоо хийх ёстой байсан бэ гэхээр Засгийн газрын орон нутаг хариуцсан сайдаа дуудаад ярьж байх ёстой байсан юм. Өнөөдөр бүх юм шат шатдаа алдагдлаа. Удахгүй хаа хаанаас бүх аймгуудын удирдлагуудаар нь дуудаж авчирч байгаад загнаад суудаг өвчтэй хүмүүс болох юм байна. Энэ хил хязгаараа цаашдаа бодох ёстой шүү гэдэг зүйлийг хэлье. Үнэхээр төсвийн асуудал байвал 2011 онд баталсан Төсвийн хуулийнхаа хэрэгжилтийг хэдүүлээ яримаар байна. Засаглалын асуудал алдаад байгаа бол 2022 онд баталсан нэгжийн хуулиа эргэж харъя. Ийм зүйлүүд байна.

Өнөөдрийн ийм тодорхой бус сонсголчуудын дараа улс төржилт нь үргэлжлэх юм бол энэ мега төслүүд эрсдэлд орно. Энэ төслүүдийн хамгийн том эрсдэл бол хоосон улс төржилт. Би энэ нийслэлд ажиллаж байхад хамгийн түрүүнд иргэдийн санал хүсэлтийг харахад "Замаа засаач ээ" гэдэг байсан. Зассан. Эрчим хүч, тог тасрахад "Эрчим хүчний эх үүсвэрийг бариач ээ" гэж хэлсэн. "Түгжрэл, утаагаа шийдээч ээ, орон сууцанд амьдармаар байна" гэж хэлсэн. Жилд 50 мянган хүн ипотекийн зээлд хамрагдах гээд хүлээгээд байж байгаа шүү дээ. Гэтэл хувийн хэвшил үсрээд үсрээд, хичээгээд хичээгээд 19 мянга. Энэ хувийн хэвшлийн зах зээл рүү ороогүй байгүй юу. Цаана нь 31 мянган хүн орон сууцаа хүлээгээд хамрагдъя гээд байж байна. Энэ зах зээлийг хувийн хэвшил одоохондоо дийлж чадахгүй байгаа.

Хоёрдугаарт өнөөдрийн Улаанбаатар хотын асуудал маш төвөгтэй байсан юм. Өнөөдөр энэ танхимд уг нь 23 их наядаар тоглож байгаа төрийн өмчит компаниудынхаа төсвийг ярих ёстой байсан. Жилд 23 их наядаар ТӨК-ийн 100 компани тоглож байхад зарим нь үр ашигтай ажиллаж байгаа, тэр 5-6 компани байгаа. 90 орчим компани нь 23 их наядаар улс төрчдийн хамаарал бүхий хүмүүс тоглож байхад хэн ч дуугараагүй, сонсгол хийгээгүй байж байж энд өнөөдөр хуульд заасны дагуу чиг үүргээ хэрэгжүүлж байгаа хүмүүсийг дуудаж авчраад ажлыг нь үүрээд, хэн нэг этгээдүүд улс төрийн оноо цуглуулаад сууж байгаад харамсаж байна. Би хэлэх үгээ хэлж байна шүү дээ. Тийм зүйл байна. Энэ дээрээ манайхан бодно биз дээ. Засаглалыг сайжруулах гэдэгтээ 100% санал нэг байна. Энэ асуудлыг сонгуулийн хуулийг ч гэсэн тухайн үед Э.Бат-Амгалан гишүүн, өнөөдрийн БХБ-ын сайд хувь гишүүнийх нь хувьд өргөн барьж байсан юм. "Сонгуулийн тогтолцоогоо ингэж засъяаа" гээд парламент нь хүлээж аваагүй, хэлэлцээгүй. Оруулж ирсэн зөв зүйтэй зүйлсийг нь дандаа унагааж байсан. Ер нь мөнгөгүйгээр шийдэгдэх юм байхгүй. Хэрэв бид олон улсаас босгож ирсэн бололцоот бүх зүйлүүдээ зөв ашиглаж

чадахгүй байх юм бол цаашид бидэнтэй харьцах хөрөнгө оруулагч бараг үлдэхгүй дээ. Үүнийг бид бодолцох ёстой. Үнэхээр зөв буруу зүйлүүд байдаг бол засаж залруулах асуудал нээлттэй. Юмнуудыг хэт улс төржүүлнэ гэдэг бол үнэндээ том эрсдэл.

Парламент дээр бүх зүйлийг төвлөрүүлээд амсуулах байдлаар юу ч шийдэгдэхгүй гэдгийг ойлгож байгаа шүү дээ. Өнөөдөр 40 жил жишээ нь ганц ч эрчим хүчний эх үүсвэр барьж чадаагүй улс шүү дээ. Гэтэл нийслэл өнөөдөр 2 жилийн дотор газрыг нь чөлөөлөөд, мөнгийг нь босгоод төр-хувийн хэвшлийн түншлэлээр 5 дугаар цахилгаан станцыг барих гэж байна. Тэгэхээр ийм зүйлүүдээ хэлмээр байна. Орон нутагт өгсөн эрх мэдэл рүү бид ингэж булаацалдах биш, эрх мэдлийн асуудал байвал орон нутгийн асуудал хариуцсан ЗГ-ын гишүүдтэйгээ энд яримаар байна.

Нийтлэг асуудал ярих гэж байгаа бол 21 аймгийн Засаг дарга энд ирээд суумаар байна. Ямар асуудал үүсээд байна, тэгээд энэ дээрээс анхааръя гэдэг зүйлийг яримаар байгаа юм. Төсвийн 53.7 чинь бүх аймагт хамаатай шүү дээ, Б.Мөнхсоёл гишүүн ээ. Та ганцаараа ухаантай байх. Энэ нэгжийн хууль чинь бүх 21 аймагт хамаатай. Үгүй ээ, мушгиад байгаа юм алга. Нийтлэг юм хумаа хэдүүлээ ярьж сурах хэрэгтэй. Б.Мөнхсоёл гээд ганц ухаантай хүн бүгдийг ингээд загнаад байж чадахгүй. Нийслэлийн иргэд орон сууц, түгжрэл, утааг шийдээч ээ л гэж байгаа юм. Мөнгөгүйгээр, тодорхой хэмжээний олон улсын төр-хувийн хэвшлийн түншлэлгүйгээр энэ асуудал шийдэгдэх юм уу гэдгийг та зүгээр асуугаад үз. Хэн ч бүгдийг загнаж авчраад "Аятайхан байгаарай" гэж хэлээд байж чадна. Гишүүд маань ч энийгээ бодно биз.

Харин та бид нар энэ дээр ажлын хэсэг гаргаад хууль эрх зүйн орчныг нь засах бүрэн эрхтэй, үүрэгтэй. Үүнийгээ бид хараасай гэж хүсэж байна. Замын чанарыг ч мэддэггүй юм байна. Зам олон улсын талаасаа 4 ангилагддаг шүү дээ. Чанартай, дундаж чанартай, чанар муудаж байгаа болон чанаргүй. Доод талын 2 ангилал руу оруулахгүйгээр, суурь бүтцийг эвдэхгүйгээр замаа засвал өртөг нэмэгддэг. Гэтэл иргэд заавал зам дэлбэрсэн хойно, суурь бүтэц эвдэрсэн хойно зам засах ёстой гэдэг "мөнгөгүйн сэтгэлгээгээр" бүх юманд хандаж байна. Үнэхээр харамсаж байна. Энийг мэргэжлийн хүмүүсээс сонсвол өөр харагддаг. Иргэд олон нийтдээ мэдээллээ зөв өгч ажиллах. Б.Пүрэвдагва дарга, бусад хүмүүсийг авчраад "Та нар засаглаад сайжруул" гэж загнах биш, бид нар харин ажлаа хийх ёстой юм байна гэдгийг гишүүд маань ойлгох санаачилга байгаа юм байна гэдэгт талархаж байна. Зөв бурууг нь хуулийн байгууллага АТГ, прокурор, цагдаа шалгаад нэг талдаа гарах байх. Шат шатны хэмжээнд хяналтаа тавих.

Тэрнээс биш хоосон улс төржүүлбэл нийслэлийн асуудлууд дахиад хэдэн жилээр шийдэгдэхгүй явна гэдэг бол энд амьдарч байгаа хүмүүсийн цаг, зардал, амьдралын өртөг гарна. Олон нийтийн сүлжээн дээр зүгээр сайн санааны үүднээс мэдээлэл дутуу зүйлс яригдахыг үгүйсгэхгүй. Тэр хүмүүсээ татаж оролцуулаад, мэдээллээ өгөөд л ажиллах ёстой. Хаа хамаагүй бүх зүйлс буруу байсан гэдгээр явах юм бол 21 аймгийн асуудлуудыг цаашдаа шийдэж чадахгүй. Бид яг эндээс, төвөөс удирдана гэвэл бүх зүйл байхгүй болно.

Эцэст нь протоколд дахин дахин давтаж хэлье. Б.Пүрэвдагва дарга байдаг юм уу хэн нэг нь хариулаач. Нэг яриад байгаа мега төслүүд чинь ерөнхийдөө УИХ-ын шийдвэртэй нь хэд юм, УИХ-аар батлагдсан бодлогын баримт бичигт тусгагдсан нь хэд юм? Огт бодлогын баримт бичигт тусгагдаагүй нь хэд юм? Энэ бүх суурь

судалгаа нь миний мэдэж байгаагаар олон улсын байгууллагуудаар хийгдсэн, олон улсын байгууллагуудын өгсөн зөвлөмжөөр болон бусад зүйлүүдээр хийгдэж байгаа нь хэд байгаа юм? Энэ 16-аас яг төсвөөс санхүүжүүлээд явж байгаа нь хэд байгаа юм? Ихэнх нь бид бусдын мөнгөөр асуудлаа шийдэх гээд босгож ирсэн мөнгө шүү дээ. Тэгэхээр энэ зүйлүүдээ нэг тоо статистикийн хувьд зүгээр хариулчхаач. Энэ бүх суурь судалгаануудыг нь бол миний мэдэж байгаагаар дандаа олон улсын байгууллагуудаар хийгдсэн, олон улсын байгууллагуудын өгсөн зөвлөмж болон бусад зүйлүүдэд үндэслэж хийгдэж байгаа. Тэгэхээр энэ 16 төслөөс яг улсын төсвөөс санхүүжүүлээд явж байгаа нь хэд байгаа юм бэ? Ихэнх нь бид нар бусдын мөнгөөр асуудлаа шийдэх гээд босгож ирсэн мөнгө шүү дээ. Тиймээс энэ зүйлүүдээ бас нэг тоо статистикийн хувьд зүгээр хариулчих аа. Би одоо ганцхан л ийм асуулт асууя. Энэ одоо нийслэлд бол олон мега төсөл байгаа. 24 төслийг сонгож байсан, төсөв мөнгөө босгож байгаа 16 төсөл байгаа. За энэ 16-аас та нэг дурдаад, УИХ гэдэг юм уу, энэ одоо бодлогын шийдвэр нь гарсан хэд байгаа юм, олон улсын судалгаа шинжилгээ, зөвлөмжийг дагаж хийгдэж байгаа нь хэд байгаа юм? Ийм зүйлүүдийг бас нэг одоо иргэд олон нийтэд мэдээлэл болгож өгөөч ээ л гэж байгаа юм. Хэлье. Тэгээд өөр өөрсдийнхөө цаг дээр. Би одоо Б.Мөнхсоёл гишүүний ярьж байхад ч хүндэтгэлтэй хандаад л сонсож байсан. Тэгэхээр хэн хэндээ хүндэтгэлтэй хандъя л гэж одоо хүсмээр байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Сайнзориг гишүүний асуултад Э.Түвшинжаргал дарга хариулна аа. 11 микрофон нээж өгнө үү.

Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа нийт 24 мега төслийн одоо бодлогын баримт буюу эх сурвалжуудыг бол бид хэд нэг бүрчлэн эмхэтгэж гаргалаа. За, үүнд бол олон улсын гэрээтэй 4 төсөл, хөтөлбөр байна. За, бодлогын баримт бичигт тусгагдсан, өөрөөр хэлбэл "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого", улсын хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, за дээр нь тухайн онуудын үндсэн чиглэлүүд, за дээр нь Монгол Улсын Засгийн газрын тогтоол, албан даалгавар, сайдын тушаал, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тэмдэглэл, НИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж гэсэн эдгээр 16 төсөл дээр нийтдээ бол одоо ийм хоёр боть, 440 орчим хууль эрх зүйн баримт бичиг гарсан байдаг. Эдгээр бүх баримт бичгүүд дээр бол энэ бүх төслүүд холбогдох шат шатны бүх зөвшөөрлүүдээ ном журмынх нь дагуу авч, энэ хууль тогтоомжийн дагуу хийж хэрэгжүүл ээ гэдэг шийдвэрүүд нь, даалгаврууд нь гарсны үндсэн дээр өнөөдөр хэрэгжээд явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Сайнзориг гишүүн нэмж тодруулья.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Золоо даргад сонсголоос зөвлөмж, дүгнэлт гарах байх тээ? Энэ дээр засаг захиргааны шинэчлэлийн асуудлыг бас одоо УИХ дээр том ажлын хэсэг гаргаж, нам намуудын төлөөллөөр ярилцъя гэдэг зүйлийг та энд дүгнэлтдээ тусгаач гэж хүсэж байна. Тэгээд энийг дагасан сонгуулийн тогтолцоо, засаглал, төсвийн бодлого нь яаж явах юм гэдэг зүйлүүдээ ярих нь зөв байх. Тэгэхээр энийг нэгдүгээрт хэлчихье гэж бодож байна. Хоёрдугаарт, үүний цаана би юу хэлэх гээд байна гэхээр Улаанбаатар хот бол яг бусад аймаг шигээ статустай байлгаад байх угаасаа боломжгүй болчихсон. Хоёр сая гаруй хүнтэй. Энийг угаасаа тусдаа авч үздэг. Энэ чинь "Capital City" гэдэг статустай байхгүй юу. Тэгэхээр энийг нэг та бас бодолцоод, зөвлөмжүүд дээр бичиж аваад тусгаач гэж хүсэж байгаа юм.

Энэ "Capital City" гэдэг онцгой статусаар нь бусад аймаг, орон нутгийн төсөв гэдгээр нь ингээд харьцаад нэг стандарт тавьчихаар энэ Улаанбаатарт жижигддэг. Улаанбаатарт тааруулаад юм хийчихээр аймгуудад нь чирэгдээд уначихдаг. Ингээд нэг ийм болдоггүй байгаа юм. Тэгэхээр энийг бас нэг гаргаад ирье. Тэгээд ер нь зүгээр яах вэ, Улаанбаатар өөрөө тосгон биш байхгүй юу. Энэ чинь мега хот. Энэ хотууд чинь ингээд одоо town, city, тэгээд mega city, metropolitan гээд явж байгаа шүү дээ. Энэ хоёр сая руугаа явчихаар бараг хамгийн сүүлийн ангилал руугаа явчихаад байгаа байхгүй юу. Тэгээд бид хэд ийм хэмжээний асуудал байвал бараг ийм хотуудтай харьцдаг Засгийн газрын гишүүн ч байдаг. Бид хэд мөн засаглалын асуудлаа ярья гээд байгаа бол үнэхээр ийм асуудлаа ярихаас өөр аргагүй. Тэгээд энэ Засгийн газартайгаа харьцаж, төрийн төлөөллийн чиг үүргийг орон нутаг дээрээ буулгаж харьцдаг ийм зүйл байх юм аа. Тэгээд энэ засаг захиргааны шинэчлэл, сонгуулийн тогтолцоо, төсвийн бодлого, за энийг дагаад татварын бодлого, хуваарилалтууд ч бас яригдах байх. Ийм зүйлүүдээ бас нэг зөвлөмж дээрээ тусгаж өгөөрэй гэдэг зүйлийг би эцэст нь хэлье. Тэгээд детальчлаад асуувал зөндөө юм байна. Тэгэхдээ одоо яришиг, маргааш бас тодорхой мэдээллүүд өгч байгаа учраас явъя. Ер нь суурь зарчмаараа орон нутагт өгсөн эрх мэдэлтэйгээ булаацалдах биш, хяналтаа зөв тавих. Эндээ өгч байгаа бол одоо буруу байна гэвэл энэ хүмүүсийг авчраад загнах биш, хуулиа өөрчилье өө л гэдэг байдлаар асуудалд хандаач л гэж байгаа юм. Тэрнээс биш одоо хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байгаа энэ орон нутаг чинь хууль өөрчлөх эрхгүйгээс хойш бид нар энд одоо бас хий хоосон шүүмжлээд байх нь зохистой биш ээ л гэдэг зүйлийг ташрамд хэлэх гээд байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Сайнзориг гишүүн үг хэллээ. Сонсголын эхэнд бас нээлт дээр хэлж байсан. УИХ-ын хууль тогтоох байгууллагын үүрэг бол эрх зүйн орчноо сайжруулах ажил нь байгаа. Өнгөрсөн хугацаанд нийгэм дээр яваад байгаа хэл ам ч тэр, эрх зүйн орчны судалгаанууд ч тэр, сая П.Сайнзориг гишүүн ч ярилаа. Энэ хуулиуд дээр бас анхаарах юмнууд байсан юм. Энийг бол бид нар анхаарах ёстой. Энэ бол Улсын Их Хурлын үүрэг бөгөөд хийх ажил нь. Чухам хаанаа алдаа гараад байгаа юм, гарахгүй байгаа юм уу? Орон нутгаа идэвхтэй хөгжүүлэхэд бид нар төсөв тавих хэрэгтэй. Тэр нь улсын төсөвтэй ямар харьцаатай байх ёстой юм? Ямар төслүүд нь хаанаа явж байх ёстой юм? Хэрэгжүүлж байгаа эрх мэдэлтэй хүмүүс нь өөрсдөө ашиг сонирхлын зөрчилтэй байж болохуйц эрх зүйн орчин нь өөрөө тийм нөхцөл байдал үүсгэчихсэн юм уу? Ажиллах орчныг нь гаргаж өгч байгаа юм уу? гэх мэтчилэн. Энэ бүгдийг бас бид хэлэлцэж, ажлын хэсгээс бол санал, дүгнэлт гарна. Тэгээд дараа нь холбогдох Байнгын хороодоор хэлэлцэх байх. Ингээд эрх зүйн асуудал яригдана. Ж.Баярмаа гишүүний микрофоныг нээж өгье.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Нэг талаасаа Туул голдоо баярлалаа гэж хэлмээр санагдлаа. "Save Tuul" гэдэг хөдөлгөөнөөс л ер нь энэ бүхэн үүссэн. Тэгээд Туул гол маань өөрийгөө хамгаалаад зогсохгүй ер нь энэ нийслэл юу болж байгаа юм бэ, энэ санхүү мөнгө нь яачихсан юм бэ, энэ мега төслүүд нь ямар түвшинд, ямар алдаа дутагдалтай явж байгаа юм бэ гэдгийг олон нийтэд сонсгох ийм буянтай үйл хийж өглөө гэж бодлоо.

Хоёрдугаарт, энэ бүх гишүүдийн асуулт, энэ хариулж байгаа хүмүүсийн үгнээс харахад нийслэл бол үнэндээ засаглалын хямралд бүрэн орчихсон юм байна. Тэгэхээр мэдээж энийг хэрэгжүүлж байгаа иргэдийн хурлын төлөөлөгчид бай, Засаг дарга нар бай, эд нарын 100 хувийн буруу биш л дээ. Мэдээж хуулийн хүрээнд л хийж байгаа. Гэхдээ яагаад ийм бантан болох ийм хуулийг бий болгосон юм бэ гэдэг асуултыг хэнээс асуух ёстой юм бэ? Эрх зүйн байдлыг нь...

Яагаад одоо Засаг даргаа хянаж байх ёстой иргэдийн төлөөлөгчид нь өөрсдөө ингээд ажил албанд томилогдоод, юу болоод байгаа юм бэ? Энэ холион бантан болох эх үүсвэрийг нь хэн тавьсан юм бэ? МАН-ынхан гэж асуумаар байна. За тэгээд саяын П.Сайнзориг гишүүний яриагаар бол дунд нь алдаа дутагдалтай болох юм байна гээд засахыг оролдсон гэж байна. Гэтэл энийг нь ерөөсөө хүлээж аваагүй гэж хэлж байна. Тэгэхээр энэ хэний буруу юм бэ гэдгийг ярих хэрэгтэй болж байна. Энэ хэний засаглал, хэн эрх барьж байсан юм? Ер нь бол нийслэлд Э.Бат-Үүл дарга 4 жил эрх барьснаас өөрөөр дандаа МАН эрх барьж байсан шүү дээ. Тэгээд ийм маапаантай, будилаантай, засаглалын хямралд хүргэхүйц эрх зүйн орчныг яагаад хүлээн зөвшөөрөөд байсан юм бэ? Асуумаар байна.

П.Сайнзориг өөрөө Засаг даргын орлогч байсан хүн хэлж байна л даа, “чи чимээгүй байгаач ээ, энд авчирч энэ хүмүүсийг ингээд байх хэрэггүй”. Загнаад байх хэрэггүй гэж. Үгүй ээ, энэ чинь нөгөө хяналт тавьж байх ёстой ИТХ нь ямар ч хяналт тавих боломжгүй болчихсон юм байна шүү дээ.

Зүй нь бол өнөөдрийн энэ бүх маапааныг бид энд яриад сууж байх ёстой биш, Иргэдийн Хурал нь өөрөө хяналтаа тавиад тэндээ яриад сууж байх ёстой байсан биз дээ. Тэгээд тийм биш болчихоор чинь хаана, хэн ярих вэ? “Улсын Их Хурлын гишүүдээ үзье” гээд байсан учраас нээрээ энэ ямар асуудлууд байдаг юм бол гээд сонирхоод л эхэлж байна. За энэ бол зүгээр жишээ. Ингээд дурдаад хэлэхэд зураг төсөвгүй, магадлалын дүгнэлтийн хугацаа нь дууссан, үгүй бол газрын асуудал нь бүрэн шийдэгдээгүй 1,4 их наяд төгрөгийн дүнтэй 75 төсөл, арга хэмжээг эхлүүлсэн байна гэж гарч байна шүү дээ. Ийм юм болоод байхад бид нүдээ аниад, чихээ бөглөөд сууж байх ёстой юм байх даа гээд гайхаж байна.

Захиалагчийн хяналттай 34 төсөл, арга хэмжээний зураг төсөв магадлалаар баталгаажаагүй, газрын зөвшөөрөл байхгүй, чөлөөлөлт хийгдээгүй мөртлөө ажил нь явж байдаг, мөнгө нь урьдчилгаа хэлбэрээр төлөгдөөд явж байдаг. Тэгээд энэ одоо зөв юм уу? гэж асуумаар байна.

Шинжээчийн дүгнэлтэд төлөвлөлт 0 гэж түрүүн хэлэх шиг болсон. Жишээлбэл дунд хугацааны бодлогод нийцээгүй 13 төсөл, арга хэмжээ, хөгжлийн жилийн төлөвлөгөөндөө нийцээгүй, үндсэн чиглэлдээ нийцээгүй, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны хөтөлбөртэй уялдаагүй гээд дандаа тоо заачихсан байна. Тэгэхээр энэ бүхэн зөв юм уу гэдэг асуулт тавимаар санагдлаа. Ингээд түүгээрээ явж байх ёстой байсан юм уу. Төсөв бараг 3 дахин нэмэгдсэн. Саяхна 2022 онд 4 их наяд баснаа 4.5 их наяд, дараа нь 10 хэдэн их наяд болчихсон. Зардал нь 3.2 дахин нэмэгдсэн байгаа юм. Тэгээд зогсохгүй жилд бараг 4-5 удаа төсвийн тодотгол хийж байсан байна. 2024 онд 4 удаа, 2025 онд 5 удаа. Ганцхан жилд 5 удаа тодотгол хийнэ гэдэг чинь улиралд хэдэн удаа тодотгол хийгээд байгаа юм бэ? Тэр 5 удаа тодотгол хийнэ гэдэг чинь 3 сард нэгээс олон удаа тодотгол хийж байна шүү дээ.

Төсвийн тухай хуулиар бол тодотгол хийх шалгуур, шаардлагууд байгаа. Тэрийг алийг нь ч мөрдөөгүй. Хуулийн дагуу бол төсөвт тодотгол хийх шаардлага үүсээгүй. Энэ тухай мэдээлэл хүссэн боловч ирүүлээгүй гэж байна лээ. Тэгээд зүгээр нэг жишээ дурдахад, Туулын хурдны замын төсвийг 2024 оны 12 дугаар сарын 25-нд 916 тэрбумаар төсвийг нь баталсан юм байна. Гэтэл ердөө гуравхан сарын дараа буюу 2025 оны 3 дугаар сарын 28-нд 1.9 их наяд болгочихсон юм байна. Энэ чинь 2 дахин нэмэгдчихэж байна шүү дээ. Тэгэхээр 2024 оны 12 дугаар сарын 25-нд энэ төсвийг баталж байхдаа юун дээр үндэслэж баталсан юм бэ? Яагаад 2 дахин

буюу 1.9 их наяд болоод нэмэгдчихэж байгаа юм бэ?

Дахиад 2025 оны 9 дүгээр сарын 23-нд 2.3 их наяд болчихсон байгаа юм. Гуравхан сарын дотор 2 дахин буюу бараг 1 их наядаар нэмэгдсэн байна. Хотын иргэд бол маш их татвар төлж байгаа. Зам ашигласны төлбөрийг 5 дахин, нийтийн тээврийн хэрэгслийн татварыг 3 дахин гээд татваруудыг 3-5 дахин нэмчихсэн. Мэдээж өндөр татвар төлж байгаагийнхаа хэрээр таарсан үйлчилгээгээ авмаар байна. Нийслэлээс тодорхой хэмжээнд түгжрэлд нөлөөлөх гол ажлуудыг хийж байх ёстой.

Би энд нэг сонирхолтой төсөл харлаа. “Дүүжин тээвэр” гэнэ. Энэ 71% гүйцэтгэлтэй, бараг ашиглалтад орох гэж байгаа юм байна. Тэгээд мөнгөн дүн нь 41.6 сая еврогийн хөнгөлөлттэй зээл юм байна. Хөнгөлөлттэй хэдий ч хүүтэй л байж таарна. Арцатаас-Өнөр хороолол чиглэлтэй юм байна. Энэ ямар үр дүнтэй, ямар ач холбогдолтой, үүгээр юу шийдэх гэж байгаа юм бол? Арцат гэдэг чинь бодвол Нүхтийн тэнд үү? Арцатын ам юм уу? Тэгээд Арцатын амнаас Өнөр хороолол гэж байгаа юм. Хархорин зах руу явах гэж байгаа гэж байгаа юм. Нүхтээс Хархорин явах ямар судалгаа, шаардлага, хэрэгцээ байсан юм бол? 41 сая евро гэдэг чинь маш их мөнгө шүү дээ. Тэгэхээр судалгаа нь юу байгаа вэ? Юу үндэслэж ийм төсөв гаргаад байгаа юм бэ? Энийг нэг тайлбарлаад өгөөч гэж асуумаар байна.

Түрүүн бас яриан дээр гарлаа. Мега төслүүдэд ерөөсөө эрэмбэлэлт байхгүй юм байна. Сангийн яамны буюу улсын төсвөөр болон УИХ-аас шийдэгдэж байгаа энэ мега төслүүд дээр болсон, болоогүй эрэмбэ байгаа юм. Өөрөөр хэлбэл шалгуур, шаардлага тавигддаг. Үүнийгээ бас 100 хувь мөрддөггүй л дээ. Бид нар анх гишүүн болоод л үүн дээр бөөн хэрүүл болж байсан. Гэтэл энэ 24 мега төслийн 16 нь хэрэгжээд эхэлчихсэн явж байна. Тэгээд эрэмбэлэлт байхгүй гэх юм. Тэгээд яг юуг үндэслэж эрэмбэлсэн юм бэ? Саяын дүүжин тээвэр шиг яаж эрэмбэлсэн учраас энэ төслүүд хэрэгжээд, төсөв нь батлагдаад яваад байгаа юм бэ? гэдэг бас асуулт байна.

Одоо Авлигатай тэмцэх газраас асуух асуулт байна. 2024 онд 40 зөрчил илэрсэн гэсэн үү? Эдгээр нь зөрчил нь иргэдийн гомдлоор хийсэн шалгалтын үр дүн юм уу, эсвэл хууль хяналтын байгууллагын хийсэн дүгнэлт юм уу? Тэрийг сайн анзаарч ойлгосонгүй. Өөрөөр хэлбэл 50-аас дээш хувийн зөрчилтэй байгаа юм л даа. Энэ юу вэ? Энийг нэг дэлгэрүүлж хэлж өгөөч. Одоо шалгагдаж байгаа хэргүүд юм уу, эсвэл зүгээр нийслэлийн албан тушаалтнуудад ХАСХОМ дээр нь хийсэн дүгнэлт юм уу? Энийг ерөөсөө сайн ойлгохгүй байгаа учраас асууж байна.

"Сэлбэ 20 минутын хот корпорац"-ийн чиг үүрэг юу вэ? "Сэлбэ 20 минутын хот" үүний чиг үүрэг нь юу вэ? Аль аль нэг орон сууц барих гээд хариуцаад байгаа юм уу? Миний сонссоноор Сэлбэ 20 минутын хотод 150 орчим ажилтан байна гэх юм. Нөгөө НОСК буюу Нийслэлийн орон сууцны корпорац нь ямар ажилтантай, ямар байгууллага байгаад, хажуугаар нь бүхэл бүтэн 150 хүнтэй ийм байгууллагыг байгуулсан юм бэ? Ямар ач холбогдолтой юм? Чиг үүрэг нь давхардаж байгаа юм биш үү?

За дараа нь төр бол хувийн хэвшил хийж болохгүй зүйлүүдийг л хийдэг гээд нэлээн их ярилаа. Түрүүнээс хойш хүнсний зах ажиллуулдаг гээд ярьж байна. Тэгэхээр энэ хүнсний зах байгаа нь үнэн үү? Бараг үнэн л дээ. Хаана билээ, нэг орон нутагт бас зах байж байгаад шатаж байсан. Тэгээд төсвөөс мөнгө өгөөд байх шиг байсан. Тэгэхээр энэ хүнсний захыг хувийн хэвшил хийж чадахгүй гэж үзэж байна

уу? Тийм учраас дүүргүүд хүнсний захтай байгаа юм уу? Тийм бол ямар агуулгаар, ямар зарчмаар ажилладаг хүнсний зах юм бэ гэж асуумаар байна.

Эрчим хүчний яам байгаа тэ? Нийслэлийн ч буруу биш байх л даа. Тэгэхээр нэгдсэн бодлого нь хаанаа зангидагдаж хийгдэх ёстой юм бэ? Эрчим хүчний яам цахилгаан станцаа барих юм уу, нийслэл цахилгаан станц барих юм уу. Цахилгаан станц, дулааны станцтай холбоотой маш олон төслүүд байдаг юм байна. Бодлого нь хаана явдаг юм бол? Ямар эрх зүйн үндэслэлээр Нийслэл цахилгаан станц барих нөхцөл үүсдэг юм бол? гэсэн асуултууд байна

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За асуултад хариулъя. Хаанаас эхлэх вэ? 4 номер.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр: Гишүүний асуултад хариулъя. Анх 2024 онд төсөвт суухдаа Туулын хурдны зам маань 4 эгнээ байсан. Нийт гүүрний урт маань болбол 3 км, 3.2 км гүүрний урттай, 32 км авто замын трасс байсан. Энүүгээрээ 2016 онд магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан төсөвт өртгийг бол төсвийн тухай хуулиар 3 жилээс хэтэрсэн тохиолдолд дахин төсвийг шинэчлэн гаргуулна гэсний үндсэн дээр 2024 онд төсвийг дахин гаргахад 916 тэрбум төгрөг болсон байгаа. Үүнээс төсөвт суусны дараагаар 2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Засгийн газрын тэмдэглэл дээр Туулын хурдны замыг 2 урсгалтай, 6 эгнээ бүхий авто замын зохион байгуулалтаар төлөвлөж, бэлтгэл ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах, Туулын хурдны замтай хойноос урагш чиглэлд холбогдох авто замуудын чиглэлийг тогтоож, төслийн бүтээн байгуулалттай уялдуулан барьж байгуулах асуудлыг ЗТЯ-тай хамтран судалж, танилцуулгыг Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт даалгав гэсэн. Энэ Засгийн газрын тэмдэглэлийг үндэслээд ТЭЗҮ дээр бол өөрчлөлт оруулж, 6 эгнээ болсон байгаа. Үүнтэй уялдаад 916 тэрбум төгрөгийн төсөвт өртөг маань 1.9 их наяд болсон. Энэ шалтгаан нь бол 6 эгнээ болсон, гүүрний урт уртассан байгаад явж байгаа. За хариулт дууслаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За нэмж Эрчим хүчний яамнаас хариулт өгөх үү?

Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал: За Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Дүүжин замын тээврийн асуудал бол Монгол Улсын Засгийн газар болон Франц Улсын Засгийн газар хоорондын олон улсын гэрээ, соёрхон батлах гэрээний хуультай. 0.0076 хувийн хүүтэй. Өөрөөр хэлбэл хүүгүй гэж хэлж болохоор, 40 жилийн хугацаатай, 12 дахь жилээсээ хүү болон зээлийн төлбөрөө төлж эхлэх нөхцөлтэй. Ийм 2 шугамыг барьж байгуулах үндсэн зорилготой хэлцэл 2023 онд анх эхэлж явсан байдаг. Энэ төсөл бол 1 дүгээр шугам буюу таны хэлээд байгаа Нүхтээс биш, Яармагаас байгаа. Яармагийн хүн амын өсөн нэмэгдэж байгаа ачаалал, одоо Яармагийн гүүр дээр 1-2 цаг гацаж байгаа. Энэ гацалтыг шууд Туул голыг хойш нь давуулж, Барс 2 буюу Сандэй 2 гэдэг зах, Энхтайваны өргөн чөлөө дээр буулгах ийм маршрут байгаа. Энэ маршрутын ажил бол 75 хувийн гүйцэтгэлтэй, барилга угсралтын ажил бол 100 хувь дууссан. Бид амжвал 9 сард туршилтыг эхэлнэ. Иргэддээ 11 сард дүүжин тээврийнхээ шугамаар үйлчилж эхлэхээр төлөвлөж байна. 98 кабинаар нэг иргэн тэндээс суухад 4.3 км замыг 11 минутад явж, Энхтайваны өргөн чөлөө дээр буухаар ийм тооцоололтойгоор, цагт 2200 иргэн зорчино гэсэн ийм судалгаатайгаар энэ төслийн ажил бол үндсэндээ амжилттай хэрэгжиж байгаа. За дээр нь энэ төслийн үйл

ажиллагааг хариуцахаар Франц Улсын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу 3 жилийн хугацааны сургалт, техникийн засвар үйлчилгээ, сэлбэгийн гэрээг хийгээд, ашиглалтын захиргааг хариуцсан компанийг байгуулсан. Одоо төслийн хүмүүс маань мэргэшээд, дадлагажаад ажилдаа орсон явж байгаа. Энэ нь бол 2 улсын Засгийн газар хоорондын гэрээтэй. Дээр нь яг энэ төслийн хувьд Засгийн газрын болон УИХ-ын, дээр нь Иргэдийн Хурлын 45 тогтоол, эрх зүйн шийдвэртэйгээр хэрэгжиж байгаа төсөл байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За ЭХЯ-наас гишүүний асуултад хариулъя. 12 дугаар.

Эрчим хүчний яамны салбарын хяналтын газрын дарга И.Лувсанцэрэн: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. ЭХЯ-ны Салбарын хяналтын газрын дарга И.Лувсанцэрэн. Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. ЭХЯ салбарын хэмжээнд, улсын хэмжээнд бол бодлогоо тодорхойлоод явж байгаа. Үндсэндээ Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд бодлогоо тодорхойлоод, улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээ, хэрэглэгчдийг цахилгаан, дулааны эрчим хүчээр найдвартай хангах үүргийг бол хүлээгээд явж байгаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэнд ДЦС-5 буюу одоо баригдах бэлтгэл ажлаа хангагдсан станц бол жагсаалтад орсон. Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгачихсан үйл ажиллагаа байгаа. Энэ дээр тухайн санхүүжилтийн асуудлыг нийслэлээс бүрэн хариуцаж, төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор нийслэлээс төсвийн санхүүжилтийг шийдвэрлэж ажиллаж байгаа гэдгийг хэлье. Хоёрт нь, ЭХЯ-ны зүгээс 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцээд тухайн төслийг Улаанбаатар хотод буюу ТЭЦ-2-ын үнсэн сангийн талбай дээр барих нь зүйтэй юм байна гэж үзээд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Эрчим хүчний бодлого нь яам, нийслэл хоёрын хооронд хэрхэн уялдаж явдаг, ямар нэгэн асуудал байна уу гэж асуусан. Тэгвэл гүйцээж хариулъя даа. Бодлогын уялдаа холбооны тал дээр ямар байр суурьтай байгаа вэ?

Эрчим хүчний яамны салбарын хяналтын газрын дарга И.Лувсанцэрэн: ЭХЯ бол улсын хэмжээнд эрчим хүчний салбарын бодлогыг тодорхойлоод явж байгаа. Харин тухайн бүс нутаг, орон нутаг, нийслэл нь санхүүжилтээ гаргаж, барих эрх зүйн үндэс болон санхүүжилт нь бий болсон учраас яамны зүгээс дэмжлэгийг нь үзүүлээд явж байгаа. Хамтраад ажиллаж байгаа төсөл дээр ийм байдлаар ажиллаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За, Ж.Баярмаа гишүүний микрофон.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: За, хоёр орны хэлэлцээрийн хүрээнд хийгдэж байгаа гэж байна. Тэгэхдээ энэ Яармаг байна уу, Нүхт байна уу, тэндээс Хархорин явах ийм маршрут гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энд тийм их эрэлт хэрэгцээ байгаа гэсэн үг үү? Энэ одоо түгжрэлийг бууруулж байгаа юм уу? Эсвэл яг хотын төв рүү байж болоогүй юм уу? Одоо нэг ёсондоо шууд асуухад, яагаад Хархорин руу, 1 дүгээр хорооллын тийшээ явж байгаа юм бэ л гэж асуугаад байгаа байхгүй юу.

Хоёрдугаарт, тэр Сэлбэ 20 минутын хот корпорац байгуулах тийм онцгой ач

холбогдол байсан юм уу? Нөгөө НОСК чинь байгаа юм уу гэж асуусан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сэлбэ 20 минутын хот. 9 номер. 150 хүнтэй том бүтэц байгуулсан байна. НОСК-той параллель юм биш үү гэж асуулаа.

Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Б.Мөнхбат: Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Дүүжин тээвэртэй холбоотой асуудал дээр бол сая хэлсэн. Үндсэндээ бол Яармаг буюу Наадамчдын гудамж, Энхтайваны өргөн чөлөө хоёрыг холбож байгаа. Энэ маань зөвхөн нэг дүүжин тээвэрт суугаад зорчихоос илүүтэйгээр бид ямар төлөвлөлтийг хийж өгч байгаа вэ гэхээр хоёр эцсийн буудал буюу хоёр орц дээр нь автомашины зогсоол, нийтдээ мянган машины зогсоол барьж байгаа. Үндсэндээ Улаанбаатар хотын төв маань Яармагт нэг хэсэг нь байна. Хоёрдугаарт, Энхтайваны өргөн чөлөө маань харьцангуй түгжрэл багатай байгаа учраас Энхтайваны өргөн чөлөөнөөс Наадамчдын гудамж буюу Нисэх-Яармагийн чиглэл дэх төрийн үйлчилгээ авах болон тэнд зорчих иргэд автомашинаа тавиад үндсэндээ 4.3 км зорчоод, тэндээ бусад нийтийн тээврээр үйлчлүүлээд, буцаад гэртээ ирэх боломжийг нээж өгөх ийм төслийн зохицуулалттайгаар эхний ээлж...

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сэлбийн асуудлаар 4 номер дээрээс мэдээлэл өгнө.

"Сэлбэ хорин минутын хот корпорац" ХХК гүйцэтгэх захирал У.Баатар: Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Сэлбэ 20 минут Хот корпорацын гүйцэтгэх захирал У.Баатар. Сэлбэ төсөл маань хамрах хүрээний хувьд анх Нийслэлийн орон сууц, санхүүжилтийн корпорац дээр явж байсан. Тэгээд Засгийн газраас Улаанбаатарт хэрэгжиж байгаа мега төслүүдийг олон улсын ФИДИК гэрээний зарчим дээр суурилж явуулна гэсэн тогтоол, шийдвэр гарсан. Уг хүрээнд бид энэ шинээр орж ирж байгаа олон улсын ФИДИК гэрээний зарчмын хүрээнд ажиллах мэргэжлийн багийг бүрдүүлэх шаардлагатай болсон. Батлагдсан орон тоо маань бол 159. Гэхдээ өнөөдрийн байдлаар 90 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа. Төслийн оргил ачааллын үе бол 8-10 сарын хооронд болно. Ингэхээр барилгын гүйцэтгэлийн талбай дээр 10 орчим мянган түр ажлын байр бий болж, түүнийг дагасан ажлын цар хүрээ нэмэгдэнэ. Тэр үед бид орон тоогоо 150 хүргэнэ. Төсөл дуусахад бид 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй үлдэхээр ийм уян хатан байдлаар төслөө хоёр жилийн хугацаанд орон тоогоо баталсан байгаа. Яагаад 60 хүн үлдэж байна вэ гэвэл барилга байгууламжийг байнгын ашиглалтад өгсний дараах нэг жилийн зүгшрүүлэлт, мөн барилгын чанарын баталгааны 3 жил гээд бид үндсэндээ 4 жил ашиглалтын захиргаа маягаар ажиллана. Шууд хэлэхэд томоохон хэмжээний СӨХ болж ажиллах тийм төлөвлөлттэй байгаа. Тэгэхээр энэ инженер, техникийн албыг үргэлжлүүлээд Сэлбэ төсөл дууссаны дараа цөөн хүнтэй, мэргэжлийн СӨХ болон ашиглалтын захиргаа бий болж үлдэхээр тэгж төлөвлөж явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: За, тэр дээр дараа нь мэдээлэл авъя. О.Батнайрамдал гишүүний микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн О.Батнайрамдал: За, та бүхэнд оройн мэнд хүргэе. Хамгийн сүүлийн гишүүн би болж таарлаа. Гэхдээ бас жаахан харьцуулсан дүгнэлттэй хэдэн зүйл хэлье гэж бодлоо. Ер нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаас хойш хяналтын механизм илүү боловсронгуй болж ажиллаж эхэлсэн байгаа юм.

Тэгэхээр нэгэнтээ татвар төлөгчдийн мөнгө эсвэл татвар төлөгчдийн өмчийн захиран зарцуулалтыг олон нийтэд тайлагнах процесс болгон нь зөв чиг хандлага, зөв гэсэн үг гэхдээ нөгөө талаасаа энэ бол өөрөө маш том хариуцлага гэсэн үг. Өнөөдөр би шинжээчдийн дүгнэлтийг анхааралтай уншлаа. Би өөрөө Оюу толгойн сонсгол 20-30 гаруй байгууллагаас 90 мянган хуудас нотлох баримтын дүгнэлтийн ард гарчихсан хүний хувьд бас харьцуулалт гэж харж байгаа юм. Яагаад гэвэл энэ өөрөө маш том үр дагавартай байдаг. Татвар төлөгчдийн мөнгө хэрхэн захиран зарцуулагдсан буцаад энэ олон нийтийн мэдэх эрхэд одоо нэг талаасаа нөлөөлдөг тус болдог. Гэхдээ нөгөө талаасаа бас улс төржилт явдаг учраас энэ дээр ер нь бол маш нухацтай хандах ёстой байгаа.

Байнгын хорооны тогтоол гараад нэг ёсондоо ийм ерөнхий сонсгол хийе гээд 5 сарын 19-нд гэдэг чинь нэг арай нэг сар болоогүй юм байна. Тэгэхээр 22 хоногийн дотор нэг ёсондоо 8 тэрбум ам.долларын үнэлгээтэй төслүүд дээр шинжээчид дүгнэлт хийгээд ороод ирж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр яах вэ гурван 7 хоногийн дотор 8 тэрбум долларын үнэлгээтэй дэлхийн хэмжээний маш том олон ТЭЗҮ дээр эдийн засаг, санхүүгийн үнэлгээ хийгээд ороод ирж байхад надад цаг хугацааны хувьд бол ерөөсөө хангалттай харагдаж өгөхгүй байна л даа. Шинжээчдийн ялангуяа санхүү, эдийн засгийн дүгнэлтийг харлаа жоохон голж магадгүй. Уучлаарай гэхдээ надад ерөөсөө хангалттай санагдсангүй 8 тэрбум ам.долларын үнэлгээтэй ийм том Нийслэлийн 1,5 сая иргэний амьдралд шууд нөлөөлөх том төсөл гэж ярьж байхад шинжээчийн дүгнэлт ерөөсөө 4 гол санаа байна л даа.

Тэгээд энэ 4 гол санааг бүгдээрээ харъя л даа. Санхүү, эдийн засгийн дүгнэлт нэгдүгээрт санхүүжилтийн эх үүсвэр бодитой шийдвэрлээгүй нөхцөл байдал хэрэгжих хугацаа хойшлох ийм сөрөг нөлөөтэй гээд энэ дүгнэлт биш. Үүнийгээ одоо нэг ёсондоо дүгнэлт гэж байгаа бол яг бодит судалгаа бодит нөгөө тоо, жишигтэйгээ өгөх ёстой. Хоёрдугаар дүгнэлт 2026 оны 16 төслийн төсөвт өртгийн 22,3% зарцуулагдахаар төлөвлөсөн ч одоогийн байдлаар 0,8%-ийг зарцуулжээ гэдэг энэ өөрөө бас дүгнэлт биш шүү дээ. Энэ бол нэг факт явж байгаа байхгүй юу. Гуравдугаарт энэ бол дүгнэлт мөн. Энэ юу вэ гэхээрээ ижил чиглэлийн төслүүдийн нийлмэл нөлөөлөл нэг ёсондоо энэ метро LRT, BRT, дүүжин тээвэр, хурдны зам.

Тэгэхээр энийг цогцоор нь авч үзээд нийлмэл гарах эдийн засаг, нийгмийн нөлөөллийг нь авч үзсэн үү гэсэн асуулт байна. Энэ бол дүгнэлт мөн. Дөрөвдүгээрт эдийн засгийн шинжилгээнд одоо зөвхөн эерэг нөлөө анхаарсан байгаль орчин гэх мэт сөрөг нөлөөллийн зардал тооцуулаагүй байна гээд. Тэгэхээр энэ яг ТЭЗҮ-ээ яриад байна уу эсвэл externality буюу нөлөөлж гарах нийгэм, байгаль орчны тусдаа нөлөөллийг яриад байна уу? Яагаад гэвэл энэ хэдэн тэрбум ам.долларын төслүүд дээр угаасаа ТЭЗҮ батлагдаагүй эсвэл хийгдээгүй бол төсөл угаасаа мөнгө нь босдоггүй байхгүй юу. Сая доллар босгох гэж байгаа тэр төсөл дээр өрөнгө оруулагч бонд гаргагчдад итгэл үзүүлэх хэмжээний хүлээн зөвшөөрөгдсөн байж угаасаа мөнгө нь босдог. Тэгэхээр мөнгө босож байна гэдэг бол эсвэл бонд итгэл төрүүлж байна гэдэг бол ялангуяа эдийн засаг, санхүүгийн талаасаа хийгдчихсэн гэсэн үг байхгүй юу. Би эндээс юу гэж хэлэх гээд байна вэ гэхээрээ бид нар нэгэнтээ 1,5 сая иргэний өнөөдрөөс өгсүүлээд дараагийн 3,4,5,10 жилийн амьдралд шууд нөлөөлөх 8 тэрбум ам.долларын төслийн үр нөлөө дээр гарсан асуудлуудыг ярьж байгаа учраас энэ дээр маш нухацтай судалгаатай хандах ёстой.

10 шинжээч томилогдсон юм байна. Энэ 10 шинжээч гурван 7 хоног ажиллана

гэдэг чинь нөгөө шинжээчдээ хамгийн гол нь хангалттай цаг хугацаа өгөөгүй санагдаад байна л даа Оюу толгойн сонсгол дээр бид нар чинь 5 сарын хугацаанд өдөр шөнөгүй сууж байж яг энэ бүхний ард гарч байгаа юм л даа. Шинжээчдийн буруу гэхээсээ илүүтэйгээр шинжээчдэд хангалттай цаг өгсөн үү тэ? Зөвхөн одоо метроны нэг ТЭЗҮ дээр хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гарахад тэр чинь хэдэн сар шаардана шүү дээ. Тийм учраас энд бид нар маш нухацтай хандах ёстой тийм учраас өнөөдөр би бараг 4 цаг шинжээчийн дүгнэлтийг, өгсөн танилцуулгыг 4, 5 удаа уншлаа л даа.

Тэгэхээр товчхондоо хэлэхэд 8 тэрбум ам.долларын төслийн зарцуулалт нь 0,8% байхад нь бид нар сонсгол хийж дүгнэлт гаргаж байгаа юм байна. Хяналтын сонсгол гэдэг бол аливаа асуудал шийдэгдээд яваад үр дагавар нь гараад хэр биелсэн бэ гэдэг дээр үндэслэж сонсгол уул нь явагдах ёстой юм. Тэгэхээр зарцуулалт нь 0,8 хувийн зарцуулалт дээр бид нар сонсгол хийхээр яг үнэнийг хэлэхэд буцаад нэг сонсголынхоо агуулгыг зөв ашиглаж байна уу гэдэг дээр л эргэлзээд байгаа юм л даа. Гэхдээ олон нийтийг мэдэх эрхээр хангах гэдэг өөрөө зөв.

Ямар ч цаг хугацаанд татвар төлөгчдийн мөнгө эсвэл татвар төлөгчдийн өмч орж байгаа тохиолдолд захиран зарцуулалтыг олон нийтэд нээлттэй мэдээлэх нь бид бүгдийн үүрэг юм. Сая 1 асуудлыг мухарлах хэрэгтэй байна. Сая нийслэлийн төсвийн алдагдал 2,4 их наяд гээд гэтэл Нийслэл болохоороо тэр алдагдал биш ээ гээд энэ бол хоёулаа зөв шүү. Сангийн яам 2,4 их наяд гэдгийг яг өнөөдрийн байгаа бодлогын хүрээнд, нягтлан бодох бүртгэлийн хүрээнд бол 2,4 их наяд алдагдал гэж бичих нь зөв байгаад байдаг. Гэхдээ Нийслэлээс 2,4 их наяд төгрөгийн 900 тэрбум нь дансанд орлогоос одоо нэг ёсондоо зарцуулж амжаагүй Төрийн санд байгаа бэлэн мөнгө нь байхгүй юу. 1,5 их наяд нь зарцуулж амжаагүй бондын үлдэгдэл байхгүй юу. Тэгэхээр 1 ёсондоо бараг бэлэн мөнгөөр шахуу байгаа он дамжуулаад цаашаагаа бүртгэгдсэн 2,4 их наяд төгрөг. Тэгэхээр нийслэл бол энийг 2,4 их наяд алдагдал биш гэж хэлэх эрхтэй байхгүй юу. Яагаад гэвэл Нийслэл чинь аж ахуйн байгууллага шүү дээ. Монгол Улсын инфляц фискал полиси буюу төсөв санхүүгийн бодлогоор харах үүрэггүй, Нийслэлийнхээ дансны хүрээнд л харах нь эд нарын үүрэг нь зөв байхгүй юу. Тэгэхээр энэ ер нь явж явж санхүүгийн бодлого, санхүү мөнгөний бодлого буцаад иймэрхүү нэг ёсондоо илүү орлого гараад тэрийг дараа жилдээ шилжүүлэн тооцохыг яаж Сангийн яамны хувьд макро эдийн засгийн төсвийн мөнгөний бодлогын хувьд бүртгэх вэ, хэрэгжүүлэх вэ гэдэг дээрээ урьд өмнө нь тохиолдоогүй жишээн дээр л бид нар 2 тал болчихоод байна л даа. Тэгэхээр энэ дээр хуульд шаардлагатай өөрчлөлт орох ёстой. Энэ бүртгэл цаашдаа зөв явах ёстой нь эндээс бол харагдлаа. Гэхдээ шууд 2,4 их наядын алдагдал гээд ойлгочхож бас болохгүй зүйл юм. Энийг Сангийн яам маш тодорхой хариулж өгөх хэрэгтэй. Мөн одоо түрүүн П.Сайнзориг гишүүн ч ярьсан. НИТХ-ын нөгөө төлөөлөгчид рүүгээ бас хэт их дайрсан юм явлаа. Яг өнөөдөр бид энэ ярилцаж байгаа хяналтын чиг үүрэг бол НИТХ дээр яригдах ёстой байхгүй юу. Яг адилхан УИХ-ын гишүүд шиг сонгуулиар Улаанбаатар хотын иргэдээс мандат авч гарсан гишүүд байгаа. Тэгэхээр Нийслэлийн төсвийн хяналтын механизм ИТХ дээрээ хамгийн түрүүнд явах ёстой юм.

Ер нь ИТХ-ын гишүүд гэдэг бол Улаанбаатар хотын 1,5 сая иргэдээс мандат авч гарсан сонголт. Тэгэхээр тэр иргэдийн сонголтод бид нар хүндэтгэлтэй хандах ёстой. 2024 оны сонгуулиар орон нутгийн сонгуулиар МАН-ын Х.Нямбаатар даргын ахалсан баг үнэмлэхүй ялсан. Энэ бол ард түмний сонголт байсан юм. Ард түмний сонголтоор захиран зарцуулах эрх нь ч гэсэн очдог. Харин НИТХ-ын гишүүд,

төлөөлөгчид нь өөрсдөө нийслэлийнхээ ажил руу орох уу, үгүй юу гэдэг энэ хуулийн цоорхой байна. Энэ хуулийн цоорхойг засах үүрэг нь бол УИХ-ын гишүүд дээр бид нар дээр байна гэсэн үг. Тэгэхээр П.Сайнзориг гишүүн ч түрүүн ярьж байсан, энийг бид засаад явах хэрэгтэй. Тэр 2,4 их наядын алдагдал гэдэг бас л хууль эрх зүйн хүрээнд эсвэл фискал полиси буюу санхүү мөнгөний бодлогын хувьд бид нар энийгээ цаашаагаа засаад явах ёстой. Нийслэл бонд гаргадаг энэ боломж бол хөгжлийн хувьд хамгийн зөв алхам байсан шүү дээ.

Энийг бас сая буруу гээд ярьчих шиг боллоо. Үгүй шүү Нийслэл бонд гаргаад том асуудлуудаа шийдээд явах нь зүй ёсны юм. Тэгэхээр би шинжээчдийн дүгнэлтээс бас нэлээн дүгнэлт хийнэ. 2024-2025 оны бараа үйлчилгээний бусад зардлын хувьд нэг ёсондоо 100% зардлын 16,3% буюу 76 тэрбумыг нийслэл, дүүргийн өмчит ААН-ээр дамжуулж хийжээ. Үлдсэн 89,7% нь хувийн хэвшлээр хийсэн байна гэсэн үг. Энэ дээр зарцуулсан гээд шинжээч дүгнэлт хийчихлээ. Нэг удаагийн 2024-2025 оны зарцуулалтаар дүгнэж болохгүй ээ. Сүүлийн 30 жилийн хугацаанд орон нутгийн өмчит ААН хэдэн хувийг зарцуулж явж байгаад 16,3% дээр очсон юм. Энэ нь 50% байж байгаад буурсаар яваад 16,3% дээр очсон гэвэл энэ дүгнэлт юм. Эсвэл 3-хан хувь байж байгаад 16,3% дээр очсон гэвэл энэ дүгнэлт юм.

Тэгэхээр иймэрхүү дүгнэлт хариуцлагатай хийх ёстой шүү. Яагаад гэвэл бид 8 тэрбум долларын зарцуулалт ярьж байгаа шүү дээ. Маш хариуцлагатай том 1,5 сая иргэний амьдралд нөлөөлөх зүйл ярьж байгаа юм. Дараагийн нэг зүйл хөрөнгө оруулалтын нийт зардал улсын төсвийнхөө 53% дээр байна. Энэ бол яг үнэнийг хэлэхэд Улсын Их Хурал дээр улсын төсөв 2 удаа баталсан. Улсын төсөв дээр хөрөнгө оруулалтын зардал нь нийт төсвийнхөө 15%-д ч хүрдэггүй байхгүй юу 10%-тай дөнгөн данган шинэ хөрөнгө оруулалтад зарцуулж байгаа. Бусад нь бүгдээрээ урсгал зардал, Улс хөрөнгө оруулалт хийж чаддаггүй. Тэгсэн чинь нийслэл дээр 2022 оноос хойш нийт төсвийн 40-57% нь хөрөнгө оруулалт руу орсон байна.

Үүнийг би хувьдаа атаархмаар дүгнэлт гэж харж байна. Нийслэл дээр л хөрөнгө оруулалт явж байгаа юм байна шүү дээ. Нийслэл дээр л бүтээн байгуулалт явж байгаа юм байна гэдэг дүгнэлт эндээс харагдаж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ статистикаас ямар дүгнэлт хийгдэж болох вэ гэхээр сүүлийн 5 жилийн хугацаанд Нийслэл дээр урд өмнө нь битгий хэл улсын төсөв дээр яригдаж байгаагүй том хөрөнгө оруулалт буюу бүтээн байгуулалтууд явж байгаа юм байна гэж харагдаж байгаа явж байгаа юм байна. Алдаа оноо байлгүй яах вэ алдаа оноог нь бид нар нээлттэй ярилцаад улам сайжруулаад цаашаагаа явах ёстой. Яагаад гэвэл энэний ард дахиад 1,5 сая иргэний хүлээлт байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг ашиглаад Нийслэлийн залуучуудад хандаад нэг зүйл хэлчихье гэж бодож байгаа юм. Өнөөдөр яах вэ, та нар нэг тийм шүүгдэж байгаа ч юм шиг, хэтэрхий бас улс төржсөн өнгө аяс харагдаад байна. Гэхдээ Нийслэлийн 35 жилийн түүхэнд хамгийн том хөрөнгө оруулалтуудыг манлайлаад явж байгаа залуучууд л байна шүү дээ. Хуулийх засах асуудлуудаа л оруулаад ирэх хэрэгтэй. Яаж цаашаагаа бид илүү ил тод, сайжруулаад, захиран зарцуулалтуудыг нээлттэй улам сайжруулж болох вэ? Гэхдээ энэ сонсголоор битгий нуруугаа авхуулаарай за юу.

Яагаад гэвэл энэ төслүүд цаашаагаа явах ёстой. Төслүүдийг явуул гэж ард түмэн бид нарт, УИХ дээр ч гэсэн, Нийслэл дээр ч гэсэн мандат өгсөн байхгүй юу. Тэгэхээр нээлттэй хэлэлцээд энэ асуудлуудаа цаашаагаа шийдээд явах нь зүй ёсны хэрэг юм. эхлээд хариултаа авъя. Тэгэхээр Сангийн яамны М.Санжаадорж дарга та

тэр асуудлуудыг яг одоо мухарлаад хариулт өгнө үү. Тэгэхгүй бол 2 талдаа хоёулаа нэг нь буруу ч юм шиг хоёулаа зөв ч юм шиг яриад байна. Нийслэлээс тэр төслүүдийнхээ талаар нэмэлт хариулт аваад тэгээд нэмж тодруулъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Сангийн яам М.Санжаадорж асуултад хариулъя.

Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж: Тэгэхлээр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 7 дахь заалтаар бол төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг УИХ баталж мөрдүүлэх ийм эрхтэй байдаг. Нөгөө талдаа Үндсэн хуулиар орон нутгийн засаг захиргаа буюу ИТХ 59.2 дахь заалтаар хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй байгаад байдаг. Төсвийн тухай хуулийн 57.2-т юу гэж заасан байдаг вэ гэхлээр орон нутгийн төсвийг алдагдалгүй баталж хэрэгжүүлнэ гэсэн ийм заалттай. 57.3-т өмнөх оны үлдэгдлийг төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэсэн ийм зүйлтэй байгаад байдаг. Нийслэл одоо яг энэ хуулиудын хүрээнд болон тооцооллын хүрээнд 2,4 их наядын алдагдалтай байгаа. Нэгдүгээрт бондын алдагдал байгаа. Гадаад бонд гаргачихсан. Энэ бонд маань өөрөө орлого биш, өр төлбөр, эргээд буцаагаад төлөх учраас бид нар энийгээ орлого дээр бүртгэдэггүй.

Олон улсын яг энэ бүртгэлийн ангиллаараа өр төлбөр болчихоод байгаа юм. Нөгөө нэг зүйл нь түрүүн та бас дурдсан. Өмнөх оны үлдэгдлийг ярьж байна. 2025 онд орсон орлогыг орлогоор нөгөө талдаа зарлага 2026 онд санхүүжүүлэх гэж байгаа бол энэ бас алдагдал. Яагаад гэвэл 2025 онд нэгэнт орлого гээд бүртгэгдсэн зүйлийг бид 2026 онд дахиж орлого гэж бүртгэж болохгүй. Нэг орлогыг 2 удаа бүртгэж болохгүй. Тэгэхлээр энэ өөрөө бас алдагдал байгаа. Түүнчлэн бол энэ жил дахиж нэмж 200 тэрбум төгрөгийн дотоод бонд гаргахаар шийдвэрлэсэн байгаа. Ингээд нийлэхлээрээ 2,4 их наядын алдагдалтай байгаа. Гэхдээ гишүүний хэлж байгаа санал дээр би бас анализ хийж үзэж байгаа. Өмнө нь энэ хууль аль аль хуулийн заалт нь төсвийн хууль анх батлагдахдаа л байсан. Нэгдүгээрт алдагдалгүй батална, нөгөө талдаа бол өмнөх оны үлдэгдлээр алдагдлаа нэмж болно гэдэг нь хууль дээр угаасаа байсан.

Энэ хууль маань хэрэгжээд явахдаа өнөөдрийнх шиг ийм асуудал бол яагаад үүсгэж байгаагүй гэвэл нэгдүгээрт нийслэлийн асуудал ийм том байгаагүй. Одоо хүлээгдэж байгаа, шийдлээ хүлээгдсэн энэ том асуудлууд байж байгаа. Нөгөө талдаа орлогын боломжтой болчихсон. 2022 онд нийслэлд бид орон нутгийн ААНОАТ-ын 40%-ийг нэмж олгодог болсон. Энэ нь өөрөө нийслэл дэх бизнесээ нэгдүгээрт дэмжих, хоёрдугаарт бол нийслэлийнхээ асуудлыг шийдэх ёстой гэдэг ийм агуулгаар бол орж ирсэн. Тэгэхээр энэ дүн маань бол өөрөө томроод байгаа учраас бидэнд өнөөдөр асуудал болсон.

Хиууль эрх зүйн хувьд бид тодорхой шийдлийг оруулж ирэх шаардлагатай байгаа. Үүнтэй холбоотойгоор 2025 оны төсвийн тодотголтой хамт бид алдагдалгүй батална гэдэг дээр төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж алдагдалгүй батална гэдэг ийм зүйл заалт оруулж ирсэн. Төсвийн хүрээний мэдэгдэл маань Улсын Их Хурал дээр бол Үндсэн хуулиар олгосон эрхийнх нь дагуу төсвийн бодлогыг мөнгөний бодлоготой уялдуулж гаргаж байгаа. Төрийн нийт гарах зардал энэ шүү. Нөгөө талдаа мөнгөний бодлогын хүрээнд бол гарах нийт зээл маань бол энэ шүү гэдгийгээ зааж өгч байж инфляцаа онилж чиглэж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ нийлүүлж удирдана шүү гэдэг ийм зүйл болчихоод байгаа. Нөгөө талаасаа харвал мэдээж хэрэг Үндсэн хуулиараа болон бусад хуулиараа нийслэлийн дансанд байгаа орлогын мөнгийг татна гэж заагаагүй. Хүчээр бид нар татаж болохгүй. Энэ мөнгө нь байгаа тохиолдолд нийслэл өөрөө тэр шийдлээ, асуудлуудаа шийдээд явах шаардлагатай болдог. Ингээд алдагдал бий болчихоод байгаа гэсэн үг. Тэгэхлээр товчхондоо 2 хуулийн зөрчилтэй заалт байгаа. Энэ асуудлыг намар төсвийн тодотгол мөн ирэх жилийн төсвийн төслийг өргөн барихдаа бид шийдлээ Сангийн яамны хувьд төсөв санхүүгийн бодлогыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Өөрөөр хэлбэл, шийдвэрлүүлэх үүрэг хүлээсэн байгууллагын хувьд оруулж ирнэ гэсэн ийм тооцоололтой ажиллаж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: О.Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн О.Батнайрамдал: Тэгэхээр би 10 шинжээчдээс нэг нь надад төлөөлөн хариулчхаач. Би зүгээр товчхон асуучихъя гэж бодлоо л доо. Шинжээчийн ажил бол бас нэлээн амаргүй ажил байдаг. Богино хугацаанд маш их нотлох баримт дээр ажиллана. Тэгэхээр та нар энэ богино хугацааны гурван 7 хоногийн туршид хэдэн хуудас нотлох баримт бичиг дээр ажиллав. Ер нь та нар одоо хангалттай дүгнэлт хийх хугацаа байсан гэж үзэж байна уу? Хэдэн том ТЭЗҮ дээр бас ажилласан бэ? Тэгэхээр нэг ёсондоо дэлгэрэнгүй мэдээлэл өгөх хэрэгтэй болов уу гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Шинжээчдээс хэн хариулах вэ? Нийт хэдэн хоног ажиллав, хэчнээн хэмжээний бичиг баримтаар, ямар хүндрэл тулгарав гээд мэдээлэл өгнө үү. Энийг хурал даргалагчийн хувиар асуучихъя аа. Нэгдүгээр микрофон нээж өгнө үү.?

Шинжээч Д.Энхбаяр: Сайн байцгаана уу? шинжээчдийн бүрэлдэхүүн 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр 6 сарын 4-ний өдөр Төсвийн байнгын хорооны тогтоол гараад ажилласан. Тогтоол гараад ажиллахад ажлын хэсэг дээр нийслэлээс ирүүлсэн цаасан материал нийт 16 төслийн ТЭЗҮ болон бусад бичиг баримтууд гээд бараг 30-40 боть баримтууд, цахимаар бас 30 гигабайт файлууд ирсэн байгаа. Мөн явцын дунд УИХ-ын ажлын хэсгээс холбогдох газрууд руу шаардлагатай материалууд албан бичгүүдээр авсан.

Таны яг асуусны дагуу энэ богино хугацаанд бид нар шахуу ажилласан. Яг нарийн эцсийн үр дүн гаргахад бас хангалтгүй хугацаа гэж дүгнэхээр байна. Тэгэхдээ эхний ээлжийн бид нарт өгөгдсөн үндсэн ажлын даалгавар, үүргийн хүрээнд бид гарах ёстой агуулгынхаа хүрээнд дүгнэлтүүдээ гаргаж өгсөн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: УИХ-аас 11 гишүүний ажлын хэсэг гарсан. Ажлын хэсгийн гишүүн, сонсгол даргалагчийн хувиар нэмэлт мэдээлэл өгье. УИХ-ын чуулган 6 дугаар сарын 29-нд 75 хоногийн хугацаа болоод чуулган завсарлах ёстой. Тэгэхээр чуулганыхаа хуваариар бид 15, 16-нд сонсгол явуулах нь зүйтэй юм байна гээд Төсвийн байнгын хороон дээр хэлэлцээд санал хурааж тогтоол гаргасан. Тэрэндээ багтаж санал, дүгнэлтээ боловсруулах ийм шаардлага үүсэж байгаа юм. Хоёрдугаарт нь, Оюу толгойн сонсгол бол тусгай хяналтын түр хороо. Энэ дээр илүү их мөрдөн шалгах их деталь ажлууд бол ордог.

Ерөнхий хяналтын сонсголын хүрээнд бид өнөөдрийн яриад байгаа эрх зүйн орчныг сайжруулах асуудлууд, тэгээд хаана ямар алдаа гарсан байна гэдэг асуудлуудыг шийдэхэд боломжийн байж болох хугацаа гэж үзэж Байнгын хорооноос тогтоол гаргасан. Хоёрт нь, хүлээх цаг хугацаа бол байхгүй. Намар дахиад төсөв орж ирнэ. Тэгэхээр наана нь бид нар дүгнэлтүүд хийх ёстой. Ямар нэгэн эрх зүйн орчны засвар байх бол энэ хаврын чуулган намрын чуулганаар хэлэлцэх шаардлагатай болно. Маргааш хэлэлцэх асуудал дээр Туул, Сэлбэ гээд 2 том төслийг жишээ болгож авч хэлэлцэж байгаа. Тэгэхээр тэр төслүүд чинь одоо зун өнгөрнө, өвөл болно, барилгын хугацаа дуусна. Нөгөө төлбөр тооцооны асуудал Туул гол дээр төлчихсөн. Сонгон шалгаруулалт, худалдан авалт дээр хууль бус ажиллагаа гарсан гээд Засгийн газраас дүгнэлт гаргачихсан байгаа. Тэгээд нөгөө мөнгөө олж чадах юм уу, үгүй юм уу, ямар асуудал үүсэх юм гээд байна. Энэ асуудлуудыг бол хугацаа алдалгүй хэлэлцээд иргэдийн мэдэх эрхийг ч хангуулах, нөгөөтэйгүүр УИХ эрх зүйн орчныг яаж сайжруулах дүгнэлт хийж, ажлаа хийх шаардлагатай гэж үзээд шахуу богино хугацаанд ажилласан байгаа.

Гишүүнээ нэмэлт байхгүй байна шүү дээ. Нэмэлт асуулт байвал, би асууж өгнө. Түрүүнд гишүүдээс ирсэн асуултууд зарим нэг байна. Тэгэхээр энэ Сангийн яамны саяын хариултаар нэмээд ярихад одоо энэ нийт дүн нь бол их юм. 16 мега төсөл 28 их наяд төгрөг гэхдээ яг гүйцэтгээд гарсан нь бага байна гэж байна. Бага гаргана гэж бол төлөвлөдөггүй шүү дээ. Бид нар хийнэ гэж төлөвлөж байгаа. Тэгээд энэ санхүүжилтийг нь харахаар 2026 онд 6 их наяд, 2029 онд 8 их наяд гарч байж энэ төслүүд цаг хугацаандаа эрчимтэй явахаар байжээ. Энэ 28 их наядын 53% нь зээл. Үүний эргэн төлөлт төсвийн ачаалал дээр хэрхэн ачаалал үүсгэх нь төслийн бичиг баримт дундаас бол олоогүй. Яг тэр тооцоог гэж бол шинжээч нар дүгнэсэн.

Эргэн төлөлт Монгол Улсын төсөвт ямар хэмжээний ачаалал үүсгэх вэ? Монгол Улсын гадаад ер нь хэд байгаа билээ. Тэгэхээр нийслэлийн энэ төслүүдийн 53% гэдэг чинь бол 15,5 их наяд төгрөг болж байна л даа. 15,5 их наяд төгрөгийн өр зээл нэмэгдэнэ гэсэн үг. Тэгэхээр энэ харьцуулаад харахад ямар хэмжээ вэ? яаж гадаад зээлийн эргэн төлөлт дээр төсөв дээр дарамт учруулахаар хэмжээ юу? үгүй юу гэдэг талаар Сангийн яамнаас мэдээлэл өгөөч.

Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж: Сонсгол даргалагчийн асуултад хариулъя. Нийслэлээс үнэт цаас Засгийн газрын 2024 оны 201, 264 дээрээс нь 17, 265 гэсэн эдгээр тогтоолуудаар 3 төрлийн бонд гаргасан байгаа. Энэ жил нэмээд нэг төрлийг гаргасан. Үүнээс яг гадаад зээлтэй холбоотой хэсэг нь Сэлбэ дэд төвтэй холбоотой хэсэг байгаа. Бусад нь бол дотоод бондууд байгаа. Сэлбийн хувьд бол Засгийн газрын шууд баталгаатай бусад хэсгүүд дээр Засгийн газраас тогтоол гарсан. Бусдаар нийслэл өөрөө баталгаагаа гаргаж байгаа ийм байдалтай байгаа.

Ер нь 2026 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр орлого, өрийн харьцаа нь нийслэлийн хувьд 54,4% байхаар хүлээгдэж байгаа. Гүйцэтгэлээр байгаа. Энэ нь Улсын Их Хурлаар баталсан Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-2028 оны Стратегийн баримт бичгийн 70%-аас бага байна гэдэг дээр нийцэж байгаа гэж бид нар нийт өрийн хувьд бол харж байгаа. Гэхдээ нөгөө талдаа энэ дээр өрийн удирдлагын стратеги дээр бол нийт орлогын тэдэн хувиас хэтрэхгүй гэдгийг заасан боловч богино хугацаанд ямар санхүүгийн дарамт учрах вэ гэдэг дээр дүгнэлт гаргах шаардлагатай гэж үзэж байна. Жишээ нь Сэлбэ дэд төвд түшиглэсэн орон сууцжуулалтын төсөл 2,5 жилийн хугацаатай 7,75%-ийн хүүтэй гарчихсан байгаад байгаа. Тэгэхлээр энэ дээр бас дахин санхүүжүүлэх асуудал яригдах болов уу гэж

бодож байна. Яагаад гэвэл шууд нэг дор 500 сая ам.долларыг шууд эргүүлээд төлөх боломж хараахан гарах боломжгүй болов уу гэсэн байдалтай харагдаж байна. Засгийн газрын нийт өр 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар 35,8 их наяд төгрөг байгаа. Энэ нь ДНБ-ий 37.5%-тай тэнцүү байгаа тэгэхээр Засгийн газрын хувьд бол 37.5%, Нийслэл дээр 54.4%-тай тэнцэхээр ийм өрийн хэмжээтэй байна. Нийслэлийн энэ гадаад бонд Засгийн газрын нийт өрийн хэмжээний бол 4%-ийг эзэлж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Мэдээлэл өгсөнд баярлалаа. Энд дахиад нэмээд хэлэхэд улс төржөөд, нэг төрийн бүтэц ИТХ-ыг шүүмжлээд байгаа зүйл бол байхгүй. Эрх зүйн орчин нөхцөл байдал нь өөрөө алдаатай байж болзошгүй. Тэр нь ашиг сонирхлын зөрчил ч бай, эсвэл зах зээл дээр эрүүл бус нөхцөл үүсгээд хувийн хэвшлийн хийх гэж байгаа ажлыг аваад хийгээд байдаг ийм зүйл үүсгэж болзошгүй гэдэг дээр Улсын Их Хурлын гишүүд санаа зовоод байна гэж хэд хэдэн хүнээс гарч байгаа. Миний хувьд ч тэгж бодож байна. Би нэг жишээ болгоод 2 компанийн асуулт тавья. Нийслэлийн аудитын дүгнэлт дээр ирсэн орон нутгийн өмчит компаниуд байгуулсан талаар, жишээлбэл, хүнсний хангамжийн үйл ажиллагаа явуулдаг 5 байгууллага байна гэнэ.

Энэ Асгат хүнс, Хүнс хангамж, Өсвөр үе, хүнс, Багачууд хүнс, Налайх хангамж гээд 5 компаниуд цэцэрлэг, эмнэлгийн байгууллагуудад ингээд хүнсний бүтээгдэхүүн, сургууль, цэцэрлэгт нийлүүлжээ. Дандаа орон нутгийн өмчит аж ахуйнууд. Эд нар маань ингээд нийлүүлээд байж гэтэл нөгөө цэцэрлэг сургуулиас нь болохоор нийлүүлж байгаа бүтээгдэхүүн өндөр үнэтэй байна, зах зээлийн ханшаас өндөр байна, хувийн хэвшлээс өндөр үнэтэй нийлүүлээд байна, чанар нь хангалтгүй байна манай байгууллага илүү зардал гаргаад алдагдалтай болчихлоо гээд гомдол гаргасан байх. Энэ Нийслэлийн аудитын дүгнэлт. Тэгэхээр эдгээр компаниуд одоо байгаа юм уу? Цаашдаа үргэлжлэх юм уу? Хувийн хэвшлээс сонгон шалгаруулалтаар тэр хүнсийг нь аваад явж болохгүй байх. Ямар үндэслэл шаардлага байгаа юм бол? Дээр ярьсан нөгөө хуулийн заалт байгаа шүү дээ. Хувийн хэвшил хийх боломжгүй тохиолдолд орон нутгийн өмчит компани хуулийн этгээд үүсгэн байгуулна гэдэгтэй нийцэж байна уу гэдэг асуултыг асууя. Нийслэлээс хэн хариулах вэ? За 9 дүгээр микрофон.

Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Б.Мөнхбат: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот хүнс хангамжийн 5 компанитай холбоотой асуудлыг лавлаж байна. НЗД-ын өнгөрсөн 7 хоногийн 4 дэх өдрийн зөвлөлийн хурлаар эдгээр 5 компанийг татан буулгах шийдэл гарсан. 3 дахь өдөр буюу 17-ны НИТХ-аар асуудал танилцуулагдахаар өргөн баригдсан. Ингээд 22-ны өдөр эцэслэн шийдвэрлэгдэх байх. Үндсэндээ бол энэ 5 компанитай холбоотой асуудал бол шийдэгдээд зах зээл буюу одоо ААН, үйлдвэрлэгчдээс хүнс хангамжаа авах чиглэл рүү орно.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Тэр 5 компанийн удирдлага дээр нийслэлийн иргэдийн төлөөлөгчдөөс байгаа юу? Бас нэг асуулт байна. Энэ ажлын хэсэг дээр товчхон мэдээлэл сонссон байгаа. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын менежмент компанийн хэрэгжүүлж байгаа төслүүд нийслэлийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс гадна бас одоо өөр засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хүрээнд явагддаг зөвлөх үйлчилгээ авдаг гэсэн ийм мэдээлэл өгсөн. Тэгээд энэ үйл ажиллагааныхаа талаар нэмэлт мэдээлэл дэлгэрүүлээд өгөөч гэж хүсье. Улаанбаатар хотын үйл ажиллагаанд нэмэр болох зорилгоор уурхай бас байгаа. Баянбогд билүү тэр бол тусдаа байгаа байх. Тэр талаар дараа нь асуучихъя.

4 дүгээр микрофоныг нээе.

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт менежмент ҮЦК-ийн захирал Г.Гангамөрөн: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя. Хөрөнгө оруулалтын менежментийн компани гэдэг нь хуулиар олгогдсоны дагуу хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж тэр сангаараа дамжуулж хөрөнгийг итгэмжлэн удирдаж хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. За манай сан нь бол СЗХ-ны зохицуулалттай байгууллага гэж явдаг.

СЗХ-оос Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын болон үнэт цаасны хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээл дээр болон хөрөнгө оруулалт менежментийн тусгай зөвшөөрүүлэх хүрээнд үйл ажиллагаагаа улсын хэмжээнд явуулах ийм боломжтой байдаг. Энэ хүрээндээ бид СЗХ-ноос 2025 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 414 дүгээр тогтоолоор үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний тусгай эрх авсан. Одоо Говь-Алтай аймагтай бусад бас аймгуудаас ирсэн санал МТЗ гэх мэтчилэн байгууллагуудын саналаар хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж ажиллаж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Энэ Говь-Алтай аймагтаа зөвлөх үйлчилгээний 250 сая төгрөгийн гэрээ байгуулаад тэгээд аймгийн Засаг даргын түр орлон гүйцэтгэгч гэрээнд гарын үсэг зурсан юм байна. Энэ гэрээ нь ажил нь хийгдчихсэн ажил уу хэрэгжих шатдаа байгаа юм болов уу? 4 номер.

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт менежмент ҮЦК-ийн захирал Г.Гангамөрөн: Энэ нэг жилийн хугацаатай гэрээ байгуулсан. Хагас жил өнгөрч байна. Одоо үйл ажиллагаа яг үргэлжлээд явж байна. Хөрөнгө оруулалтын компаниуд буюу олон улсын хөрөнгийн зах зээл дээрээс Говь-Алтай аймаг дахь сэргээгдэх эрчим хүчний төсөл буюу нарны цахилгаан станц дээр хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулагчид саналаа ирүүлчихсэн байгаа. ХАА-н чиглэлээр нэмүү өртөг шингээсэн экспортод гаргах бүтээгдэхүүн буюу дайвар мах, махан бүтээгдэхүүн дайвар бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл явуулж Япон Улсын зах зээл дээр бүтээгдэхүүнээ гаргах ийм саналыг Говь-Алтайн зүгээс тавьсан.

Энэ хүрээндээ бид Япон Улсад экспортод гаргах бүтээгдэхүүн үйлчилгээнийх нь хэлцлийг хийгээд гэрээг нь хийгээд өгчихсөн байгаа. Тэгэхээр бид нарын гэрээний хугацаа бол хагас жилийн дараа дуусна. Одоогоор бол 70%-ийн гүйцэтгэлтэй явж байна гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Хаш-Эрдэнэ гэсэн гарын үсэгтэй ийм гэрээ байгаа юм байна шүү дээ?

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт менежмент ҮЦК-ийн захирал Г.Гангамөрөн: Тийм. Говь-Алтай аймгаас энэ тендер зарласан. Бид нар тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд тендерт орж энэ үйл ажиллагааг авсан байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Төлбөр тооцоо нь бол хийгдчихсэн. Яг нөгөө гүйцэтгэлээрээ 70%-тай явж байгаа. 250 сая төгрөг дээрээ нэмээд нэмэлт төлбөр байгаа билүү?

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт менежмент ҮЦК-ийн захирал

Г.Гангамөрөн: Нэмэлт төлбөр бол хөрөнгө оруулалт хийгдсэний дараа байгаа. Энэ нь бол олон улсдаа саксес фи гэж ярьдаг ямар хэмжээний хөрөнгө оруулалтыг, ямар хугацаатай, ямар гэрээ хэлцлүүдийн үр дүнд хийгдсэнээрээ тухайн олон улсынхаа хөрөнгө оруулагч талаас тэр төлбөрөө тусдаа тэр Говь-Алтайн Засаг даргын тамгын газар шилжүүлэх үүрэгтэй. Манайхаар бол дамжихгүй ээ гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Хэдэн хувийн гэрээ байх вэ?

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт менежмент ҮЦК-ийн захирал Г.Гангамөрөн: Жишгээрээ бол 1-3%-тай байдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Яах вэ та бүхэн бол СЗХ-ноос тусгай зөвшөөрлөө аваад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлээд гэрээ байгуулаад явж байгаа субъект байна. Нөгөө хувийн хэвшил хийх боломжгүй чиглэлд орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулна гэдэг хуулийн заалттай ямар нэгэн зөрчил байна гэж үзэж байгаа юу? Энэ тал дээр мэдээлэл өгөөч?

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт менежмент ҮЦК-ийн захирал Г.Гангамөрөн: Хуулийн хувьд огт харшил байхгүй. Хэрвээ Говь-Алтай аймгийн ЗДТГ ч байдаг юм уу өөр бусад орон нутгийн байгууллагууд хөрөнгө оруулалтын чиглэлээр ахиад нэг төсвийн байгууллага ч юм уу манайх шиг ингээд тусгай зөвшөөрөлтэй компани байгуулбал нэгдүгээрт хугацаа алдана.

Хоёрдугаарт энэ чиглэлийн туршлага нэлээн удаан хугацаанд хэрэгтэй. Энэ талаасаа давхардсан бүтэц байлгахгүйгээр дээрээс нь ер нь орон нутгийн байгууллагууд Улаанбаатар хотоос нэг зүйлийг их олж харсан гэж байнга хэлдэг. Улаанбаатар хот бол өөрсдөө төсвийн бус эх үүсвэрийг бүрдүүлж төсөв даадаггүй. Одоо энэ мега гэж нэрлэж байгаа томоохон дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэлт гаргалаа. Эндээс бас суралцаж энэ дагуу явъя гэдэг. Энэ чиглэлээр бид нараас зөвлөгөө мэдээлэл их авдаг. Тэр ч үүднээсээ сэргээгдэх эрчим хүчний болон дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүд бол нэлээн өндөр дүнтэй. Хамгийн багадаа 20-30 сая ам.доллараас 300-500 сая хүртэлх ам.долларын хөрөнгө оруулалтууд яригддаг. Энийг төсвийн ямар нэг байгууллага юм уу, хувийн ААН төрийн одоо ямар нэгэн байгууллага хийхэд хэцүү. Энийг яг мэргэжлийн хөрөнгө оруулалтын, хөрөнгө оруулалт менежментийн компани хийж хэрэгжүүлдэг.

Энэ онцлогоороо Монгол Улсад яг төрийн оролцоотой хоёрхон компани үйл ажиллагаа явуулдаг юм. Нэг нь манай Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт менежментийн компани. Энэ үүднээсээ зөвлөх үйлчилгээнийхээ хүрээнд бусад орон нутгийн байгууллагууддаа төсөвтөө ачаалал үүсгэхгүйгээр, гэхдээ хөрөнгө оруулалт, менежмент, санхүүжилтийн хамгийн зөв бүтцээр хууль тогтоомжид, бүх төрлөөр нийцсэн, олон улсын хөрөнгө оруулагчдын хяналт шалгалтын хүрээнд ил тод байдлаар ажиллахад нь одоо зөвшөөрөлтэйгөөр тусламж үйлчилгээ зөвлөгөө үзүүлдэг гэсэн үг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Мэдээлэл өгсөнд баярлалаа. Нийслэл Улаанбаатар хот маань ингээд бонд босгоно, бондоо банканд тавьж, арилжааны банкнаас нэмэлт орлого олно. Тэр олсон орлогоо нийтийн сайн сайхны төлөө, Улаанбаатар хотынхоо төлөө янз бүрийн зүйлд зарцуулна. Үнэт цаасны менежментийн үйлчилгээ үзүүлнэ. Нэгэнт өөрсдөө том мөнгө босгоод явж байгаа хүмүүс туршлагатай баг болчихсон байгаа. Тэрүүгээрээ ингээд бусдадаа

тусалъя ч гэдэг юм уу, чанартай сайн хоолоор хангах компани байгуулъя сургууль, цэцэрлэгээ хангая гэх мэтчилэн. Энэ зүгээр концепцын ялгаа асуудалтай зүйл яваад байна. Одоо үг хэлэх хэсэг эхэлж байгаа болохоор би шууд үгээ хэлж байгаа юм. Энэ маань зөв үү буруу юу? гэдэг асуудал байгаа. Хууль тогтоомжийнхоо хүрээнд та бүхэн үйл ажиллагаагаа явуулж байгаа. Гэхдээ Улаанбаатар гэдэг нэг ийм том корпорац болсон хэв маяг харагдаад байна. Ингээд баахан хувийн хэвшлийн хийдэг үйл ажиллагаануудыг явуулаад давхар санхүүгийн ч бай, худалдааны ч бай үйл ажиллагаа явуулаад тэрийг чинь удирдана. Удирдлага улс төрийн албан тушаалтнууд ч байна, төрийн албаныхан ч байна. Хүссэн хүсээгүй эрх ашгийн зөрчил рүү орно.

Зарим хуулийн заалтыг өдөр бид нар ярилаа шүү дээ. Зарим хуулийн заалт дээр илэрхий эрх ашиг нь орооцолдсон зүйл дээр шийдвэр гаргаад явсан байна. Холбоотой асуудал төслүүд дээр санал хураагаад төсөв батална гэдэг одоо хуулийг тайлбарласан ч гэсэндээ агуулгаар бүгдээрээ л ойлгож байгаа. Энэ эрх ашиг нь их багаар холбоотой гэсэн үг. Тэгэхээр энэ бүтэц маань аль хүртэл явах вэ эндээс ямар алдаанууд гарах вэ? Тэр гарсан алдаа нь мэргэжлийн хүмүүсийн хувьд болоод хариуцлага татагдах асуудал. Улсын төсөв, эдийн засаг дээр яаж эрсдэл үүсгэж болох вэ гэдэг. Энэ зүйлийг бол тойрч өнөөдөр ярилаа.

УИХ-ын гишүүд асуулт, асууж хариулт авч дууслаа. Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Р.Батболд гишүүнээр тасалъя. Дэгээрээ нэрсийн дарааллаар нэг гишүүн 5 минутад багтаан үг хэлж болно гэж заасан. За Р.Батболд гишүүний микрофоныг нээж өгнө үү.

УИХ-ын гишүүн Р.Батболд: Би богинохон үг хэлнэ. Энэ нийслэлийн өнөөдрийнх чинь энэ Нийслэлийн төсөв тэрний зарцуулалттай холбоотой ийм сонсгол хийгээд байгаа. Зарим гишүүд маань орж ирээд Улсын Их Хурлынхаа гишүүдийг байдаг юм уу, Улсын Их Хурлынхаа үйл ажиллагааг хамаагүй заачих гээд байдаг ийм асуудал үүсээд байх юм. Нийслэлийн асуудлыг ярихаар энэ П.Сайнзориг гэж гишүүн ерөөсөө орж ирээд загнаад эхэлдэг. Чи буруу юм ярилаа. Улаанбаатарчууд чинь утаагүй амьдрах ёсгүй юм уу? байранд амьдрах ёсгүй юм уу гээд загнаад байх юм. Хийж байгаа ажил нь зөв өө. Хэлээд байгаа шүү дээ. Санал санаачилга нь ч зөв, зүгээр хийж байгаа яг энэ процесс нь болохгүй байна, төсөвт өртөг нь хамаагүй их байгаад байна, энийгээ та нар үзээч ээ. Тэгээд холбогдуулаад хэлээд байгаа нь тэр. Нийслэлийн 45 гишүүн чинь энийгээ хянаж чадахгүй болчихсон байна.

Хэн ер нь энэ төсөвт өртгийг зохиогоод, тэгээд хэн зургийг нь зохиогоод байдаг юм? Хэн нь тэрийгээ хянан баталгаажуулаад байдаг юм. Ийм асуудлууд яваад байгаа юм. Одоо хийж байгаа бүх л ажил дээр нь ийм төсөв мөнгөтэй холбоотой асуудал үүсээд байна л даа. Тийм учраас л яригдаад байгаа шүү дээ. Түүнээс биш зүв зүгээр явж байгаа нийслэлийн ажлыг үгүй татаж авчраад л ерөөсөө болохгүй байна, бүтэхгүй байна гэж яриад байгаа юм ерөөсөө байхгүй. Энд яагаад ийм асуудалд орчхоод байгаагаа нийслэлийнхэн ч гэсэн өөрсдөө бодох хэрэгтэй байна.

Бид улсын төсвөөс илүү өртгөөр нийслэлд ажил хийгээд байна шүү дээ. Улсын төсөв дээр тавьж байгаа өртгөөс илүү үнээр нийслэлд чинь хамаг юмандаа ойрхон газар бүх юм нь бэлэн байж байгаа юмыг аваачаад улсын төсөв дээр тавьдаг, илүү үнээр хийгээд байна шүү дээ. Энийгээ Нийслэл яагаад ойлгохгүй байгаа юм бэ гэдэг л асуудал байгаа юм. Энэ дээр маргааш ч гэсэн зөндөө асуудлууд үүсэх байх

л даа. Яригдах байх. Тэгээд П.Сайнзориг гишүүндээ одоо шууд зориулаад хэлчихмээр байна. Одоо энэ улс төржөөд байдаг асуудлаа больчих.

Бид нар ерөөсөө төсөв санхүүгийн асуудал л яриад байгаа юм. Түүнээс биш энд нэг их улс төржөөд янз бүр болоод байгаа юм байхгүй Нийслэлийн ажлыг буруутгаад байгаа ч юм алга. Энэ хийж байгаа ажлууд нь зөв. Тэгсэн хэр нь та нарын наад төсөв зарцуулалт хөрөнгө оруулалт чинь бүр арай дэндүү боллоо. Одоо халаасандаа хийчихсэнийг чинь мэдэхгүй болохоор хулгайч нар гээд дуудчихад хэцүү байна. Тэгэхдээ наадах чинь одоо бүр арай л дэндүү байна шүү дээ. Бүр яаж ч бодсон хувийн ААН-үүд чинь гайхаад савж унаад байна шүү дээ.

Нийслэлээс ажил авчих юм сан гэдэг, нөгөө төлөөлөгч нар нь өөрсдөө хуваагаад идчихдэг ийм л байдалтай болчихоод байна шүү дээ. Энэн дээрээ та нар дүгнэлт хийгээд ажиллах ёстой шүү дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Н.Алтаншагай гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай: Баярлалаа. Монгол Улсын Үндсэн хуульд нутгийн өөрөө удирдах ёс орон нутгийн бие даасан байдлыг хангасан суурь үзэл баримтлалыг тодорхой зохицуулсан. Эдгээрийг доор дурдсан 3 зохицуулалтыг та бүхэндээ энэ сонсгол санаачилсан гишүүддээ уншаад танилцуулчихъя гэж байгаа юм.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна” гэж заасан.

Хоёрдугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэж заасан.

Гуравдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” гэсэн зохицуулалтууд байгаа.

Орон нутгийн бие даасан байдлыг хангах, хөгжүүлэх, иргэдийн аж ахуйн амьдралыг одоо сайжруулах, ажил орлоготой байлгах, аятай тухтай орчинд амьдруулах асуудлыг одоо гол хөшүүрэг нь төсөв, санхүүгийн бие даасан, хараат бус байдал гэж байгаа юм. Ингээд үе үеийн хотын дарга нар маань энэ нэг санхүү бүрдүүлэх энэ бүтээн байгуулалтаа үргэлжлүүлэх явуулах гээд энэ нэг ийм асуудалтай үе үе тулгарч байсан. Зөвхөн төсвөөс хараат бус байхын тулд тэгээд аргаа ядахдаа миний мэдэж байгаагаар энэ 2021 онд тухайн үеийн НЗД Д.Сумъяабазар дарга энэ Баянбогд байх хот уурхайтай больё гээд явж байсан шүү

дээ. Эндээсээ мөнгө босгоё, хотдоо энэ зам, талбай, гүүр гээд бүх нийгмийн асуудлуудаа шийдвэрлээ гээд ярьж байсан. Тэгэхээр бид ингээд буцаасан социализмын үе рүүгээ шилжмээргүй байгаа юм. Нэгэнт энэ одоо Үндсэн хуулийн суурь зарчмаар орон нутгийн байгууллагад нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад бүх эрх мэдлийг нь өгчхөөд буцаагаад бүгдийг нь татдаг.

Бүгдийг нь эндээ төвлөрүүлдэг. Эсхүл бол одоо энд Нийслэлийн иргэдийн хурал гэж байгаад яах юм. Эд нар нь өөрөө асуудлаа шийдэхгүй юм бол нөгөө социализмын үеийн төвлөрсөн төлөвлөгөөт гэдэг шиг 21 аймаг, 9 дүүрэг, 331 сумдаа ингээд төсвийг нь хуваарилж өгөөд шууд явчихдаг. Энэ зарчим руугаа нэг шилжих гээд байгаа юм шиг. Ийм ухралтын агуулгатай юмнууд сүүлд гараад ирсэн. Энэ нийслэлийн иргэдийн хурлаа нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь одоо байгаа хууль тогтоомждоо л би тааруулж ажиллаж байна гэж энэ нөхдүүдийг энэ явж ирсэн процессыг харж байгаа. Тэгээд цаашдаа дээр бид бүхэн онцгойлон анхаарахгүй бол болохгүй.

Төр өмчтэй байх ёстой шүү. Энэ хоол үйлдвэрлэлийн чиглэлийн 5 компани гээд яригдаад байгаа бол нөгөө хүүхдийн хүнсний аюулгүй байдалтай яригдаж байгаа учраас онцгойлон анхаарах ёстой. Төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй л гэдэг санал. Гэхдээ төр алдагдалтай ч гэсэн үүрэх ёстой ачаагаа үүрэх ёстой шүү. Ялангуяа энэ хүүхдийн эрүүл мэнд, хамгаалал дээр. Энэ дээр хотын удирдлагууд бодолцоно биз.

Дараачийн нэг асуудал Сэлбэ төвтэй холбоотой асуудлууд их олон тойрч ярьсан. Гадаад зээлийн үр ашгуудыг нэмэгдүүлэх тухай хуулийг санаачлаад өргөн баригдаад эрчим хүч, цахилгаан нефть боловсруулах үйлдвэр нь явагдаад Сэлбэ дэд төв маань хасагдсан. Гэхдээ өөрийгөө зохицуулаад явчих нийслэл дээрээ эрэмбэлээд, төсөвтөө суулгаад явчих ийм боломжтой гэж үзсэн. Энэ бол Улаанбаатарт хэрэгжиж байгаа анхны бөгөөд төр оролцсон үлдсэн энэ байшин хорооллын төсөл гэж ойлгож байгаа. 2012 онд эхэлсэн дахин төлөвлөлтийн ажил төр оролцоогүйгээс нурсан шүү дээ. Хэдэн компаниуд байршил зааж өгсөн. Айлын хашаа худалдаж аваад суурь цутгаад бүгд алга болсон.

Төр тэгэхээр оролцохдоо бас оролцож дараачийн хувийн хэвслүүддээ нөгөө зам мөрийг нь гаргаж өгч боломжийг нь нээж өгөөд л холдох ёстой. Энэ зарчмаар явах ёстой. Тэгэхээр Сэлбэ явах ёстой зайлшгүй агаар орчны хөрсний бохирдлыг хамгийн сайн бууруулах, мөн 20 минут хот энэ хүрээндээ явах ёстой томоохон төсөл шүү гэдгийг бас хэлэх нь зөв байх. Ингээд маргааш хэлэлцэх асуудлууд дээр санал бодлоо илэрхийлье.

Нийслэлийн удирдлагууд зөндөө боломжууд бий. Бүх боломжуудаа тултал хэрэглэж хууль, эрх зүйн хувьд нь нийцүүлэх, маргаашийн хэлэлцүүлэг дээр иргэдэд энэ мэдээллээ сайн өгч, эргэлзээг нь тайлах ёстой шүү. Тэгж байж энэ том төслүүд цаашаагаа явна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шаардлагыг нь хангаад энэ сонсгол хийж байгаа байх гэж би бодоод байгаа шүү. Жоохон буруу ч юм хийгээд байгаа юм шиг санагдаад явчих юм. Сүүлдээ нутгийн өөрөө удирдах ёс руу халдаад, бие даасан байдлыг нь алдагдуулах гээд л

энд татаж авчрах гээд төвлөрүүлэх гээд байгаа ч юм шиг бас яриад байгаад нь би гайхаад байна. Үгүй ээ энэ чинь түүгээрээ л явж байсан шүү дээ. Болохоо байчхаад энд авчирч ярьж байна гэж би ойлгоод байгаа шүү дээ.

Ингээд яагаад вэ гээд харахаар аргагүй нөгөө хяналт тавьж байх үүрэг функцтэй иргэдийн төлөөлөгчид нь өөрснөө цалингүй учраас янз бүрийн ТУЗ-ийн гишүүн болчихсон, аж ахуйтай хутгалдчихсан болохоор яаж хяналт тавьж чадах юм. Тэгээд хяналтгүй болчихсон байсан шүү дээ. Төлөөлөгчдийг ерөөсөө буруутгаагүй. Эрх зүйн орчиндоо л ажиллаж байгаа. Тэрийг бол буруутгаж байгаадаа биш. Гэтэл нэг тун хэтрээд, савнаасаа халихаар юу болдог билээ тийм байдал үүсчихсэн шүү дээ. Вант улс болчихсон байна гээд УИХ-ын гишүүд зөндөө хэлсэн.

Тэгээд бүр аргаа бараад энд ирж асуулт асуугаад байна гэж бодоод байгаа шүү дээ. Энэ тийм зөв зүйтэй, сайн сайхан юм байлгүй л яах вэ. Мэдээж зөндөө л ажил хийж байна. Нийслэлээ бас нэг өөд нь татчих гээд л өглөө, үдэш, оройгүй явцгааж байгаа. Тэрийг ойлгож байна. Гэхдээ маш их асуудал байна шүү дээ. Нэг жилд 5 удаа тодотгол хийнэ гэдэг чинь бас яг юу гэсэн үг вэ? Наад зах нь ер нь төлөвлөлт гэж байгаа юм уу? Хоёрт, зураг төсөвгүй магадлалын дүгнэлтийнх нь хугацаа нь дуусчихсан эсвэл газар нь бүрэн шийдэгдээгүй 1,5 их наяд төгрөгийн гэрээний дүнтэй 75 төсөл арга хэмжээг эхлүүлчихсэн байна гэж байна.

Энэ одоо зүгээр үү? эрүүл үү? хууль ёсны дагуу юу? яагаад эхлүүлж байгаа юм. Жишээ нь хуульд бол болохгүй шүү дээ. Зураг төсөвгүй хэр нь юун дээр үндэслэж барих гээд байгаа юм? Жишээлбэл, энэ СХД-ийн 11 байршил дээр авто зам барих гэж байгаа юм. Зураг байхгүй байж яаж зам барих гээд ингээд мөнгө төгрөгийг нь өгөөд байгаа юм. Энэ чинь асуудлууд байгаад байгаа байхгүй юу даа. Тийм учраас энэ чинь бүр одоо аргаа бараад энэ Улсын Их Хурал дээр орж ирж байна л даа. Мэдээж энэ байгаа хууль, эрх зүйн орчин нь ийм байгааг бол ойлгож л байна.

Мэдээж энд татаж ирж төвлөрүүлж ярьж байгаагийн үндсэн дээр бол маш хурдан эрх зүйн өөрчлөлтийг оруулах шаардлагатай. Түрүүнд П.Сайнзориг гишүүн хэлсэн тэр эрх зүйн нэмэлт өөрчлөлтийг бол хийх шаардлагатай. Тэгэхгүй бол ерөөсөө жинхэнэ засаглалын хямрал болчихсон юм байна гэж би дүгнэлээ. Төсөв баталж байгаа хүмүүс нь өөрсдөө эрх ашгийн зөрчил, ашиг сонирхлын зөрчилтэй юм шиг болж хувирчихсан байгаа байхгүй юу. Бид нар энийг ярихаас өөр замгүй болчихсон байна. Нэг талаасаа хууль, эрх зүйн орчин нь буруу байна гэдэг зүйл байгаа учир энэ Улсын Их Хуралтай холбоотой. Тийм учраас энийг энд ярихаас өөр замгүй болж байгаа юм. Тэгээд мэдээж бид нар цаашид юу хийх вэ гэдэг чухал. Хүн болгон ингээд сонсгол хийдэг, сонсоод өнгөрдөг, цаашид үр дүн байхгүй гэдэг юм руу орох гээд байна л даа.

Би Ж.Золжаргал гишүүнийг их ажил хэрэгч гэж бодож байгаа учир эндээс цаашид юу хийх, ямар ажил хийх вэ гэдгээ маш нарийн гаргаж, тэрнийхээ төлөө явах хэрэгтэй байх. Ямар хуульд ямар өөрчлөлт орох юм бол энэ засаглалын хямрал нь арилах, яаж ил тод болох юм гээд олон асуултууд байна. Тэр хууль, эрх зүйн орчныг нь маш яаралтай сайжруулж өгөхөөс нааш энэ бантан бол арилахгүй юм байна. Нөгөө талаас мэдээж бүх энэ зөрчил, алдаа дутагдлын ард бол хэн нэгэн хүн хариуцлага хүлээх ёстой. Заавал ч үгүй хариуцлага хүлээх ёстой.

Түүнээс биш ажлаа өгөөд, улс төрөөс гарчихаараа хариуцлага хүлээхгүй болчихно гэдэг юм бол байхгүй байх гэж найдаж байна. Монгол Ардын намынхан

хоорондоо хэрэг наймаалцдаг маяг руу орчих вий гэж санаа зовж байна. Би бол мэдэхгүй л дээ. Зүгээр хэн ямар хариуцлага хүлээх юм? Гэхдээ ингээд удирдлага нь бүрэн солигдчихсон, тэгээд яг хариуцах ёстой өмнө нь хэдэн жил хийсэн тэр хариуцлага хүлээх ёстой хүмүүсээс нь уг нь асууж байх ёстой. Гэхдээ ингээд байхгүй хүмүүс нь ер нь хариуцлага хүлээх юм уу? үгүй юм уу? Түрүүн би АТГ-аас уг нь асуусан юм.

Тэр нэг хэрэг гомдол юм уу эсвэл ХАСХОМ-ийн зөрчил юм уу? Би тэрийг нь мэдэж чадаагүй. Дандаа 50-аас дээш хувийн зөрчилтэй гэж гарсан байгаа байхгүй юу.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Ж.Галбадрах гишүүн үг хэлье.

УИХ-ын гишүүн Ж.Галбадрах: Оройн мэнд хүргэе. Би уг нь асуулт асууя гэж бодож байсан. Тэгээд өөр ажилтай давхцаад амжсангүй. Та бүхэнд хэдэн үг хэлье. Манай Улаанбаатар хот маань “Азийн цагаан дагина” гээд л Азидаа нэртэй. Бид нар ч гэсэн одоо эргээд дурсаад Улаанбаатар хотоо харахад нэг тийм сайхан хот байсан юм. Өндөр өндөр шилэн барилга байгаагүй ч гэсэн иргэд нь аз жаргалтай сайхан ийм цаг үе байсан.

Өнөөдөр бол гаднаас ирсэн зочид хараад Улаанбаатар хот мундаг хөгжиж байна, энэ өндөр барилгуудыг хараад иргэд маань өнөөдөр үнэхээр аз жаргалтай амьдарч байна уу гэвэл үгүй байна. Та бүхэн маань “Аз жаргалтай Улаанбаатар хот” гээд л арга хэмжээнүүд хийгээд байсан. Одоо аз жаргалын индекс нь ийм өндөр байна гээд өөрсдийгөө юу гэдэг юм хийсвэр дүгнэлт ингээд хийгээд яваад байгаа.

Тэгэхээр бид нар аз жаргал гэдгийг юу гэж ойлгох вэ? иргэд маань аз жаргалтай амьдарна гэж юу вэ гэдгийгээ л үндсэн философиор нь их сайн ойлгох ёстой. Үндсэн хэмжүүр шалгуурууд байж байгаа шүү дээ. Зүгээр би энэ дотор гуравхан зүйлээ хэлэхэд бол ерөөсөө л үр хүүхэд нь чанартай боловсрол олж авч чадаж байхад нэгдүгээрт эцэг, эх тэнд байж байгаа хүмүүс аз жаргалтай.

Өнөөдөр Улаанбаатар хотын боловсрол чанартай байгаа юу? Улаанбаатар хотын боловсрол маш хэцүү байгаа шүү. Тэр даацаас, хүртээмжгүй байдлаас, тэр багшийн хомсдолоос болоод, багшийн ачааллаас болоод сургуулийн боловсрол бол чанаргүй болчихсон байна.

Хоёрдугаарт эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах гэж байгаа эмнэлэг үйлчилгээ маань үнэхээр чанартай үйлчилгээгээ үзүүлж чадаж байна уу? Юунаас болоод үзүүлж чадахгүй байгаа вэ? Энэ хүн амын нягтрал суурьшил энийг дагаад барих тэр эмнэлгийн үйлчилгээнүүд ямар байна вэ? Орон сууцын хүртээмжийн асуудал энэ зүйлүүдийгээ та бүхэн маань харж байгаа.

Тэгээд хамгийн гол шалтгаан нь энэ 3 зүйл дээр хэлэхэд сургууль хүртээмжгүй, эмнэлэг чанаргүй байгаа гэдэг асуудал маань орон сууц хүрэлцэхгүй гэдэг асуудал нь хот төлөвлөлт жинхэнэ шинжлэх ухааны үндэстэй явж байна уу? гэдэг л асуудал байна. Сургууль барьж байгаа бол, хотхон, хороолол барьж байгаа бол заавал сургууль, цэцэрлэг барих ёстой. Тэгээд энэ хууль дүрэм яаж хэрэгжээд байгаа юм. Ямар ч сургуульгүй газар ахиад л барилга бариад л байна. Шинээр баригдаад байна шүү дээ. Одоо шинэ удирдлага гарч ирсэн байгаа. Би шинэ удирдлагад бас хүлээлт байгаа амжилт хүсэж байна.

Бид чинь нэг барилга баригдсаний нь дараа нураана гээд л явж байна шүү дээ. Суурийг нь тавиад явчихсаны дараа зөвшөөрлийг зогсооно, нураана гэж яриад байгаа. Тэрнээсээ өмнө зөвшөөрөл өгөөд, энд яагаад ч 16 давхар байшин барьж болохгүй дээ гэж байгаа газар барилга барьчихаад байна шүү дээ. Жижигхэн зайнд ямар ч зогсоол байхгүй, ямар ч сургууль барихгүй. Тэрний оронд тэнд нь сургууль барья, газрыг чинь худалдаж авъя гэж болохгүй юу? гэдэг асуудал байгаа.

Үүнийг нь ингээд харахаар зарлага нь 7-8 их наяд байгаа юм байна шүү дээ. Энэ мега төслүүдэд зориулсан төсөв чинь төсөв 6,4 их наяд, үүнээс 5,1 нь хөрөнгө оруулалт гэж байгаа. 5,1-ийн их наядаар хөрөнгө оруулах гээд байхад үүн дотор тэр сургууль, цэцэрлэгээ барихгүй, Сангийн яам ингэсэн гээд хэлчхээд өнөөдөр ширээ, сандал алга гээд шүүмжлээд яваад байх ёстой юм уу? Нийслэл яагаад сургууль барьж болохгүй гэж. Бидэнд энэ ойрхон Казахстан, Оросын туршлага байж байна. Казахстан бол 240 сургуулийг хотууд нь өөрсдөө барьж байна шүү дээ. Нэмээд энэ Оросын туршлага бол 14 дүгээр сургууль гээд 6 мянган хүүхэдтэй сургууль байлаа гэхэд яагаад ч сургууль 6 мянган хүүхдэд чанартай сургалт явуулахгүй. Тэр ойролцоо нь 13 дугаар хорооных нь хүүхдүүд явдаг газрын 2 сургууль шинээр барья. Гэхдээ тэр нь 14 дүгээр сургуулийнхаа харьяандаа л тэр 2-3 сургуулийг оруулаад дэд захирлууд тавья.

Ерөнхий захиралтай болоод тэгээд сургуулиудыг дотор нь төрөлжүүлээд хүүхдүүд, багш нар нь явдаг байя. Ийм байдлаар хийхгүй бол бид энэ тал дээрээ бас их дутагдалтай байна гэдгийг хэлэх гээд байгаа юм. Би бас мэргэжлийн хүний хувьд хувийн сургууль, хувийнхантайгаа хоршиж ажиллаад хувийн сургуулиудыгаа дэмжээд явж байгаа зүйлийг ярилаа. Ялангуяа бага, дунд сургууль дээр бол төр, нийслэл маань сайн анхаараад ахлах сургуулиудад боломжийг нь өгөөд. Хувийн сургуулиуд тэндээ барилгаа өөрсдөө барих боломжууд байдаг шүү дээ. Мэргэжлийн тал дээр нь ингээд явах талыг бас бодож ажиллаасай л гэж бодож байна. Тэгээд иргэдийнхээ санал, санаачилгыг авах хэрэгтэй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: П.Сайнзориг гишүүн үг хэлнэ.

УИХ-ын гишүүн П.Сайнзориг: Сонсголыг бас эерэг талаас нь харах ёстой. Одоо олон зүйлүүд манай Галбадрах багш бол боловсролын асуудлаар дагнадаг учраас энэ талруугаа чиглүүлж хэлж байх шиг байна. Би бас зарим гишүүдийн хэлээд байгаа засаглалыг сайжруулах, төсвийн бодлого зохицуулалт, хэрэгжилтийн асуудал ямар байгаа юм. Энэ бүх зүйлүүд дээр үүнийгээ сонгуулийн тогтолцоо ямар байх юм, гэдэг зүйлсийг ярьж байгаа нь их сайн байна.

Маш олон жил яриад яг гүйцэтгэл байхгүй, хэрэгжүүлэх шийдэл рүүгээ зориглоод орох гээд явж байна. Тэгэхээр нэг жоохон улс төрийн нюансуудаас нь болж өгдөггүй зүйл байсан. Тэгээд би энэ хэлэлцүүлгийг бодолцоод цаашид орон нутгийн эрх мэдлийн асуудал угаасаа байна. Өгсөн эрх мэдэл дээр ингэж ч хэрэгжүүлээ гэдэг загнаж ерөөсөө болохгүй. Үнэхээр томдоод байгаа бол Улсын Их Хурал нь буцаагаад авчих хэрэгтэй. Яах аргагүй л нэгжийн хуулиар зам, гүүр, сургууль, цэцэрлэг барих асуудал нь орон нутгийн асуудал.

Яам бол бодлогоо гаргана шүү л гээд байсан. Одоо тэгээд барихаар загнаад байна. Мөнгөө босгож ирээд барихаар ч их мөнгө босгож ирээд улсаасаа томорлоо гээд байх юм. Улаанбаатарыг чинь нүүлгэж аваад мөрөн дээрээ тавиад өөр тийшээ

явчхаж чадахгүй биз дээ? тэгээд юу яриад ингээд байгаа юм. Харин төсвийн бодлого талаасаа болгоомжлолыг бол ойлгож байна. Мэдээж энэ асуудал дээр нутгийн өөрөө удирдах бус байгууллага Засгийн газар холбогдох хяналтын байгууллагуудтайгаа маш сайн мэдээллээ өгөөд ойлголцоод явах ёстой. Угаасаа л явж ирсэн юм. Бид хэдийн олон нийтэд өгөөд байгаа мэдээлэл нь тэр. Ингээд манай Р.Батболд гээд нам ч үгүй, намаа хувааж тоглодог шантаажчин, нэг тендерчин нөхөр та нар ямар их том төслүүд хэрэгжүүлээд байгаа юм гээд ийм солиотой юм яриад. Тэгэхээр энэ чинь ерөөсөө мэтгэлцээн биш болчихоод байна. Энэ хүн Сэлбэ төсөл эхэлж байхад л шантааж хийгээд гүйж байсан тийм л нөхөр шүү дээ. Тэгээд одоо нэг гэгээн цагаан, дүртэй гэж андуурдаг юм. Гэгээн, цагаан дүртэй хүмүүс зөндөө байна. Та бүгдийн бас нийслэлийн 2 сая иргэдийн зовлонг жоохон нимгэлэх биш битгий нэмчхээсэй. Ийм сэдэв барьж байгаад улс төрийн карьер, капиталаа олж авч байгаа бол тэр ажилд нь амжилт хүсье. Зарим хүмүүст 2028 онд нь амжилт хүсье.

Харин нийслэлчүүдийн нийтлэг эрх ашгийн төлөө явж байгаа зүйлүүд дээр үнэхээр зөв байвал зөвийг нь дуугараад, буруу бол буруу байвал ингэж шийдье гээд шийдэлтэйгээ гоё мэтгэлцээсэй гэж би хүсэж байна. Тэрнээс биш хоосон иргэдийг төөрөлдүүлсэн, хариуцлага тооцох вэ гэдэг байдлаар хандаж байна. Сүүлдээ энэ иргэд чинь итгэхгүй байна. Хэдэн их наядыг идчихлээ гээд. Монголд угаасаа тийм их мөнгө байхгүй.

Эцсийн дүндээ 16 юм уу? 24 төслийн ТЭЗҮ дэх тоонуудыг нэгтгэж байгаад нийгэмд хаяж өгч “пүү паа” болгоод. бодит мэдээллээ сонсохоор тийм л байгаа биз дээ? 24 төслийн чинь дөнгөж 11 нь дөнгөж гараанаасаа гараад бага зэрэг санхүүжилт олгоод явж байна л гэж байна. Иргэдийн тархи угаагаад. МАН бас нийслэлд дахиад ялчих вий гэж бас хандаж байхыг бас үгүйсгэхгүй. Яах вэ энд бас улс төрийн өрсөлдөөн явж байгаа учраас би энэ өнцгийг нь бол хүндэтгэнэ.

Улс төрчдийн хувьд гэхдээ огтоос шинжлэх ухаан болон судлаачдын нэр барьж байгаад ингэж будилуулдаг, нийгмийг хар айдсаар автуулдаг ийм бүлэг этгээдүүд байна. Энийг уг нь бусад оронд бол хорлон сүйтгэх үйл ажиллагаа гэдэг юм. Гэмт хэрэгтэй байхгүй юу. Тухайн улс орны нийгэм, эдийн засгийн амьдралыг саатуулах хорлон сүйтгэх ажиллагаа гэдэг. Манайд даанч ийм зүйлийн хариуцлага нь байхгүй учраас дураараа дургиж байгаа юм. Ийм зүйл их байх юм.

За тэгээд одоо яах вэ? Энэ сонсголын үр дүнд цаашдаа засаг, захиргаа нэгжийн тухай хуулийн шинэчлэлийг яваасай, үнэхээр цаашдаа 21 аймаг, Нийслэлийнхээ статусыг зөв тодорхойлоосой. Засаг дарга, Хотын захирагч гэдэг тусдаа этгээд байдаг юм байна гэж. Статус буюу аж, ахуй эрхэлдэг хүн байдаг юм байна. Хот гэдэг нь өөрөө корпорацийн зарчмаар ажилладаг гэдэг дэлхий нийтийн чиг хандлагыг ойлгодог болох эргэлтийн цэг юм шиг надад санагдаад байна.

Олон хүмүүс бас энэ асуудлыг ярьж хэлээд, зөв ойлголт талаас нь хэлээд байна. Хэдүүлээ энэ орон нутгийн иргэд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон энэ ажил хийж байгаа хүмүүсийг байнга дууддаг юм руу битгий орчхоосой гэдэг л байна. Нийтлэг энэ асуудлуудыг нь шийдэж өгөх зөвлөмжүүдээ сайн өгөөсэй л гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Золжаргал: Зөвлөмжийн асуудлыг дахиад ярьсан П.Сайнзориг гишүүндээ баярлалаа. Сонсголын зорилгыг дахиад хэлэхэд яг энэ эрх зүйн орчны талаар бид нар санал, дүгнэлт боловсруулах ёстой байх. Өнөөдрийн сонсголын явцад шинээр мэдээлэл шаардлагатай болсон 3 зүйл байна. Энэ талаар бол та бүхэндээ мэдээлэл өгье.

Нэгдүгээрт, иргэн асуудал гаргаж ирсэн. Сонсгол явуулах үедээ бэлдэж, цуглуулсан мэдээллийг нэгдсэн системд байрлуулах ёстой гэж. Тэгэхээр энэ хуулийн зүйл заалтын дагуу сонсголын дараа тайлан мэдээг 5 хоногийн дотор нийтэлнэ. Түүнээс гадна сонсгол бэлдэхэд цуглуулсан мэдээллийг хуулийн дагуу нэгдсэн системд байрлуулах. Тэнд нь байрлуулах зай багтаамж байдаггүй бол бий болгох талаар албан бичиг сонсгол даргалагчийн зүгээс Улсын Их Хурлын Тамгын газар луу явууллаа. Тэгэхээр энэ мэдээллийг та бүхэн авч танилцаж анализ хийгээрэй. Мэдээж тэнд мэргэжлийн хүмүүс ангилна. Тэгээд олон нийтэд нээлттэй тавьж болох мэдээллүүдийг бол тавих ёстой. Хууль хэрэгжих ёстой гэж үзэж байгаа. Техникийн шалтгаанаас болоод хууль хэрэгжүүлэхгүй байж болохгүй. Ямар нэгэн байдлаар шийдэх ёстой.

Хоёрдугаарт нь, НИТХ-ын протоколоос томоохон төслүүдийн шийдвэр гаргалттай холбоотойгоор төслийн удирдлага дээр ажилладаг иргэдийн төлөөлөгчид хуралд орохоос татгалзсан, ашиг сонирхлын зөрчлийн нөхцөл байдал үүсэж болзошгүй учраас татгалзсантай холбоотой мэдээллийг ирүүлэхээр болсон. Тэгэхээр энэ мэдээлэл бэлэн байгаа, маргааш өгнө гэж бодож байна. Бүх протокол, мэдэгдэл бэлэн байх ёстой. Маргааш өглөөний сонсгол дээр ирүүлсэн байхыг хүсье. Тамгын газрынхаа араас нь анхаарч ажиллаарай.

Гуравдугаарт нь гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөл гээд 70-аад тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байгууллага байгаа. Маш олон мэдээлэл ирж байгаа. Тэгэхээр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөлийн гүйлгээний зарцуулалт, ямар данс руу, ямар зорилгоор зарцуулсан бэ? Гэдэг талаар албан бичиг хүргүүлж, энэ талаарх мэдээллийг маргааш авах хүсэлтэй байна.

Үүнийг Тамгын газрын Хяналт шалгалтын газрынхан албан бичгийг нь явуулъя гэж хүсэж байна. Өнөөдрийн сонсголыг дүгнэхэд, ямар ч байсан маш их мэдээлэл бид нар солилцлоо. Үнэхээр нийслэлийн хэрэгжүүлж байгаа том мега төслүүдийн цар хүрээ, мөнгөн дүн, оролцсон хүний тоо асар том учраас ийм богино хугацаанд бүгдийг нь дүгнэнэ гэж юу байх вэ. Гэхдээ агуулгын болон зарчмын зүйлсийг бид маш тодорхой харж байна. Нэгдүгээрт нь, нийслэлийн зарцуулж байгаа төсөв, томоохон хөрөнгө оруулалтууд, улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалт их байна. Төсвийн алдагдал 2,4 их наяд буюу улсын төсвийн алдагдлаас 1,4 их наядаар их байна. Энэ бүхэн чинь эргээд эдийн засгийн бодлого, төсөв дээр том нөлөө үзүүлэх учраас яаж засаж залруулах вэ гэдгийг бодох хэрэгтэй болж байгаа юм.

Хоёрдугаарт нь, олон ААН байгуулж, түүгээрээ дамжуулж мөнгөн гүйлгээ хийх тэр нь бас хангалттай хяналттай биш байна. Ийм нөхцөл харагдаж байна. Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бусад бараа үйлчилгээний зардал гээд дэлгэрэнгүй тайлан байхгүй. 300 гаруй тэрбум төгрөгийн борлуулалт, гүйлгээ хийгдсэн ийм мэдээллүүд байгаа. Аудитын дүгнэлтүүд төлөвлөгдөөгүй, бэлтгэгдээгүй, зураг төсөлгүй ажлууд хийсэн талаар ярилаа. 100% төсвөөс тэжээгддэг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд байна. Бодлого судалгааны төв, махны үйлдвэр байна. Төсвийн байгууллага биш хэр нь 100% төсвөөс тэжээгддэг ийм үйлдвэрийн газрууд хэрэгтэй юу? үгүй юу? гэдэг асуудлыг эргэж харах хэрэгтэй болж байна.

Маш олон төрийн өмчит, орон нутгийн өмчит компаниудын задаргаа байхгүй, гүйлгээнүүдийн цаана хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр захиалгат мэдээлэл

явуулдаг гэсэн мэдээлэл гарлаа шүү дээ. Гадуур нэлээн оло тооны мэдээллүүд явсан. Тэгэхээр энэ зүйл дээр ажлын хэсэг мэдээлэл цуглуулахаар холбогдсон. Асуулга явуулсан тэгээд НЗДТГ, НИТХ-аас мэдээлэл ирсэн. Нөгөө салбар, хараат өмчийн оролцоот компаниудын хүрээнд, түүгээр дамжиж ямар гүйлгээ хаашаа явж байна вэ? гэдэг талаар мэдээлэл цуглуулж хараахан дуусаагүй байгаа. Тэгэхээр энэ бүгд чинь эцсийн дүндээ маш том корпорацын хэлбэрт орсон байдлаа зөвтгөж хэвлэл мэдээллээр зөв, буруу нь мэдэгдэхгүй янз бүрийн мэдээлэл төлбөртэй цацдаг схем байгаа гэдэг тал дээр үргэлжлээд мэдээлэл цуглуулах шатандаа явж байна гэж гэдгийг бас хэлье.

Ингээд маргаашийн сонсгол 9 цагаас эхэлнэ. Маргаашийн үндсэн хоёр сэдэв бол Туул хурдны зам, Сэлбэ 20 минут гэсэн хоёр том төсөл байгаа. Туулын хурдны замын худалдан авалтын ажиллагаа хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөлүүд болон урьдчилаад явуулчихсан 500 тэрбум төгрөгөө олж чадах юм уу? үгүй юу? Сэлбэ дэд төв 12 мянган орон сууц төлөвлөж байгаад яагаад 8 мянга болчхов гэсэн асуудлуудыг маргааш хэлэлцэнэ. Холбогдох байгууллагын мэдээлэл, шинжээч нарын дүгнэлт танилцуулна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас болон шинжээчийн дүгнэлт, Зам, тээврийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам танилцуулга хийнэ.

Сонсголд оролцогчоор 69 хүн бүртгүүлснээс үг хэлэх хүмүүсийг өглөө бүртгэж аваад сонсгол үргэлжилнэ. Идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа. Өнөөдрийн сонсголын үйл ажиллагаа хаасныг мэдэгдье ээ. (алх цохив)

Тэмдэглэлтэй танилцсан:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
СОНСГОЛ ДАРГАЛАГЧ

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР